Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл 2013 он. 12 сар. №24 (058) www.mongolianeconomy.mn

Евро бүсийн “сүүдэр” Хятадад

Л.Дулмаазул: SMBC Монголын том төслүүдийг сонирхоно

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭ АЛСЫН ХАРАА



САММИТ КОМПЬЮТЕР ТЕХНОЛОГИ ХХК

Мэдээлэл технологийн салбарт тэргүүлэгч

PC mall

summit
computer technology

ШИНЭ ЖИЛИЙН МЭНД ХҮРГЭЕ!







DELL The power to do more · SAMSUNG Turn on tomorrow · Apple · hp invent · Haier Inspired Living · EPSON EXCEED YOUR VISION · BOSE Better sound through research. · NOKIA Connecting People

IDTECK · CASIO · lenovo · ACTi Connecting Vision · SHARP · ELKO · ORIENT · BOSCH

7011-3535

Join us on Facebook
http://www.facebook.com/PCmallOfficial

Visit us:
www.summit.mn

AERO MONGOLIA
The Leading National Airline

ШИНЭ ЖИЛИЙН БЭЛЭГ БОЛГОН БҮХ ЧИГЛЭЛИЙН НИСЛЭГТЭЭ

25% OFF

ХЯМДРАЛ ЗАРЛАЛАА



33-03-73

www.aeromongolia.mn

АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬЮТОР

The power to do more

БАТАЛГААТ 3 PC SERVICE ЖИЛ ХУГАЦАА



ШИНЭ ЖИЛИЙН

УРАМШУУЛАЛТ ХУДАЛДАА

3-ЫГ АВБАЛ 3%

5-ЫГ АВБАЛ 5%

ХЯМДАРНА

PC mall®
СҮЛЖЭЭ ДЭЛГҮҮР

www.pc-mall.mn

7011-3535, 7012-3535

IKH KHARANGA



1сек
35.000-50.000₮

Реклам сурталчилгаа тв шторк



Алban байгууллага
хамт олны
шинэ жилийн арга
хэмжээ болон
видео мэндчилгээг
чанарын өндөр
түвшинд
тус тус хийнэ.





Манай байгууллага нь
И-МЭЙЛ маркетингийн
ЦОГЦ
үйлчилгээг танд
санал болгож байна.

Харилцах утас:
7010-0156, 9111-6586

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800-6228/

ЕРӨНХИЙ РЕДАКТОР:
Б.Цогзаяабаатар /9919-0715/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ: Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:
Б.Баяртогтох
Э.Зоригт
Х.Хулан
Б.Үүрийнтуяа
Б.Бямбадорж

ДИЗАЙНЕР: Ш.Оюундарь
ВЭБ МАСТЕР: Н.Гал

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:
Д.Барианжав /9409-2904/
Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:
М.Хишигтогтох /9409-2906/

“ECONOMY” TB СТУДИ

РЕДАКТОР: Ж.Баяржаргал
ЗУРАГЛААЧ: Ш.Гантуул
КОМПЬЮТЕР ГРАФИКЧ: Т.Баярсайхан

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Шинэ оны босгон дээр сэтгүүлийнхээ 58 дах дугаараараа уншигч захиалагчидтайгаа учран золгож байгаадаа баяртай байна. Бид оны сүүлийн дугаартаа Монголын болон дэлхийн эдийн засагт өрнөсөн томоохон үйл явдлыг тоймлон дүгнэж, айсуй оны өнгийг тольдлоо. Өнгөрч буй онд Монголын эдийн засаг,бизнесийн амьдрал гялалзсан амжилт, таатай тоон үзүүлэлтүүдээр бялхам биш байсан ч “Mongolian Economy” сэтгүүлийн хувьд бичих сэдэв, хөндөх асуудал дүүрэн байлаа. Нэг жилийн хугацаанд бид хөрөнгө оруулалт огцом буурсан, нүүрсний үнэ навс унасантай холбоотой сэтгэл гонсойлгосон таагүй үйл явдлуудын талаар шинжлэн дүгнэж бичихээс гадна Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын VII бага хурал, “Монгол Давос”, “Салхит” салхин станц байгуулагдсан, төрийн тэргүүнүүдийн түүхэн айлчлал, түнш орнуудын хамтын ажиллагааны түүхт ой, Улаанбаатар хотын өнгө зассан байдал зэрэг хөрөнгө оруулалт-бүтээн байгуулалттай холбоотой сайн сайхан мэдээ мэдээллийн талаар ч сэтгүүлийнхээ нүүр, хуудаснаа томоохон зай талбай эзлүүлэн тод томруунаар дархлан үлдээж чадлаа. Тухайлбал, бид энэ оны эхэнд Давосын Дэлхийн эдийн засгийн чуулганд зориулж Гадаад хэргийн яамтай хамтран “The Ever-Growing Economy” гэсэн тусгай дугаар бэлтгэж 1000 ширхгийг Давост хүргэж, тарааж байсан. Түүнчлэн Монгол Их Британи улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан тусгай дугаарыг Монгол дахь Английн Элчин сайдын яамтай хамтран гаргалаа. Ийнхүү Монгол Улсыг, Монголын эдийн засгийг гадаад ертөнцөд сурталчилан таниулахаас гадна дотоодод улам бүр данхайж байгаа төр, бизнесийн орчин, бизнес дэх төрийн оролцоо их болж байгаа талаар хөндөн бичиж, олон нийтийн загтанасан газар нь маажиж чадлаа. Нэг үгээр хэлбэл, бид дотоод, гадаадын уншигчиддаа шинэлэг мэдээ мэдээлэл, мэдлэг өгөх үүргээ 2013 онд бүрэн дүүрэн гүйцэтгэсэн гэж хэлж болох юм.

Нөгөө талаас байгууллагынхаа хүний нөөц боловсон хүчнийг бэхжүүлэх, чадвахжуулах тал дээр багагүй амжилттай ажиллаа. Тийм ч учраас шинэ оны босгон дээр “Economy” TV студи ашиглалтад оруулж, удахгүй телевизээр нэвтрүүлгийнхээ цацалтаа хийхэд бэлэн болсныг дуулгахад таатай байна. Мөн бид ирэх онд сэтгүүлийнхээ нийтлэлийн бодлого, чанар чансааг дээшлүүлэх чиглэлээр нэлээд ажлыг хийхээс гадна www.mongolianeconomy.mn цахим хуудасныхаа мэдээллийн чанар, хурдад ч хувьсгал хийхээр төлөвлөн ажиллаж буй.

Үүсгэн байгуулагдаад гурав дахь жилтэйгээ золгох гэж буй “Mongolian Economy” сэтгүүлийнхээ оюунлаг-ажил хэрэгч захиалагч уншигчдадаа ирэх ондоо эрүүл энх, ажил үйлс нь бүтэмжтэй байхын ерөөлийг өргөн дэвшүүлье

ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ И.ОТГОНЖАРГАЛ

“Mongolian Economy” сэтгүүлийн шинэ оны нэгдүгээр улирлын захиалга явагдаж байна.

http://mongolianeconomy.imedia.mn/

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ



Б.БЯМБАСАЙХАН Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн



Б.БОЛД
“Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажилллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч



С.БЭХБАТ
ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга



Д.ЖАРГАЛСАЙХАН
МІН группын ерөнхийлөгч



Ц.БАТСҮХ
СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч



Ж.СҮНЖИДМАА
“Пийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер



Б.ТҮВШИНТӨГС
Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

ХАЯГ:
Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг. VI хороо,
Их сургуулийн гудамж. AB center. 503 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Фреско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mall" салбарууд

АГУУЛГА

ЭДИЙН ЗАСАГ

12 Таагүй жилийн тааламжтай угтал

14 “Mongolianeconomy” сэтгүүлийн асуулт

16 Оны онцлох 10 үйл явал

22 Евро бүсийн “сүүдэр” Хятадад

24 ОХУ-ын эдийн засгийн 2013 оны тойм

28 Төсөвт ийм эрсдэл байна

30 Зэс шинэ рекорд тогтоох уу

32 Дорно зүгийн охин

34 Ойг дэд бүтцийн эдийн засгийн нэг хэсэг болгон үзэх нь

БИЗНЕС

36 Л.Дулмаазул: SMBC Монголын том төслүүдийг сонирхоно

39 Хувьцааг хямдхан гаргах арга зам

40 Эсгий ертөнцөөр аялахад

44 Хэвшлийг хэт эвдэх хөгжлийн 10 таамаг

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ТВ ХУВИЛБАР



Манай сэтгүүлийн үнэнч уншигч та бидний уран бүтээлийг мөн телевизээр үзэх боломжтой боллоо.

“Economy” ТВ студи улс оронд тулгарсан бүхий л асуудал, иргэн, бизнесмэнийг эмзэглүүлсэн аливаа сэдвийг цуврал нэвтрүүлэгтээ шууд хөндөн, шууд нэвтрүүлнэ. Тиймээс анхны бүтээл болох “”Зантгар төр” нэвтрүүлэг олны хүртээл болгох гэж байна.

“ЗАНТГАР ТӨР” нэвтрүүлэг
Гарах телевиз: NTV
Гарах өдөр: Ням гариг, 2013.XII.22
Гарах цаг: 21.40

Уншигчдийн маань мэргэн дүгнэлт, үзэгчдийн минь онч үгс бидний бүтээлд том дэм болох билээ.

МОНГОЛД

ДНБ

Ирэх онд эдийн засаг илүү дээрдэнэ гэдгийг гадаад дотоодын зарим эдийн засагч хэлж байгаа. Тухайлбал, ирэх онд Монгол Улсын ДНБ-ий өсөлт 15.3 хувьд хүрэх талаар “The Economist”-д дурдсан байна. Түүнчлэн Дэлхийн банкны тооцоолсноор ирэх онд манай ДНБ мөн л хоёр оронтой тоогоор өсөх төлөвтэй байгаа юм.

Төсөв

Нийслэлийн ирэх оны төсөв төвлөрлийг сааруулах. Мөн иргэдийн амьдрах орчин нөхцлийг сайжруулахад гол агуулга нь оршиж буй. Ирэх оны нийслэлийн төсөвт төвлөрөх орлого 556.9 тэрбум төгрөг. Энэ нь 2013 оны төсвөөс 108.7 тэрбум төгрөгөөр илүү юм. Өөрөөр хэлбэл, орлогын төлөвлөлт 24.3 хувиар өссөн гэсэн үг. Орлогын 65.9 хувийг Хувь хүний орлогын албан татвараар бүрдүүлэх аж. Харин үлдэж буй хэсгийг бусад нэр төрлийн татвар болон татварын бус орлогоор тооцжээ. Ирэх онд нийслэл төсвийн орлогынхоо 1.3 хувийг өмч хувьчлалын орлогоос олох юм байна.

Хөрөнгө оруулалт

Энэ оны эхний хагасын байдлаар бүртгэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оныхоосоо даруй 43 хувиар буурсан үзүүлэлт гарсан. Мөн өнгөрсөн 10 дугаар сард гаднынхан Монгол руу хөрөнгө оруулах бус, манай улсаас гадагшаа хийсэн хөрөнгө оруулалт нэмэгдсэн үзүүлэлт гарчээ. Харин ирэх онд Монгол руу орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэдэг хүлээлт байна.

Хэрэглээ

Ирэх онд уул уурхайн олборлолт нэмэгдэж байгаатай холбоотойгоор түлш, шатахууны хэрэглээ нэмэгдэхээр байгаа. Мөн барилга, орон сууц, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг дагаад барилгын материалын импорт өснө. Нийт импортын хэмжээ 2014 онд 6.7 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны алдагдал 500 орчим сая ам.доллар болохоор төлөвтэй байна.


Ажлын байр

Засгийн газраас энэ онд улсын хэмжээнд 50 мянган шинэ ажлын байр бий болгохоор төлөвлөн ажиллав. Энэ хүрээнд “Ажилтай, орлоготой Монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Үр дүнд нь энэ онд Монгол Улсын эдийн засгийн идэвхтэй хүн ам 1.17 саяд, ажиллах хүчний оролцооны түвшин 63.8 хувьд, ажилгүйдлийн түвшинг 7.7 хувьд тус тус хүрэх төлөвтэй байна. Ажиллагсдын тоо 2013-2016 онд жилд дунджаар 2.0 хувиар өсч, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 34-35 мянга орчим байх аж.

Жижиг, дунд үйлдвэрлэл

Өнгөрсөн аравдугаар сарын байдлаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 5549 аж ахуйн нэгж байгууллага. Мөн иргэдээс ирсэн төслийг шалгаруулж нийт 489.5 тэрбум төгрөгийн зээл олгожээ. Уг зээлийн үр дүнд нийт 26492 ажлын байр шинээр бий болсон байна. Үүнээс 17365 ажлын байр нь эдийн засагт хадгалагдаж үлджээ. Мөн 47.5 тэрбум төгрөгийг бүс нутгийн зээлд олгосон байна. Бүс нутгийн хэмжээнд олгосон ихэнх зээлийн хэмжээ нь 100 сая төгрөгөөс дээш байжээ.

Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт (хувиар)




Эх сурвалж: ЭЗХЯ

Эдийн засгийн өсөлт

Ирэх онд Монгол Улсын уул уурхайн бүтээн байгуулалт дахин хүчээ авах төлөвтэй байна. Тухайлбал, Оюутолгойн зэс-алтны ордын үйлдвэрлэл 2014-2016 онд 2013 оныхоос 2-3 дахин нэмэгдэж, Тавантолгойн Баруун болон Зүүн цанхийн олборлолт эрчимтэй явагдана. Мөн газрын тос, төмрийн хүдрийн олборлолт ч нэмэгдэх хандлагатай байна.


Нүүрсний экспортын хэмжээ (сая.тонн)



Эх сурвалж: YCX

ДЭЛХИЙН ДАХИНД

АНУ



АНУ-ын ажилгүйдлийн түвшин 2008 оноос хойш хамгийн бага буюу долоон хувь болж буурав. Өнгөрсөн сард хөдөө аж ахуйгаас бусад салбарт 203 мянган хүн шинээр ажилтай болсон талаар тус улсын Хөдөлмөрийн яам мэдэгджээ. Барилгын салбарт 17 мянган хүн шинээр ажилд орж, өмнөх сарынхаас 42 хувиар өссөн байна. Энэ нь орон сууцны зах зээл сэргэж, хэрэгцээ нь нэмэгдсэнтэй холбоотой аж. Аж үйлдвэрүүдэд 27 мянган хүн шинээр ажилтай болж, сүүлийн 20 сард байгаагүй өндөр үзүүлэлттэй байв.

Япон

Японы бизнес эрхлэлтийн индекс сүүлийн гурван сард илт сайжирчээ. Энэ нь сүүлийн зургаан сард байгаагүй өндөр үзүүлэлт болохыг тус улсын Төвбанкнаас хийсэн судалгаа харуулж буй. Ерөнхий сайд Шинзо Абэгийн “Абэномикс” гэх бодлого нь эдийн засагт өргөн тархжээ. Төвбанкны “Танкан” судалгаанд уг бодлого зөвхөн том компанид бус, мөн жижиг компаниудад үр ашгаа өгч буйг дурдсан байна. Жижиг үйлдвэрлэгчдийн сентимент нэмэгдэж, индекс эерэг үзүүлэлттэй гарчээ.




Герман



Германы парламентийн доод танхимын санал хураалтаар Ангела Меркель гурав дахь удаагаа канцлераар улиран сонгогдсон байна. Тэрбээр шинэ Засгийн газраа байгуулж, эрх мэдлийг гартаа авах боломж бүрджээ. Түүний Засгийн газар цөмийн эрчим хүчнээс сэргээгдэх эрчим хүч рүү шилжих бодлого барьж буй. Энэ өртөг ихтэй шилжилтийн үйл явцыг хэрхэн гардан явуулахыг өрсөлдөгч Социал демократ намынхан ажиглаж байна. Мөн Европын орнуудыг цаашид хямралаас хамгаалахад чиглэсэн реформыг улам бататгах ажилд идэвхтэй оролцох аж.

ОХУ

ОХУ-ын “Газпром” компан ирэх онд зарцуулах хөрөнгө оруулалтын үнийн дүнгээ 20 гаруй хувиар бууруулжээ. Энэ талаар тус улсын Ерөнхий сайд Дмитрий Медведев мэдэгдэв. Дээрх компанийн 2014 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 1.03 их наяд рубль байсныг 800 тэрбум рубль болгон бууруулжээ. Энэ талаар Wall Street Journal сэтгүүлд нийтэлсэн байна. ■



БНХАУ



БНХАУ нь Япон, БНСУ-тай хамтран Зүүн Азид тулгараад буй агаарын бохирдолтой тэмцэх уулзалт, хэлэлцээрийг Бээжингтэй ойролцоо орших Шианге хотод хийжээ. Энэ нь экологийг сайжруулахад чиглэсэн тогтвортой хөгжлийг нэмэгдүүлэх зорилготой аж. Хэлэлцээрт оролцогчид тогтвортой хөгжлийн төлөө хамтран ажиллана гэдгээ харилцан илэрхийлжээ.

А.АМАРСАЙХАНЫ БУЛАН



ОНЦЛОХ

ТААГҮЙ ЖИЛИЙН ТААЛАМЖТАЙ УГТАЛ

И.ОТГОН

Монгол Улс нийгэм, эдийн засгийн хувьд хатуухан нэгэн оныг үдэж байна. Гадаадын хөрөнгө оруулалт гадаад, дотоод шалтгааны улмаас огцом багассан, төсвийн орлогын голыг нугалдаг байсан нүүрсний үнэ шалдаа бууж, экспорт нь бараг зогсоход хүрсэн, Оюутолгойн далд уурхайн санхүүжилтийн асуудал удтал гацаанд орсон, валют тэр дундаа ам.долларын ханш хагас жилээс хойш тасралтгүй өссөөр оны сүүлийн сарын эхэн гэхэд бүр 1740 төгрөгийг хол давсан зэрэг тодорхой шалтгаануудаас улбаалж 2013 оны эдийн засгийн амьдрал базаахгүй үзүүлэлттэй гарч байна. Ялангуяа өнгөрч буй оны эхний улиралд зөвхөн Монгол төдийгүй дэлхийн эдийн засаг таагүй мэдээллүүдээр бөмбөгдүүлсэн хэцүүхэн цаг хугацаа байсан гэж хэлж болно. Учир нь 2008-2009 оны хямралаас хойш дэлхийн эдийн засаг бүрэн сэргэж амжаагүй байтал 2010 оноос Европын Холбооны өрийн хямрал эхэлсэн, 2011 онд АНУ-д төсвийн асуудал үүссэн, 2012 онд Хятадын эдийн засгийн удаашрал гээд дэлхийн эдийн засгийн дээрх он дараалсан таагүй байдал дэндүү бачимдмаар байлаа. Ийм сайнгүй суурин дээр айлчилсан 2013 оны эхэн үед байдал бүр ч эвгүйдэх шинжтэй байсан юм. Харин мөн оны II улирлаас хөгжингүй эдийн засгуудын индикаторууд боломжийн гарч эхэлсэн нь цаг уярах шинжийг бэлгэдсэн. Гэхдээ л манай уул уурхайн түүхий эдийн гол импортлогч болох урд хөршийн эдийн засагт зуны дэлгэр цагт ч нар наашлаагүй л байлаа. Түүнчлэн нүүдлийн шувууд буцах намартай зэрэгцэн болдог “Discover Mongolia” уул уурхайн хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт 11 дэх жилээ хамгийн цөөхөн оролцогчидтой болсон төдийгүй спонсор ч олдоогүй нь тун санаа зовоосон хэрэг байв. Энэ нь нэг талаас дэлхий нийтэд од болон гялалзаж байсан уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хумигдаж, тэр дундаа нүүрсний үнэ огцом буурсантай холбоотой байсан. Нөгөө талаас Монголын улс төрийн тогтворгүй байдал, тодорхой бус шийдвэр болон Стратегийн салбар дахь хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай



хууль батлагдсантай холбоотойгоор хөрөнгө оруулагчдыг нүүр буруулахад хүргээд байв. Нэг үгээр, өнгөрсөн оны намар гэхэд хөрөнгө оруулагчид Монголд дахин эргэж ирэх үү, үгүй юу гэдэг том асуултын тэмдэг урган гарсан. Үүний урхагаар гадаадын шууд хөрөнгө оруулалт 40 гаруй хувиар буурч, шинэ хөрөнгө оруулалт бараг хийгдсэнгүй. Мөн Оюутолгойг тойрсон асуудал гацсан хэвээр бүтэн оныг үдэж байгаа нь эдийн засагт сайнгүй юм.


Мөн 2013 оны Нэгдсэн төсвийг хэт өөдрөг төсөөлсөн нь эдийн засагт томоохон ачаа болсон талтай. Тухайлбал, ▸▸

2013 оны төсвийг батлахдаа ДНБ-ийг 18.5 хувиар өсөн гэж тусгасан бол оны эхний хагас жилийн байдлаар эдийн засаг ердөө 11.3 хувиар тэлсэн байна.

Үүнээс гадна дээрх төсөвт төсөвлөснөөр 28 сая тонн нүүрс экспортлох ёстой байсан ч энэ үзүүлэлт 16 сая тонныг экспортолж нэг тэрбум ам.долларын орлого олоод буй тухай шинэхэн статистик мэдээлэл гараад байна. Хариугүй он дуусах гэж байгаа учраас эл тоо нэмэгдэх нь юу л бол.

Дараагийн эдийн засаг дахь оны таагүй үзүүлэлт бол мэдээж удаан хадгалагдсан ам.долларын ханшийн өсөлт. Импортод суурилсан эдийн засагтай орны хувьд ам.долларын ханшийн өсөлт удаан хадгалагдах нь бизнес эрхлэгчдийг дарамтад оруулаад зогсохгүй аажимдаа инфляци өсөхөд нөлөөлөв. Монгөний бодлогын хүрээнд Монголбанк инфляцийг нэг оронтой тоонд барих зорилт тавин ажиллаж буй. Гэсэн хэдий ч энэ оны долдугаар сард 8.3 хувьтай гарсан инфляци алгуур өссөөр арваннэгдүгээр сард 12 хувийн өсөлттэй гарсан нь Төвбанкны том зорилт үзэгдээд өнгөрөх төдий байлаа. Гэхдээ 2012 оны 14.2 хувьтай харьцуулахад бол буурсан үзүүлэлт. Ийн бууруулахын тулд Монголбанк багагүй хүчин чармайлт гарган ажиллаж байгаа. Тухайлбал, 2012 оны сүүлээс Монголбанк, Засгийн газар хамтран “Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийг” хэрэгжүүлж эхэлсэн нь инфляцийн нийлүүлэлт талд тусгайлан анхаарсан хэрэг юм. Энэ хүрээнд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах, барилгын материалын гол нэрийн үйлдвэрлэлийг дэмжих, орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох зэрэг бодитой ажил хийсэн нь богино болон дунд хугацаанд үр дүнгээ өгснийг тэмдэглэх хэрэгтэй. Гэхдээ эдийн засагчдын үзэж буйгаар тус хөтөлбөрийн хүрээнд инфляцийг / мах, гурил, шатахууны үнийг / барьж байгаа боловч макро эдийн засгийн үзүүлэлтүүд инфляцийг урт хугацаанд нэмэгдүүлэх төлөв ажиглагдаж байна хэмээн үзсэн нь оны төгсгөлд

Инфляци (жилийн өсөлт)



Эх сурвалж: Монголбанк

биелэлээ олж байх шиг.

Харин эрэлт талын хүчин зүйлийн тухайд өмнөхийг бодвол инфляцийг хөөрөгдөх нөлөө харьцангуй бага байв. Тухайлбал, төсвийн тэлсэн бодлого хумигдсан, бэлэн мөнгө тараах байдал танагдсан, цалин хөлсний дундаж нэмэгдэл бага байсан зэргийг нэрлэж болно. Мөн макро эдийн засгийн бодлогын хүрээнд инфляци буурсантай холбоотой Төвбанк бодлогын хүүгээ гурван ч удаа бууруулж 10.5 хувь болгосон нь банк хоорондын хүүгийн түвшин болон Монголбанкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү буурахад эерэг нөлөө үзүүлсэн байна. Эцсийн дүнд ам.долларын ханшийн өсөлтөөс улбаалан өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт гаарсан дүнтэй шинэ оныг угтав. Ирэх он жилүүдэд валютын ханш инфляцид нөлөөлдөггүй Монгөний бодлого хэрэгжүүлэх үндэс суурь тавигдсан талаар УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл онцлон хэлжээ. Тийм бол сайн л байна.

2013 оны эдийн засаг дахь таагүй үзүүлэлтийг тоймлон дүгнэхэд ийм ч барилгын салбарын өсөлт маш сайн байсан төдийгүй олон мянган өрх ипотекийн найман хувийн зээлийн хүрээнд орон байртай болсон сайхан мэдээ бий. Харамсалтай нь дээрх найман хувийн зээлээс хамааран орон сууцны үнэ энэ оны зургаагаас наймдугаар сар хүртэлх хугацаанд 12-28.7 хувийн огцом өсөлт үзүүлсэн таагүй мэдээ ч бий. Мөн оны сүүлийн хагаст хөрөнгө оруулалтын тухай хууль баталж гаднын хөрөнгө оруулагчдыг эргүүлэх эерэг сэтгэгдэлтэй болгож чадсан нь сайн зүйл. Түүнчлэн Монгол Улсын эрчим хүчний салбарт сүүлийн 30 жилд хийгдээгүй том бүтээн байгуулалт болох “Салхит” салхин цахилгаан станцыг байгуулсан нь мэдээж эдийн засагт гэрэл гэгээ авчирсан сайн мэдээ. Чингис бонд болон Хөгжлийн банкны бондтой нийлээд хоёр тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын ачаар эдийн засгийг харин ч танагтай авч гарлаа хэмээн Төвбанкны ерөнхийлөгч тэргүүтэй холбогдох албаныхан онцлон хэлэх дуртай. Гэтэл нөгөө талд ийм их хэмжээний өр үүсгэж, түүнийгээ урт хугацаанд ашиг өгөх бүтээн байгуулалтад зарцуулж байгаа нь монголчуудыг өрийн дарамтад оруулж байна гэсэн шүүмжлэл өрнөсөн. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ч “Том төрөөс ухаалаг төр луу” хэлэлцүүлэг чуулганыхаа үеэр Засгийн газрыг бонд босгож өр тавих их дуртай байна хэмээн шүүмжилсэн удаатай. Тэрбээр ухаалаг төр луу шилжих хөтөлбөрийнхөө хүрээнд гаргах

Оны үнээр илэрхийлсэн ДНБ-ий хэмжээ, эдийн засгийн бодит өсөлт, хувиар



Эх сурвалж: Сангийн яам

хуулиудын дотор Өрийн удирдлагын тухай хууль гаргахаа ч мэдэгдсэн.

Засгийн газар Чингис бондоор босгосон 1.5 тэрбум ам.долларaa төсөвт суулгалгүй Хөгжлийн банкаар дамжуулан томоохон төслүүдэд хөрөнгө оруулалт хийсэн. Тус банкнаас гаргасан төсвөөс гадуурх нийт зарлага 2013 онд ДНБ-ий 10 орчим хувьд хүрэхээр байгааг Дэлхийн банк тооцсон. Бондын мөнгийг ийнхүү төсвөөс гадуур зарцуулах нь зүйд нийцэхгүйг олон улсын байгууллагынхан болон мэргэжилтнүүд шүүмжилдэг. Хэрвээ үүнийг төсөвт багтааж тооцвол энэ оны төсвийн алдагдал ДНБ-ий 12 хувьд хүрэхээр байгаа юм. “Монгол Улсын төсвийн алдагдал тус бүс нутаг дахь хөгжиж буй орнуудтай харьцуулахад онцгой өндөр байна” гэж Дэлхийн банк анхааруулсан.

Харин 2014 оны нэгдсэн төсвийг 6.9 их наяд төгрөгийн орлого, 7.3 их наяд төгрөгийн зарлага, 409.9 тэрбум төгрөгийн алдагдалтай, эргээд тодотгох нөхцөлтэйгээр баталсан. Засгийн газар энэ оны төсөвт дэд бүтцийн төслүүдээ хайр найргүй таначихсан. Жишээлбэл, улсын төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтыг 318 тэрбум төгрөгөөр багасгажээ. Дээр нь УИХ төсөвт өртөг нэмэгдсэн гэсэн шалтгаанаар 144 объектыг царцаах шийдвэр гаргасан /Энэ жагсаалтад олон тооны цэцэрлэг, сургууль багтсаныг үл харгалзан санхүүжилтийг тэглэв/.

Бонд гаргах замаар бүтээн байгуулалтын том төслүүдээ үргэлжлүүлнэ гэж найдсан Засгийн газар хоёр оны зааг дээр санаснаа хийж чадлаа.

Ерөнхий сайд Н.Алтанхуяг өнгөрсөн есдүгээр сард Япон улсад айлчлал хийх үеэр Японы Засгийн газрын Олон улсын хамтын ажиллагааны банк Монгол Улсад найман тэрбум иенийн зээлжих эрх нээж байгаа болон Монголын Засгийн газрын бондод баталгаа гаргах боломжтойгоо илэрхийлэн хамтын ажиллагааны санамж бичгийг үйлдэж, хоёр тал гарын үсэг зурсан. Энэ нь өнгөрөгч сарын хоёр дахь долоо хоногт биелж, байдал тодийлэн дээрдэхгүй байх гэсэн таамаглалтай байсан айсуй оны эдийн засгийн өнгийг сэргээв. Сайн мэдээний сургаар урт хугацаанд өсч 1700 хол давсан ам.долларын ханш огцом буурав.

Удтал гацсан Оюутолгойн асуудлуудаар ч тодорхой мэдээлэл дуулдах цаг ойртсон бололтой. Ямар ч гэсэн Англи-Монгол хоёр улс дамжин үргэлжилсэн ТУЗ-ийн хурал 2014 оны төсвөө санал нэгтэй баталжээ.

Эцэст нь хэлэхэд таагүй жилийн тааламжтай угтал айсуй. Самурай бонд болон өнгөрсөн оны эдийн засгийн тойм, ирэх оны өнгийг илүү мэргэжлийн түвшний дүгнэлт судалгаатайгаар манайх удахгүй хүргэх болно. ■

“MONGOLIANECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

-Монголын эдийн засаг 2013 он ямар байв. Та ирэх оныг хэрхэн харж байна вэ?

Ц.Батсүх /СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч/



-Манай улсын хувьд 2013 он эдийн засаг талаасаа тодийлэн таатай байсангүй. Тэр тусмаа төсвийн орлого, хөрөнгө оруулалтаа авч үзэх юм бол эдгээр үзүүлэлт эрс буурлаа. Төсвийн алдагдал, зарим үйлдвэрлэлийн салбарын бууралтаас харж болно. Үүнд дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал нөлөөлсөн. Гэхдээ дотоодод макро эдийн засгийн удирдлага муу байгаагаас дээрх эрсдэл үүссэн. Гадаад зах зээл нийтдээ сүүдэртэй байсангүй. Зарим нэг сэргэлт гарсан. Гэвч үүний нөлөө манай уул уурхайн салбарын бүтээгдэхүүний борлуулалтад дорвитой өөрчлөлт авчирсангүй. Энэ нь манай улс олон улсын зах зээлд томоохон гэрээ хэлцэл хийж, нэвтэрч чадахгүй байгааг харуулж байгаа юм. Дүгнэвэд хэлэхэд хөдөө аж ахуйн салбар таатай. Харин уул уурхайн салбарт хатуурхсан жил боллоо. Төсвийн орлого тасарсан нь нүүрс гэхээс илүү төлөвлөлтийн алдаа гэж харж байгаа. Хэт өөдрөг орлогыг тооцсон нь төсөвт эрсдэл учруулсан. Ирэх жил дээрх нөхцөл байдал үргэжлэхийг үгүйсгэх аргагүй. Тиймээс шинэ онд эдийн засгийн өрсөлдөх чадварт дорвитой сэргэлт найдвар ажиглагдахгүй байна. Нөгөөтэйгүүр банк санхүүгийн салбар нэлээд эдрээтэй болох шинжтэй. Учир нь чанаргүй зээлийн хэмжээ эрс нэмэгдсэн. Дээр нь валютын ханш урьд байгаагүйгээр өссөн. Үүнээс үүдэн валютын албан нөөц багассан. Тиймээс үүний нөлөө ирэх жил гарч мэдэх юм. Ирэх жил валютын нөөцийг нэмэгдүүлэхэд нэлээд анхаарч ажиллах хэрэгтэй. Одоогийн байгаа албан ёсны нөөц нэмэгдэж чадахгүй бол ханш өсөх эрсдэл байгаа. Валютын ханшийн өсөлт нь бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөд нөлөөлнө. Ингэснээр Монголбанкны инфляцийг бууруулах зорилт хүссэн үр дүндээ хүрэхгүй байх хандлага байгаа.»

Б.Гарамгайбаатар /УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга/:



-Ирэх онд Оюутолгойн зэс, алтны ордын үйлдвэрлэл энэ оныхоос бараг хоёр дахин нэмэгдэж, олборлолт эрчимтэй явагдана. Түүнчлэн газрын тос, төмрийн хүдрийн олборлолт ч нэмэгдэх хандлагатай байна. Үүнтэй холбоотой эдийн засгийн өсөлт нэмэгдэж, макро эдийн засгийн өсөлт тэнцвэртэй байдлаа хадгална. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд Засгийн газраас инфляцийн түвшинг бууруулж, тогтворжуулах бодлого баримтлан үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн. Энэ хүрээнд бүтээгдэхүүний нийлүүлэлтийг дэмжиж, барилгын материалын импортыг бууруулж, дотоодод үйлдвэрлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр байгаа. Үүний үр дүнд инфляцийн түвшинг нэг оронтой тоонд барихаар төлөвлөөд байна. Тиймээс ирэх онд эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, улмаар өсөлтийг бататгах боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Б.Эрдэнэбат /МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор, судлаач/



-Статистик харах юм бол энэ онд ДНБ-ий өсөлт 12.5 хувь байхаар хүлээгдэж байгаа. Энэ бол маш өндөр тоо. Дэлхийн 200 гаруй улсаас толгой цохьсон үзэгдэл гэж хэлж болно. Гэхдээ өсөлтийн цаана хүртээмж хэр байсан гэвэл эерэг дүр зураг харагдахгүй. Манай улсын эдийн засгийн тооцоолол буруу болоод байгааг өмнө би хэд хэдэн удаа хэлж байсан. Тухайлбал, өрийн асуудал дээр нэгдсэн ойлголт алга. Нийгэм өөрсдөө тэгш хүртээмжийн тухайн хөндөхгүй байгаа. Энэ онд уул уурхайн салбарт нэг компани тоглогч байлаа. Тус компани манай гадаад худалдаанд томоохон хувь эзлэх болсныг илүү мэдэрлээ. Энэ нь Оюутолгой. Оюутолгойн далд уурхайн үйл ажиллагаа зогссонтой холбоотойгоор төгрөгийн ханш унах дарамтад орсон.

Нэг компанийн Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөө том болно гэдэг давхар эрсдэл юм. Эдийн засгийн таагүй байдал бидэнд багагүй зүйлийг бодитоор харахад хүргэсэн. Гэхдээ аж үйлдвэрийн салбар дахь хөрөнгө оруулагчдаа шахан гаргасан. Энэ нь гаднын хөрөнгө оруулалт буурахад сөрөг нөлөө үзүүлсэн. Төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотойгоор эдийн засагт төрийн оролцоо нэмэгдсэн. Энэ хэрээр хувийн секторыг шахан гаргах үзэгдэл хүчтэй ажиглагдлаа. ДНБ-д эзлэх хувийн хэвшлийн эзлэх хувь байнга буурсаар байна. Уг нь хувийн хэвшилд тулгуурласан эдийн засаг байсан. Гэтэл төрийн гарыг харсан эдийн засагтай болж байна. Аж ахуйн нэгжээс гадна банк санхүүгийн байгууллага төрийн гар харж амьдардаг хувийн сектор болон хувирч байна. Энэ бол сэтгэл түгшээх зүйл.

Ирэх он тодорхой бус байдлаар дүүрэн байна. Манай эдийн засгийн түшиц салбар хөдөө аж ахуй байгалийн эрхшээлд байсан. Тэгвэл одоо хоёр дахь тийм тодорхой бус эдийн засгийн хөдөлгөгч хүч нь уул уурхай болчихлоо. Уул уурхайн салбар нь дэлхийн түүхий эдийн зах зээлийн эрхшээлд орсон. Бид өөрсдийнхөө жолоодлогыг алдаж байна. Тиймээс улсаараа алсын хараатай, эдийн засгийн бодлого судалгаатай явах юм бол дээрх эрсдэлийг бууруулах боломжтой. Чанаргүй зээлийн хэмжээ таван сарын дотор хоёр дахин өссөн. Ам.долларын ханшийн өсөлт банкны үйл ажиллагаанд ч нөлөөлж мэдэхээр байна. Ам.доллараар гадаад эх үүсвэр татсан Хөгжлийн банк, Төрийн банк болон бусад байгууллагад гадаад валютын эрсдэлд орсон. Энэ нь ирэх онд нэлээд өсөх хандлагатай байна. Манайх 2017 оноос ам.долларын зээлээ төлж эхэлнэ. Үүндээ эртнээс бэлдэх ёстой. Энэ бол 2014 онд хийх ажлын нэг гэж бодож байна.

Тэхюн Ли /Дэлхийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газрын ахлах эдийн засагч/



-Монголбанкны зүгээс эдийн засагт ихээхэн хэмжээний төгрөг нийлүүлсэн. Ингэснээр төгрөгийн олдоц нэмэгдэж, валют хомсдох болсон. Үүнээс үүдэн төгрөгийн эсрэг ам.долларын ханш чангарсан. Энэ нь импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөд сөргөөр нөлөөлж, инфляци болж байна. Мөн банкны зээл олголт эрс нэмэгдсэн. Энэ нь санхүүгийн системийн тогтвортой байдалд эмзэг тусаж байгаа. Тэр тусмаа арилжааны банкуудын хувьд энэ байдал нь сөрөг үр дагавар авчирах эрсдэлтэй. Нөгөөтэйгүүр тогтолцоо эрүүл бус болж байгааг харуулж байна.

Төвбанк ихээхэн анхаарах хэрэгтэй. Мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхээс илүү ханш, инфляци, төлбөрийн тэнцэл энэ бүхнийг тэнцвэржүүлэх, тогтвортой байлгах нь чухал. Хөрөнгө оруулалтын тухай хуулийг энэ онд баталсан нь сайн хэрэг. Гэхдээ монголчууд тэвчээртэй хандах хэрэгтэй. Хууль баталсан ч хөрөнгө оруулагчид хүлээнэ харна, азнана. Хууль баталсан дор хөрөнгө оруулалт орж ирэхгүй. Ирэх онд эдийн засгийн өсөлт энэ хэрээр үргэлжлэх байх. Гэхдээ эрсдэл бол байгаа. Эмзэг байдал улам гүнзгийрэх магадлалтай. Тиймээс одоо л зөв бодлого хэрэгжүүлэх ёстой. Тооцоогүй үр дүн гарч ирж болзошгүй. Нийт эдийн засгийн өсөлт нь өндөр байгаа ч бүтцийг нь задлаад задаргааг үзэхээр тун онцгүй чиг хандлага анзаарагдаж байгаа. Өсөлтийг бүрдүүлж байгаа салбарын тоо улам хумигдаад үндсэндээ хоёр салбар байх жишээтэй. Энэ бол олон тулгуурт эдийн засгийн бүтэц биш. Дараагийн нэг зүйл бол өндөр өсөлттэй байхын төлөө л хүмүүс хэт их анхааралд байх шиг байна. Мэдээж бусад улсад хоёр оронтой өсөлт амжилт. Гэхдээ өсөлт бүхэн хөгжил биш гэдгийг санах нь зүйтэй. Үүнээс гадна Чингис бондын зарцуулалтаа эргэж харах ёстой. Ирэх онд төсвөө тодотгохоос илүү Төвбанкны хэрэгжүүлж буй үнийг тогтворжуулах хөтөлбөрийг зогсоох. Мөн Чингис бондын хүрээнд хэрэгжүүлж байгаа төслүүдэд ялимгүй таналт хийх эсвэл хойшлуулах арга хэмжээг авахад хангалттай. Энэ тохиолдолд төсөв тодотгох шаардлагагүй. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн нэг сул тал бий. Тус хөтөлбөр зогсох шийдвэр гарлаа гэхэд үнийн өсөлтийг дахин хөөрөгдөж мэдэх юм. Гэхдээ урт хугацааны эдийн засгийн тогтвортой байдлаа авч үлдэхийн тулд Засгийн газар зөв сонголт хийх ёстой.

Ч.Анхбаяр /Мандал даатгал компанийн эрсдэлийн удирдлагын ахлах шинжээч/:



-Энэ онд урсгал тэнцэл их алдагдалтай байна. Уг алдагдал нь гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсантай холбоотой үр дүн. Өмнө нь урсгал тэнцлийн алдагдлыг гадаадын шууд хөрөнгө оруулалтаараа нөхдөг байсан. Өөрөөр хэлбэл гадаадын шууд хөрөнгө оруулалтаас манай улсын валютын нөөц хэт хамааралтай гэсэн үг юм. Дээрээс нь валютын нөөцөд дарамт болох дотоод хүчин зүйлс байна. Тухайлбал, Монгол Улсын өрийн хэмжээ. Эдгээр өрийн хүрээнд Засгийн газар жилд дунжаар 195 сая ам.доллар төлөх учиртай. Дээрээс нь банк, томоохон компаниудын төлөх өрийн хэмжээг нэмбэл манай улс жилд дунджаар 770 гаруй сая ам.долларын нөөцийг цааш нь хийх шаардлага гарч ирж байгаа юм. Гэхдээ энэ бол ердөө л богино хугацаанд шүү дээ. Хэрвээ урт хугацаандаа төлөх өрийн хэмжээг нэмбэл өнөөдөр байгаа валютын нөөц хаанаа ч хүрэхгүй. Ирэх онд валютын нөөц багасах нь ойлгомжтой байна. Дээр нь гадаад валютын харилцах хадгаламж өссөн дүнг харьцуулж үзэхэд өнөөдөр Төвбанкинд байгаа валютын нөөц хаанаа ч хүрэхээргүй байгаа юм. Үүнтэй холбоотой валютын ханш өсөх магадлал их. Манай байгууллагын хувьд техникийн шинжилгээ хийснээр ханш 1920 хүртэл өсч магадгүй. Үүнтэй холбоотой ирэх онд инфляци 17.5 хувьд хүрч болзошгүй. Хэрвээ цаашид Төвбанкны зүгээс тодорхой арга хэмжээ авахгүй бол валютын нөөцөөс шалтгаалсан ханшийн өсөлт нь инфляцийг хоёр оронтой тоонд хүргэх гол шалтгаан болох юм. Өнөөдөр хөрөнгө оруулалтын байдал тодорхойгүй байна. Тиймээс ирэх онд шинээр баталсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийг олон улсад сайн сурталчлах хэрэгтэй. Тэгж чадвал хөрөнгө оруулагчдын хандлага сайжирна. Хэрвээ гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдвэл эдийн засагт учрах эрсдэл буурна.

Др. Штефан Ханзельманн /ЭТИС болон БНЭЗДХ-ийн захирал/:



-2013 он зөрчилдөөн, маргаантай асуудлаар дүүрэн жил байлаа. Нэг талаас сүүлийн нэг жил зургаан сарын хугацаанд гаднын хөрөнгө оруулагчдын сентимент богино хугацаанд муудсан. Үүнийг Засгийн газар ч хүлээн зөвшөөрсөн байх гэж бодож байна. Тэдний итгэлийг дахин олж авахын тулд төр, засгийн зүгээс ихээхэн хичээл зүтгэл гаргаж, Хөрөнгө оруулалтын тухай шинэ хууль хүртэл батлав. Мөн Гаднын хөрөнгө оруулалтыг дэмжих газар шинээр байгуулагдсан.

Нөгөө талаас Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон уул уурхайн салбар дахь үндэсний хэлэлцүүлэг зэрэг чухал асуудлууд хүлээгдсээр л. “Рио Тинто”, “Оюутолгой” компаниудад шинэ удирдлага томилогдсон. Гэвч зарим асуудал шийдэгдээгүй хэвээр байна.

Санаа зовоосон өөр нэг зүйл бол макро эдийн засгийн суурь муудсан асуудал. Үүнд төгрөгийн ханшийн сулрал, улсын өр нэмэгдсэн, Төвбанкны нөөц хурдацтай багассан, инфляци нэмэгдсэн зэрэг

багтана. Мөн эдийн засгийн уналтад маш өртөмхий салбар болох орон сууцны зах зээлд хүмүүсийг ихээр татан оролцуулсан ипотекийн хөтөлбөр. Үүнд Засгийн газраас дэмжлэг үзүүлсэн. Ингэснээр найдваргүй зээлийн хэмжээ нэмэгдэх болов. Түүгээр ч зогсохгүй BRIC-ийн орнууд тэр дундаа БНХАУ-ын эдийн засгийн өсөлт тааруухан байгаа. Энэ нь Монголын зах зээлд сөргөөр нөлөөлж, үнийн уналт болон зогсонги байдал үүсгэж, хангамжийн илүүдэл үүсгэх хандлагатай байна.

Барилгын салбарын хувьд өөдрөг дүр зураг харагдаж буй. Гэвч Монголын эдийн засаг энэ онд ихээхэн дарамтад орсон. Энэ нь ч эдийн засгийн эрүүл мэнд муудаж буйг харуулж байгаа хэрэг.


Энэ онд хэрэгжүүлсэн олон арга хэмжээ бүгд ирэх онд үр ашгаа өгөхгүй нь ойлгомжтой. Хөрөнгө оруулагчдын итгэлийг шууд сэргээх боломжгүй. Уул уурхайн салбар ч гэсэн өнгөрсөн жилүүдэд байсан шиг огцом өсөлт гаргахгүй байх. Ирэх он бол эргэлтийн гол тулах цэг байж болох юм. Тиймээс ч ирэх оны бүх үйл явдал хамтдаа нэгдсэн байдлаар амжилтыг авчрах байх гэж бодож байна. Японы Засгийн газрын дэмжлэгтэйгээр гаргаж буй Самурай бонд, мөн Dimsum бонд нь Монголын санхүүгийн ган гачигтай он жилүүдэд тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх байх. Гэхдээ энэ хөрөнгийг үндэсний баялаг бүтээх зэрэг зүйлст ашиглаж, сайн хөрөнгө оруулалт болгох шаардлагатай юм. Засгийн газраас дэмжлэг үзүүлж буй ипотекийн зээлийн хөтөлбөр эдийн засгийн өсөлтийн хэмжээг нэмэгдүүлнэ. Гэхдээ энэ нь хөрөнгийг буруу газарт байршуулж буй хэрэг юм. Төсвийн нэгтгэл байхгүйгээс эдийн засгийн байдал ирэх онд ямар байх нь тодорхойгүй. Төгрөгийн ам.доллар болон евротой харьцах ханш хувийн хэрэглэгчид, хувийн хэвшлийнхэнд тэр дундаа жижиг, дунд хувийн хэвшлийнхэнд маш сөрөг нөлөө үзүүлэх талтай. Учир нь том компаниудыг бодвол жижиг компани, үйлдвэрийн үйл ажиллагаа хязгаарлагдмал. Энэ нь дотооддоо ашиг багатай үйл ажиллагаагаа ашигтайгаасаа нөхөн сэлбэх ямар ч боломжгүй хэрэг. Нөгөө талаас бараа, бүтээгдэхүүнийхээ үнийг нэмэх боломжгүй байдагтай нь холбоотой.

Түүнчлэн бүх зүйлийг ор үндсээр нь өөрчлөх боломжтой өөр нэг гол хүчин зүйл бий. Энэ бол “Оюутолгой” төслийн талаарх “Рио Тинто”-той хийсэн хөрөнгө оруулалтын гэрээ болон тус компанийн хөрөнгө оруулагч хэлбэрээр дахин хүртэх ашгийн асуудал. Эсвэл энэ тал дээр маш хүчтэй гаднын өөр түнштэй хөрөнгө оруулалтын гэрээ хийж болох. Хэрэв ирэх оны эхээр үүнийг хийж чадвал энэ нь эдийн засгийн сэргэлтийн гараа болох сайхан боломж юм. Гаднын шууд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад чиглэсэн Засгийн газрын хичээл зүтгэл, зориулалтыг ажил хэрэг болгож чадвал Монгол Улс олон улсын компаниудын хувьд нас бие гүйцсэн, бодитой, прагматик байдлаар хөгжих боломжтой. ■

ОНЫ ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ

2013 онд Монголд улс төр, эдийн засаг, бизнесийн хол ойрын үйл явдал буцалсан өрнүүн амьдралын жил байлаа. “Mongolian Economy” сэтгүүл эдийн засгийн салбарт өрнөсөн үйл явдлыг тоймлон Оны онцлох 10-ыг нэрлэж байна.

1. Айлчлалын үр дүн



Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг энэ онд БНХАУ болон Япон улсад айлчилсан. Ерөнхий сайдын урд хөршийн айлчлал хоёр орны эдийн засагт үүсээд байсан саад тотгорыг арилгасан гэж дүгнэж болох юм. Өөрөөр хэлбэл, нүүрсний салбарт тулгамдсан асуудлыг шийднийг онцлохоос өөр яах вэ. Монгол Улс Хятадад нэг тэрбум тонн коксжих нүүрсийг 20 жилийн хугацаанд нийлүүлнэ. Ингэснээр 50 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг дунд хугацаанд татах болсон нь эдийн засагт нааштай мэдээ байв. Урт хугацаанд Тавантолгойн бүлэг ордоос олборлох нүүрсийг тээвэрлэх. Ложистикийн болон зах зээлийн өргөн боломжийг нээсэн нь хөршийн харилцаанд шинэ алхам боллоо. Мөн цаашдаа хүрэн нүүрс нийлүүлэх 20 тэрбум ам.долларын санамж бичиг үзэглэсэн нь дээрх харилцааг улам гүнзгийрүүлж байгаа юм.

Айлчлалын хүрээнд хоёр орны ирэх 20 жилийн харилцаа, хамтын ажиллагааг тодорхойлсон. Энэ нь Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөрийг баталсан явдал байв.

Мөн Ерөнхий сайдын Японд хийсэн айлчлалын үр дүнд оны өмнөхөн “Самурай” бондыг Монголын Засгийн газар гаргаж чадлаа.

Харин Ерөнхийлөгч төрийн гадаад бодлогын

харилцааг өргөжүүлэхээр цөөнгүй оронд айлчлал хийсэн. Тухайлбал, хаалттай гэж хэлж болох БНАСАУ-д айлчилсан нь дэлхийн нийтийн анхаарлын төвд байв. Тус айлчлалын хүрээнд манай Ерөнхийлөгч Хойд Солонгостой хөдөө аж ахуйн салбарт хамтарч ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн юм. Үүнээс гадна БНАСАУ-ын Кесон дахь аж үйлдвэрийн цогцолборт хөрөнгө оруулан хамтран ажиллах боломжийг судлахаар болсон нь айлчлалын гол яриа хэлцлийн нэг байв. Түүнчлэн Ерөнхийлөгч Зүүн Өмнөд Азийн зарим оронд төрийн айлчлал хийсэн нь улс төрийн тэдийгүй эдийн засгийн харилцаанд шинэ имиж болсныг тэмдэглэж буй. Төр, засгийн тэргүүнүүдийн эдгээр айлчлалыг эдийн засгийн агуулга, өгөөжид нь үндэслэн манай сэтгүүл онцолж байна.

2. Нэр хүндийн илэрхийлэл

Улирч буй 2013 онд Монгол Улс олон улсын хурал зөвлөлгөөн, зочид төлөөлөгчдийн хөлд дарагдсан. Тухайлбал, АОХН-ийн сайд нарын VII бага хурлыг Монголд анх удаа зохион байгуулсан. Бага хуралд 100 гаруй орны 1300 орчим төлөөлөгч оролцож, дэлхий дахины ардчиллын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлаар санал солилцож, шийдвэр гаргасан юм. Монголчуудын хувьд ийм өндөр дээд хэмжээний олон улсын хурал, зөвлөлгөөн зохион байгуулж, төдий тооны зочдыг нэг дор хүлээн авч байсан удаагүй. Тиймээс энэ үйл явдал 2013 оны онцлох үйл явдлын нэгд зүй ёсоор тооцогдох нь мэдээж. Тус хурлын дараа олон улсын хэд хэдэн хурал, зөвлөлгөөн Улаанбаатар хотод шил дараалан болсон. Өнгөрсөн есдүгээр сард гэхэд “Давос Монголд” арга хэмжээ болж “Монгол Улсын хөгжлийн ирээдүйн асуудлаарх стратегийн яриа хэлэлцээ” сэдэвт дугуй ширээний уулзалтыг зохион байгуулав. Уулзалтад Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын захирал Клаус Шваб болон 30 гаруй орон, олон улсын 90 гаруй байгууллагын 170 гаруй төлөөлөгч оролцсон. Түүнчлэн Дэлхийн байгаль орчныг өдөр, Ази, Номхон далайн бүс нутгийн Азийн банкны холбооны XXX чуулган, Зүүн хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны форум зэрэг арга хэмжээг энд дурдаж болно. Дэлхийн хэмжээний асуудалд монголчууд өөрсдийн дуу хоолойгоо хүргэж, нэр хүндтэй арга хэмжээг эх орондоо зохион байгуулж чадсан нь манай улсын нэр хүнд олон улсад өсч байгаагийн баталгаа болсон юм.



3. Дэлхийн томчууд Монголд тавтай морил



Нэг өглөө сэрэхэд Хадгаламж банкийг Төрийн банктай нэгтгэснийг эс тооцвол Монголын банк, санхүүгийн салбарт ээлтэй жил байлаа. Өнгөрсөн аравдугаар сарын эхээр Монголд анх удаа Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдлаа. Энэ нь манай улсын эдийн засаг, санхүүгийн салбарын ирээдүйд нэн чухал ач холбогдол бүхий үйл явдал юм. Мөн удтал дуншсан Үнэт цаасны тухай хууль өнгөрсөн хавар батлагдсан. Шинэ оны эхнээс хэрэгжиж эхэлнэ.

Монголын санхүүгийн салбарын 96 хувийг дангаараа эзэлдэг банкны салбарт Bank of China, Япон улсын хоёр дахь том банк Sumitomo Mitsui Banking Corporation (SMBC) зэрэг томчууд орж ирсэн нь олон хүний анхаарлыг татсан юм. Үүнийг Монгол Улс санхүүгийн зах зээлээ хамгаалж чадах эсэхийг нэг талаар сорьж буй хэрэг гэж харах хүмүүс ч бий. Нөгөө талаар бизнес эрхлэгчдэд чанартай үйлчилгээ үзүүлнэ гэсэн хүлээлт ч байна. SMBC банкны хөрөнгийн хэмжээ 1.5 их наяд ам.доллар буюу дэлхийн 20 том банкны нэг. Эдгээр банк Монголд төлөөлөгчийн газраа нээсэн нь нэг талаар Монголынхоо хөгжлийг тодорхойлох томоохон төслүүдэд хөрөнгө татах боломж юм. Нөгөө талаар гаднын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээхэд чухал үүрэгтэй. Дахиад ч Японы нэг номерын банк Монголд орж ирэх сураг шинэ оны босгон дээр чих дэлсэж байна. Дэлхийн томчууд Монголд тавтай морил.

4. Бизнесийн шинэчлэл




Монгол Улс Дэлхийн банкны бизнес эрхлэлтийн индексээр 2013 онд 76 дугаар байрт орсон нь өмнөх жилийнхээс 10 байраар ахисан үзүүлэлт юм. Гэхдээ энэ үзүүлэлтэд Засгийн газрын шинэчлэл хариуцсан сайд Ч.Сайханбилэг тэргүүтэй хүмүүс сэтгэл дундуур байгаа. Учир нь, Засгийн газар 2012 оноос бизнесийн шинэчлэл хийхээр тодорхой салбаруудад тодорхой ажил хийж эхэлсэн билээ. Тухайлбал, Барилгын зөвшөөрөл, Цахилгааны холболт, Гадаад худалдаа, Хөрөнгийн бүртгэл, Хөрөнгө оруулагчийг хамгаалах зэрэг чиглэлээр нэлээд ажил хийжээ. Гэсэн ч дээд түвшинд хийсэн дорвитой шинэчлэлүүд доод шатны хэрэгжүүлэх байгууллага дээр очоод ажил хэрэг болдоггүй. Хуучин хүнд сурталтай арга барилаар явж буй учраас санасан хэмжээний үр дүнг үзүүлж чадахгүй байгаа юм. Гэхдээ бизнесийн орчны шинэчлэлийн эхлэл олон зүйл дээр тавигдсан нь ирэх онд илүү бодитой үр дүн гарах үндэстэй. Мөн “Том төрөөс ухаалаг төр лүү” гэсэн томоохон хөтөлбөрийг санаачилсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн үйл хэрэг ч Засгийн газрын бизнесийн орчны шинэчлэлд хүч өгөх нь дамжиггүй. Тиймээс “Mongolian Economy” сэтгүүл бизнесийн орчны шинэчлэлийг оны онцлох үйл явдлаар нэрлэж байна.

5. Оюутолгойн экспорт ба шинэ боломж


Одоогоос жилийн өмнө “Оюутолгой”-н баяжуулах үйлдвэр ашиглалтад орсон. Ингэснээр өмнийн говь аж үйлдвэрийн төв болсон. Тэгвэл энэ онд тус компани зэсийн хүдрээ боловсруулсан. Зөвхөн хүдрээ баяжуулаад зогсохгүй бүтээгдэхүүнээ экспортолсон. Дэлхийн топ таван уурхайн нэг Оюутолгойн бүтээгдэхүүн үйлдвэрлэл Монгол Улсын төсвийн алтан найдвар гэж хэлж болно. Нөгөөтэйгүүр боловсруулах үйлдвэрлэлийн салбарт шинэ боломж авчирсныг салбарынхан нь онцолж буй. Баяжуулах үйлдвэр эхний гурван жилд дунджаар 27-30 хувийн агуулгатай 650-700 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэх юм. “Оюутолгой” компани оны эцэс гэхэд 85 мянган тонн зэс агуулсан баяжмал үйлдвэрлэхээр урьдчилан төлөвлөсөн. Одоогоор баяжуулах үйлдвэр хоногт 100 мянган тонн хүдэр боловсруулж байна. Уурхай ашиглалтын нийт хугацаандаа 78 сая тонн баяжмал үйлдвэрлэж 22.7 сая тонн зэс. Мөн 26 сая унци алт /808.6 тонн/, 170 сая унци мөнгө /5287 тонн/, 129 сая фунт молибден тус тус үйлдвэрлэхээр төлөвлөжээ.

“Оюутолгой”-н үйлдвэрийн өнөөгийн хүчин чадал нь “Эрдэнэт” үйлдвэрийнхээс даруй 12 сая тонноор их. Цаашид Оюутолгойн баяжуулах үйлдвэр хүчин чадлаа нэмэгдүүлэн 2018 он гэхэд жилд 54 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай болох юм. Уурхай жилд хамгийн багадаа 600 сая тонн зэс үйлдвэрлэх төлөвлөгөө бий. Эдийн засагт шинэ боломж айсуй.



6. Түүхэн бүтээн байгуулалт

Монголчууд салхийг эрхшээсэн түүхэн үйл явдал өнгөрсөн онд тохиосон. Энэ бол “Clean energy” компанийн “Салхит” салхин станцын томоохон бүтээн байгуулалт юм. Төвийн бүсийн сүлжээнд холбогдож байгаа анхны сэргээгдэх эрчим хүчний энэхүү эх үүсвэр нь хүчин чадлаараа ДЦС-4, ДЦС-3-ын дараа орно. “Салхит” салхин цахилгаан станцын салхин сэнс нь 120 гаруй метр өндөр. Баганын өндөр нь л гэхэд 80 метр, 125 тонн жинтэй. Далбаа тус бүр нь 40 гаруй метр урт, 6.2 тонн жинтэй. Энэ аварга төхөөрөмжийг тогтоохын тулд 240 шоо метр буюу есөн давхар байшингийн сууринд орох хэмжээний бетон зуурмаг орсон гэсэн. Мөн 110 кВт- ын 28 км урт хоёр хэлхээт дамжуулах шугам, тус бүр нь 1.6 мВт-ын чадалтай 31 салхин цахилгаан үүсгүүрээс салхит станц бүрдэнэ. Бүтээн байгуулалтын ерөнхий гүйцэтгэгчээр “Лейтон” ХХК ажилласан бөгөөд дотоодын



барилга угсралт, инженерийн 18 компани оролцсон байна. Барилга угсралтын ажлын оргил үед төслийн талбайд 500 гаруй хүн ажилласны 94 хувь нь монгол ажилчид байжээ. Станц бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээр жилд 120 мянган тонн нүүрс, 1.6 сая тонн ус хэмнэх юм. Мөн 20 орчим мянган га газар мод тарьсантай дүйцэхүйц хүлэмжийн хийн ялгарлаас сэргийлэх ажээ.

7. Мөнгөний бодлогын “иж бүрдэл”



Гаднын хөрөнгө оруулалт 40 хүртэл хувиар багассан. Оюутолгойн далд уурхайн хөрөнгө оруулалт зогссон. Ам.долларын ханш өссөөр оны сүүлийн сарын эхэнд 1700 төгрөгийг хол давж, бизнес эрхлэгчдэд дарамт болсон. Нүүрсний үнэ өндийж гийгүүлээгүй нэгэн оныг бид үдэх гэж байна. Валютын урсгал саарахын хэрээр иргэн бүр харилцан адилгүй хохирол амссан гэж хэлж болно. Нэг жилийн хугацаанд 1.5 тэрбум ам.доллар буюу 2.5 их наяд төгрөгийн алдагдал хүлээсэн болохыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж тэмдэглэсэн нь бий. Өөрөөр хэлбэл, гадаад зах зээлээс 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө босгосон ч энэ хэмжээний валютыг нэг жилийн хугацаанд бид алджээ. Үүнд валютын өсөлт нөлөөлсөн нь дамжиггүй. Төгрөгтэй харьцах ам.долларын ханш 20 хүртэлх хувиар чангарсан нь үүнийг тод гэрчилнэ. Иймээдрээ дундуур 2013 оны мөнгөний бодлого хэрэгжсэн. Нөгөөтэйгүүр мөнгөний бодлогоор зохицуулах төгрөгийн худалдан авах чадвар огцом суларсан нь эдийн засагт “шок” үүсгэсэн юм. Инфляцийг тогтоон барих мөнгөний бодлогын зорилт ирэх онд ч үргэлжилнэ. Ханшийн өсөлтийг Төвбанкны зүгээс гадаад хүчин зүйлтэй холбон тайлбарлаж буй.

Төсвийн орлого 1.5 их наядаар тасарсан нь мөнгөний бодлогыг зах зээлд томоохон тоглогч болгов. Монголбанк дээрх байдлыг зөөллөх үүднээс бодлогын хүүгээ гурван удаа бууруулсан. Ингэснээр зах зээлд 2.8 их наяд төгрөгийг нийлүүлсэн. Уламжлалт бус мөнгөний бодлогын хүрээнд Үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлж, ипотекийн тогтолцооны эхний алхмыг тавьсан. Нэг үгээр хэлбэл, мөнгөний бодлого макро эдийн засагт төсвийн бодлогоос илүү үүрэг гүйцэтгэв. Инфляцийг нэг оронтой тоонд оруулах. Цаашилбал тогтвортой барих гэсэн Төвбанкны зорилт богино хугацаанд биелэлээ олсон. Гэхдээ дунд хугацаанд тогтвортой байж чадсангүй.

8. Залруулга

Эдийн засаг огцом өсч, дэлхий нийтийг гайхшруулаад удаагүй байлаа. Гэтэл 2013 онд Монгол Улс гэнэтлэн хөрөнгө оруулагчдын сонирхлын гадна үлдчихсэн. Гадаадын шууд хөрөнгө оруулалт энэ онд 40 гаруй хувиар огцом буурч, валютын ханш хэт өссөн. Эдийн засгийн огцом өсөлт бага багаар царцав. Энэ бүх мэдээ улстөрчдийн нэг бус буруу шийдвэрээс улбаатай. 2006 оноос хойш уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой дөрвөн ч томоохон хууль батлагдаж, хэрэгжиж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд батлагдсан хуулиудын ихэнх нь хөрөнгө оруулагчдыг үргэсэн. Үүний хамгийн энгийн жишээ 2012 оны сонгуулийн өмнө гэнэт батлагдсан “Стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай”



хууль юм. Энэ хуулийн балаг 2013 онд Монголын эдийн засгийг хөмрөнгөө алдсан. Хөрөнгө оруулалтын орчин бараг хоёр жил болсны эцэст Хөрөнгө оруулалтын тухай хууль “мэндэлсэн” нь өнгөрч буй оны бас нэгэн онцлох үйл явдал яах аргагүй мөн. Хууль төрсний маргаашнаас эдийн засагт гарах эерэг үр дүнгийн талаарх хүлээлт, хөрөнгө оруулагчдын итгэл сэргэсэн болов уу гэх таамаг өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. Ямартай ч шинэ хуулиар Монголд хөрөнгөө оруулсан гадаад дотоодын бүх л хөрөнгө оруулагчдын дунд тогтвортой байдлыг бий болгож байгаад олзуурхах хүн олон.

9. Зам бүхэн хөгжлийн хөтөч



Авто замын салбарын хувьд ахиц дэвшлийн он байлаа. Тухайлбал, Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн 116.25 км авто зам шинээр ашиглалтад орсон. Үүнийг хүлээн авах нээлтийн ажиллагаанд Ерөнхий сайд Н.Алтанхуяг оролцохдоо “Энэ зам ашиглалтад орсноор ОХУ болон БНХАУ-тай олон улсын чанартай босоо тэнхлэгийн авто замаар холбогдож байгаа нь ач холбогдолтой юм” гэж тодотгосон.

Энэ жил авто замынхан нийтдээ 1824 километр хатуу хучилттай замын ажлыг хийж гүйцэтгэжээ.Тус салбарын бүтээн байгуулалтад нийт 9000 гаруй хүн ажлын байраар хангагдсан бөгөөд 5000 гаруй тоног төхөөрөмж ашигласан тухай Зам,тээврийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Р.Онон онцолсон юм.

Мөн шинэчлэлийн Засгийн газрын нийслэлийг орон нутагтай хатуу хучилттай замаар холбох зорилт хэрэгжиж байна. Тухайлбал, Хөвсгөл аймгийг Улаанбаатар хоттой холбох ажлын нэг хэсэг болсон 79 км хатуу хучилттай замыг ашиглалтад оруулсан. Ирэх онд үлдсэн 160 км замыг тавина. Улаанбаатар–Дархан-Алтанбулаг чиглэлийн замаас салаалсан Төв аймгийн Борнуурын 7,4, хуучнаар партизаны САА буюу Жаргалант хүртэлх 24,7 км зам байна. Налайх-Дөрөвдүгээр зөрлөг-Зуунмод чиглэлийн хатуу хучилттай 25 км замын ажил ч мөн бий. Үүнийг ашиглалтад оруулснаар Төв аймгийн иргэд цагираг хэлбэрийн замаар Улаанбаатарын зүүн, баруун талаар зорчиж нэвтрэх боломжтой юм. За тэгээд Увсад Наранбулаг –Хяргас нуурын чиглэлийн 100 км хатуу хучилттай замын нээлтийг хийгээд удаагүй байгаа. Ховд аймагт л гэхэд баруун бүсийн босоо тэнхлэгийн 85км, нийслэл чигтэй хэвтээ тэнхлэгийн 100 гаруй км замууд тавигдсан. Улаанбаатар хотод бол зам тавихаас гадна хэд хэдэн том уулзваруудыг шинээр бий болгосон. Энд харин тодотгоход улсын хэмжээнд шинэ зам тавих, хуучнаа өргөтгөх, засварлах, тордох, арчлах ажлыг ч өмнөх жилүүдээс өрнүүн хийснийг тэмдэглэхэд таатай.

10. Өсөлтийн эзэн



Эдийн засгийн өсөлтийг 2013 онд хадгалж үлдэхэд томоохон хувь нэмэр оруулсан нь үл хөдлөх хөрөнгийн салбар. Тэр дундаа орон сууцны зах зээл байлаа. Статистик тоо мэдээллээс харахад өнгөрсөн онд 11349 айлын орон сууц нийслэлд шинээр ашиглалтад орсон. Энэ ондоо багтаж 19390 айлын орон сууц ашиглалтад орох төлөвтэй байна. Үүнээс өнгөрсөн арваннэгдүгээр сарын 28-ний байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд нийт 38311 айлын орон сууц шинээр борлуулагджээ. Эдгээр тоон үзүүлэлтээс гадна Монголбанк, Дэлхийн банкны гаргасан судалгаагаар барилгын салбар энэ жил 125 хувиар огцом өсөлт үзүүлжээ. Эдийн засгийн уналтын шинж илэрсэн жилд барилгын салбарын өсөлт эрчээ авсны гол учиг нь Үнэ тогтворжуулах хөтөлбөр болон орон сууцны найман хувийн зээл юм. Цаашдаа Улаанбаатар хот 2012-2020 онд барилгын салбарын эрчимтэй хөгжлийн суурь бүс байх төлөвтэй байна. Энэ утгаараа ирэх онуудад барилгын салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэх төлөв бий. Хонконгийн “Mongolia Investment Summit 2013” чуулганы үеэр Монголын барилгын салбарт хөрөнгө оруулах боломж байгаа эсэх талаар гаднын хөрөнгө оруулагчид ихээхэн сонирхжээ. ■

УРД ХӨРШ

ЕВРО БҮСИЙН “СҮҮДЭР” ХЯТАДАД

Б.АЛТАЙ

Дэлхийн эдийн засаг ирэх онд тэдийлэн сайжрахгүй нь бололтой. Хэдийгээр АНУ, Евро бүсийн эдийн засаг ялимгүй сэргэхээр байгаа ч Төвбанкууд нь мөнгөний тэлэх бодлогоо аажмаар хязгаарлах болсноор эдийн засгийн өсөлт нь царцаж мэдэх юм гэж “Roubini Global Economics”-н дэлхийн эдийн засгийн бүсчилсэн шинжилгээнд дурджээ. Түүнчлэн Хятадын хөрөнгө оруулалтын өгөөж буурч, эдийн засгийн өсөлт саарч байгаа нь түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлснөөр манай гадаад худалдаа, хөрөнгө оруулалт эрс сэргэх найдвар замхарч байна. Хэрэв энэ байдал нь удаан үргэлжлэх аваас экспортын бүтээгдэхүүний үнэ өсөх бус унах эрсдэлтэй.

Энэ онд Хятадын ДНБ-ий өсөлт 7.5 болж, 0.2 хувиар буурчээ. Тус улсын албан ёсны статистик мэдээнд аж үйлдвэрийн өсөлт 9.9 хувиас 8.9 хувь болж, нэг хувиар буурсан гэжээ. Энэ нь дээрхэд нөлөөлсөн байна. Нөгөө талаасаа Евро бүсийн эдийн засгийн хямралаас үүдэн Хятадын гадаад худалдаа алдагдал хүлгээгээд буй. Иймээс тус улсын удирдлагууд эдийн засгийн бодлогоо өөрчилж илүү тэнцвэртэй, дотоод эрэлт, хэрэглээнд суурилсан өсөлтийг бий болгохыг эрмэлзэж байна. Мөн чанаргүй зээлийн хэмжээг бууруулж, хумих бодлого зарлалаа.

“Таны хэзээ ч сонсоогүй Хятадын компаниуд дараагийн арван жилд аварга том өрсөлдөгч болон гарч ирнэ. Тэд таны пүүсийн оршин тогтоноход заналхийлэх болно. Хятад зөвхөн зах зээл тэдий бус. Энэ орон буурьтай өрсөлдөгч болох замдаа их хурдтай явна” хэмээн “Женерал Электроник”-ийн домогт удирдагч явсан Жак Уэлч өөрийн “Jack Straight from the Gut” хэмээх намтарчилсан бүтээлдээ сануулж байсан. Үнэхээр хоосноос үүссэн мэт Хятад сүүлийн 15 жилд дэлхийн экспортын хоёр дахь гүрэн болж гарч ирэв.

Эдийн засгийн өсөлт нь алгуур саарсан ч Хятад ирэх онд энэ оны амжилтаа хадгална хэмээн Дэлхийн банк үзэж байна. Дундаж өсөлт нь долоон хувь байх бөгөөд 2014 онд үүнээс дээш тэдийлэн цойлохгүй аж. 2015 он хүртэл Хятадын эдийн засгийн жилийн дундаж өсөлт дээрхээс нэг их хэтрэхгүй гэх. Тэгвэл шинээр 45 сая ажлын байр бий болгох зорилтыг урд хөрш өмнөө тавьжээ.

“The Economist”-сэтгүүлд гарсан таамаглалаар Хятадын эдийн засгийн өсөлт 2020 он хүртэл дунджаар долоон хувиар өсөхөөр байна. Энэхүү өсөлт нь 2030 он гэхэд 3.7 хувь байх болно гэжээ. Тус сэтгүүлийн таамгаар Хятадын эдийн засаг 2016 он гэхэд АНУ-ыг гүйцэж түрүүлнэ гэсэн. Мөн 2030 он гэхэд Хятад АНУ-ын эдийн засгаас даруй 30 хувиар илүү байна гэж тоцоолсон. Үүгээр бол дэлхийн хамгийн том эдийн засагтай улс болох юм.

Хятадын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 8650 ам.доллар болж өссөн байна. Дэлхийн эдийн засагт шинэ тоглогч болоод буй Хятадыг хямд өртөгтэй ажиллах хүч нь олон улсад өрсөлдөхүйц үйлдвэрлэгч болгож хувиргасан юм. Тус улсад дунджаар нэг цагийн ажлын хөлс хоёр ам.доллар байв. Харин ирэх оноос Хятадын ажиллах хүчний ажлын хөлс эрс нэмэгдэж магадгүй нь. Энэ дүн АНУ-д 35 ам.доллар байдаг.

Дэлхийн хүн амын тавны нэгийг эзлэх Хятад эдийн засагтаа бүтцийн өөрчлөлт хийж буй. Энэ талаар манай сэтгүүл өмнө нь нийтэлж байсан бөгөөд 54 дэх дугаарын “Хятадын шинэ эдийн засаг” өгүүллээс үзэж болно. Азийн хөгжлийн банкны төсөөлж байгаагаар ирэх онд эдийн засаг мөн л үргэлжлэн ялимгүй саарч, 7.4 хувь болох төлөвтэй байна. Өмнө нь дээрх банк Хятадын эдийн засгийг энэ онд 8.2 хувиар өснө гэж таамаглаж байв. Тус улсын эдийн засгийн өсөлт сүүлийн арван жилийн туршид дунджаар 10.5 хувь байсан.

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч байгаа нь тус улсын эрх баригчдын хэрэгжүүлж буй бодлоготой холбоотой болохыг Азийн

хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын ахлах эдийн засагч Яан Хансэн тайлбарласан юм. Түүний хэлж байгаагаар экспорт болон хөрөнгө оруулалтад тулгуурласан өсөлтөөс хувийн хэрэглээ, нийгмийн үйлчилгээний тэлэлтэд суурилсан тогтвортой хөгжлийн загвар руу дунд хугацаанд шилжиж байгаа. Энэ нь өсөлт саарах шалтгаан болжээ. Үүнийг “дахин тэнцвэржүүлэх” бодлогын үр дүн гэж Яан Хансэн хэллээ.

Хятад нь түүхий эдэд суурилсан хурдтай хөгжлийн загвараас татгалзаж эхэлсэн нь Азийн бүсийн улс орнуудад ихээхэн эрсдэл дагуулсаар. Тэр тусмаа Хятад руу эрдсийн бүтээгдэхүүн экспортлогч орнуудад энэ байдал нь цаашдаа ч улам хүндрэл учруулж болзошгүй. Хятадгүйгээр энэ дэлхий оршин тогтнож чадахгүй. Тэд дэлхийн хамгийн том эдийн засагтай болж чадсан. Үүнээс гадна НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн хориг тавих эрхтэй гишүүн өнөөдөр дэлхийг “захирч” байна. Тэд хойшдоо ч захирах бололтой. Японыг ардаа “жийж” чадсан Хятад АНУ-ын байр сууринд шилжих нь нэгэнт тодорхой болохыг “Хятад дэлхийн гүрэн эргэж ирж байна” номонд дурджээ. Нөгөөтэйгүүр Хятадын эдийн засгийн сэргэлт удааширч байгаа нь Евробүсийн эдийн засгийн төлөв бүрхэг байгаагаас улбаатай аж. ■



Шинээр 45 сая ажлын байр бий болгох зорилтыг урд хөрш өмнөө тавьжээ.



ХОЙД ХӨРШ

ОХУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2013 ОНЫ ТОЙМ

Р.ГАНТУЛГА

Deloitte Research судалгааны байгууллага

ОХУ-ын эдийн засаг цаашид хэрхэх нь тодорхойгүй байна. Тус улсын ДНБ-ий өсөлт саарч, газрын тосны салбар уналтад орж буй. Энэ нь дэлхий дахины газрын тосны хэрэгцээ буурсантай холбоотой. Бусад салбарын хувьд гадаад, дотоодын хөрөнгө оруулалт буурахад татвараас хамааралтай байдал нь сөргөөр нөлөөлж байна. Мөн эдийн засгийн удаашралд нөлөөлж буй хүчин зүйл нь санхүүгийн асуудал. Учир нь энэ оны нэгдүгээр улиралд тус улсын төсвийн тэнцэл тааруухан байсан. Энэ тохиолдолд мөнгөний бодлогоо өөрчлөх хэрэгтэй байсан боловч тэгсэнгүй. Ялангуяа бизнесийнхэн санхүүжилтийн өртөг, зардал маш өндөр байгаад гомдоллох болсон. Харамсалтай нь инфляци өндөр байгаа учраас бодлогын хүүг ойрын үед бууруулах боломжгүй аж. Эдийн засгийн хувьд ганцхан боломж нь хувийн хэрэглээний зардлыг нэмэгдүүлэх. Энэ төрлийн зардлыг ажилгүйдлийн түвшинг бууруулах, орлого нэмэгдүүлэх, хэрэглээний кредит карт нэвтрүүлэх зэргээр нэмэгдүүлэх боломжтой.

Эдийн засагт тээг болж буй таваар, хөрөнгө оруулалт

ОХУ-ыг таваараас хамааралтай гэдгийг ялангуяа гол зах зээлийн хэрэгцээ буурахад хэрхэн уналтад орж байгаагаас нь төвөггүй харж болно. Таваарын ханш уналттай байгаа нь Евробүсийн 17 орны эдийн засаг тааруухан байгаатай холбоотой. Мөн АНУ-ын эдийн засаг тэдийлэн сэргэхгүй байна. БНХАУ, Энэтхэг зэрэг таваар импортлогч гол зах зээлийн эдийн засгийн өсөлт тааруухан байгаатай ч мөн хамаатай.

Тухайлбал, ОХУ-ын экспортын гол түүхий эд болох Уралын түүхий нефть энэ оны эхний улиралд нэг баррель нь дунджаар 111 ам.долларын ханштай байв. Энэ нь жилийн таван хувийн бууралттай ханш юм.

График 1. Түүхий нефтийн үнэ, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт



Эх сурвалж: Deloitt University Press

Газрын тос, байгалийн хий, металл зэрэг байгалийн нөөц олборлолт эдийн засгийг энэ оны эхний улиралд арагш татах гол хүчин зүйл байсанд гайхах зүйлгүй. Жилийн дундаж өсөлт 4.9 хувиар буурсан байна. Энэ нь эргээд ДНБ-ий бодит өсөлтийг 1.6 хувиар бууруулжээ. Энэ нь 2009 оны дөрөвдүгээр улирлаас хойших хамгийн муу өсөлтөд тооцогдож байна.

Хөрөнгө оруулалт өнгөрсөн оны эхний улирлаас эхлэн огцом буурсан. Энэ оны эхний улиралд 0.4-хөн хувийн өсөлттэй байв. Гадаад хэрэгцээ буурсан нь газрын тосны компаниудыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнийхөө хамрах хүрээг багасгахаас аргагүй болгожээ. Зээлийн

График 2. ДНБ-ий бодит өсөлт, хувийн хэрэглээ, нийт хөрөнгө оруулалт (%)



Эх сурвалж: Bloomberg, 2013, Oxford Economics

өндөр зардал мөн ямар ч дэмжлэг болж чадаагүй байна. Түүнчлэн ирэх онд зохиогдох Сочигийн өвлийн олимпийн бэлтгэл ажил бараг дууссан боловч барилгын үйл ажиллагаа нь удаашрах болжээ. Энэ нь үндсэн хөрөнгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж буй.

2013 онд ОХУ-ын эдийн засгийн өсөлтийг хөдөлгөгч гол хүчин зүйл нь хувийн хэрэглээ байв. Ирэх онд ч мөн адил байх бололтой. 2013 онд өсөлт 6.8 хувь, энэ оны эхний улиралд 4.7 хувь байсан. Хөдөлмөрийн хүчтэй зах зээл, өсөн нэмэгдэж буй орлого, зээл авахад хялбар болсон зэрэг олон хүчин зүйлээс хэрэглэгчид ашиг хүртсэн байна. Энэ оны тавдугаар сарын байдлаар ажилгүйдлийн түвшин 5.2 хувь болж буурчээ. Энэ нь хамгийн доогуур үзүүлэлтүүдийн нэг байв. Цаашид ч богино хугацаанд доогуур түвшнээ хадгалах шинжтэй байна. 2013 оны эхний таван сарын байдлаар орлого 12.5 хувиар нэмэгдсэн бөгөөд цалин, хөлс таван хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй. Түүнчлэн өрхийн өр харьцангуй бага буюу ДНБ-ий 12 хувийг эзэлж байгаа. Тиймээс зээл авах боломжоор хэрэглэгчдийг хангах үндэслэлтэй юм. Энэ онд хэрэглэгчдийн өр 40 хувь, кредит картны зээл 80 хувь хүртэл тус тус нэмэгдсэн аж.

Гэхдээ зээл олгох давтамж, хурд удаашрах хандлагатай байна. Энэ нь Оросын Төвбанк арилжааны банкуудаа хэрэглээний зээлийн хүүгээ бууруулахыг шавдуулсаар ирсэнтэй холбоотой. Ингэснээр зээл олгох асуудлыг аль болох түргэн хугацаанд шийдвэрлэх шаардлага гарсан. Улмаар үүнтэй холбоотой эрсдэлийг бий болгож буй. Хэрэглэгчдийн хувьд өөр нэг асуудал бол өндөр инфляци. Энэ нь бодит цалин дахь өсөлтийг бууруулах хандлагатай. Ингэснээр хэрэглэгчдийн худалдан авалтад сөргөөр нөлөөлж болзошгүй. Эдгээрийн нөлөөлөл болон удааширч буй эдийн засгаас хувийн хэрэглээнд үзүүлж буй нөлөөлөл нь жижиглэнгийн худалдааны өсөлт буурч буйг тодорхой хэмжээгээр харуулж байна.

Борлуулалт 2013 оны тавдугаар сард 2.9 хувиар өссөн. Гэхдээ дөрөвдүгээр сараас 4.1 хувиар, нэгдүгээр сараас 4.4 хувиар тус тус буурсан үзүүлэлт юм. Харин хэрэглээний зардал буурахгүй нь бололтой. Хувийн нийт хэрэглээний өсөлт 4.4-4.6 хувь байх хандлагатай байна. Энэ нь ДНБ-ийг 2.2-2.4 хувиар өсгөх болно.


Оросын Төвбанк өнгөрсөн нэгдүгээр сараас хойш бодлогын хүүгээ өөрчлөөгүй. Сүүлийн есөн сарын турш 8.5 хувь байлгасаар иржээ. Хэдийгээр инфляци өндөр, хэрэглээний зээлийн өсөлт хүчтэй байгаа боловч эдийн засгаа сэргээх үүднээс тус банк бодлогын хүүгээ бууруулахаас татгалзсан байна. Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, хэрэглэгчийн хэрэгцээ өссөн зэргээс шалтгаалан өнгөрсөн оноос хойш инфляци өсч буй. Өнгөрсөн тавдугаар сард инфляци сүүлийн 21 сард байгаагүйгээрээ хамгийн өндөр түвшинд хүрч, 7.4 хувь болсон. Харин Төвбанкнаас таамаглаж байсан түвшин 5-6 хувь байв. Үүний зэрэгцээ хэрэглээний зээл болон эдийн засаг дахь нийт мөнгөн дүн (broad money – M2) энэ онд мөн өссөн үзүүлэлттэй байна. Нийт мөнгөн дүнгийн өсөлт өнгөрсөн оны арванхоёрдугаар сард 11.9 хувь байсан. Тэгвэл энэ оны дөрөвдүгээр сард 15.2 хувь болж нэмэгджээ.

График 3. Жижиглэнгийн худалдааны өсөлт, ажилгүйдэл



Эх сурвалж: Bloomberg, 2013

График 4. Инфляци, М2 нийлүүлэлтийн өсөлт



Эх сурвалж: Bloomberg, 2013

Өндөр үнийн дарамтаас үл хамааран энэ оны сүүлч гэхэд мөнгөний бодлого тодорхой хэмжээгээр сулрах шинжтэй байна. Инфляци өнгөрсөн оны хоёрдугаар хагаст илүү хөнгөрч буй. Энэ нь суурь нөлөө их, бүтээгдэхүүний гарц илүү сайн байгаатай холбоотой.

Мөн Оросын Төвбанк бодлогын хүүгээ энэ оны сүүлийн хагаст 25-50 суурь оноо (basis point – bps)-гоор бууруулах боломжтой. Хэрэв инфляци тус банкны дээд хэмжээ болох зургаан хувиас буурвал дахин 25 суурь оноогоор бууруулах боломжгүй юм. Үүний зэрэгцээ тус банкны удирдлага солигдсон нь мөнгөний бодлого дахь инфляцийн асуудлыг шийдвэрлэнэ байх гэсэн хүлээлтийг үүсгэжээ. Тус банкны ерөнхийлөгч Эльвира Набиуллина бодлогын хүүгийн ханшийг бууруулах эсэх нь богино хугацаанд үнийн дарамт ямар байхаас шалтгаална хэмээн удаа дараалан хэлжээ. Тэрбээр рублийн ханшийг улам өрсөлдөөнтэй болгох эрсдлийг дагуулах ханшийн зах зээлд хөндлөнгөөс оролцохгүй гэдгээ илэрхийлсэн. Үүний оронд мөнгөний бодлогод зориулсан инфляцийг онилсон механизмыг бүрдүүлнэ. Бас томоохон банкуудын төвлөрлийг сулруулах, банк бус санхүүгийн байгууллагын зохицуулалтын хяналтыг сайжруулах нь чухал. Түүнчлэн эрсдэл болон зээлийн практикийн талаарх мэдээллийн тэгш хэмийг сайжруулах нь илүү дээр хэмээн тэрбээр үзэж байгаа аж.

Санхүүгийн илүү хянамгай байдал

Санхүүгийн нэгдэл (fiscal consolidation) нь ирэх хоёр жилийн хугацаанд гол асуудал хэвээр байх төлөвтэй байна. Засгийн газар 2015 оны төсвийг тэнцвэртэй байдлаар гаргахыг зорьж буй. Гэвч уг төсөв нь өнгөрсөн онд ялимгүй илүүдэлтэй гарсан байна (ДНБ-ийн 0.1 хувьтай тэнцэх). Энэ нь хөрөнгийн урсгалыг удаашруулж буй. Шалтгаан нь ДНБ-ий өсөлт буурсантай холбоотой. Нөгөө талаас таваарын доогуур ханш энэ онд төсвийн алдагдал үүсгэх магадлалтай. Үүнтэй мөн холбоотой аж.

График 5. Улсын өр ба Засгийн газрын тэнцвэржүүлэлт (ДНБ-н эзлэх хувь)



Эх сурвалж: Deloitte University Press

ОХУ-ын газрын тос болон байгалийн хийнхээс бусад салбарын алдагдал ДНБ-ий 10.6 хувьтай тэнцэх болжээ. Уг нь таван хувь байх болов уу хэмээн Дэлхийн банк болон Олон улсын валютын сан тооцоолж байв. Энэ зорилтод хүрэхийн тулд Засгийн газар ялангуяа дунд болон урт хугацааны зардлыг багасгах арга замыг хайх шаардлагатай болж. Гэхдээ тус Засгийн газраас газрын тосны үнийг таамаглахаас илүү урт хугацааны дундаж үнийг гаргах зэргээр төсвийн зардлыг бодитоор танах санаачилгатай байгаа нь сайшаалтай хэрэг. Газрын тосны урт хугацаат үнэ гэдэг нь өнгөрсөн таван жилийн дундаж үнэ юм байна. Гэхдээ энэ нь газрын тосноос бусад салбарыг илүү сайн удирдан зохион байгуулах түвшинд хүргэхэд хангалттай биш юм.

Эдийн засгийн өсөлтөд байгалийн нөөцөө ашиглах хэрэгтэй

ОХУ-ын эдийн засгийн өсөлт удаашрах болсонтой холбоотойгоор тус улсын Ерөнхийлөгч Владимир Путин мэдэгдэл хийжээ. Тэрбээр 43.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг гол төлөв дэд бүтцэд хийх төлөвлөгөөгөө танилцуулсан. Үүнээс 13.6 тэрбум ам.долларыг нь Үндэсний баялгийн сангаасаа санхүүжүүлэх аж. Үүнд Транс-Сибирийн төмөр замыг шинэчлэх, Москва болон Казань хотын хооронд хурдны галт тэрэгний 900 км төмөр зам барих, Москва хотыг тойрсон хурдны авто зам барих гэсэн гурван том төсөл багтаж буй. Засгийн газраас эрсдлийг бууруулах баталгаа өгөхийн зэрэгцээ хувийн хөрөнгө оруулагчид нээлттэй аж. Энэ нь эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой. Гэвч хөрөнгө оруулалтын орчинг сайжруулж, эдийн засгийг төрөлжүүлж, үйлдвэрийн бүтээмжийг дээшлүүлэхгүйгээр үүнийг хийх боломжгүй.

Бизнесийн орчин, бүтээмжийг сайжруулж, эдийн засгийг төрөлжүүлэх шаардлага

Хөрөнгө оруулагчид сүүлийн жилүүдэд ОХУ-д гарч буй эдийн засгийн гэмт хэргүүдийн золиос болсон тохиолдол нэлээд бий. Үүнтэй холбоотойгоор Ерөнхийлөгч Путин ийм төрлийн гэмт хэргээр шоронд хоригдож буй гаднын хүмүүст өршөөл үзүүлэх зарлиг гаргасан. Энэ нь тус улсад бизнесийн орчинг сайжруулах зорилготой. Гаднын хөрөнгө оруулалтыг татахын тулд компанийн сайн засаглалыг хөгжүүлж, бизнесийн ил тод байдлыг сайжруулах, төрийн зохицуулалтыг халах зэргээр шаардлагатай ахиц, дэвшлийг гаргах хэрэгтэй юм. Эдийн засгийг газрын тосны бус салбаруудаар төрөлжүүлэх хэрэгтэй. Ингэснээр аж үйлдвэр, үйлчилгээ зэрэг бусад олон салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжтой. Цаашдын тогтвортой хөгжил, төрийн эрүүл санхүүжилтэд амин чухал зүйл бол орчин үеийн технологи болон чадвартай мэргэжилтнүүд.

ОХУ-ын ажил эрхэлдэг иргэдийн тоо сүүлийн үед буурч байгаа. Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд технологи болон ур чадварыг хөгжүүлэх шаардлагатай. Энэ нь мөн бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс

олох ашиг, орлогыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Хөдөлмөр эрхлэх насны хүн амын тоо 2020 он хүртэл жил бүр 0.9 хувиар буурах хандлагатай байна. Энэ нь тэтгэвэр болон эрүүл мэндийн зардал нь цаашид ажил эрхлэгчид, аж ахуйн нэгж, засгийн газарт улам дарамт болно гэсэн үг. Тус улсад ажиллах хүчний тоо буурч байгаагаас ДНБ-ий боломжит өсөлт ч буурах төлөвтэй. Иймээс үйлдвэрлэлээс олох ашиг, орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Шигтгээ цогцолбор:

Ирэх онд зохиогдох Сочигийн өвлийн олимпийн тоглолтын нийт зардал 50 тэрбум ам.доллар болох төлөвтэй байгаа тооцоог Pricewaterhouse-Coopers компани хийжээ. Энэ нь олимпийн түүхэн дэх үнэмлэхүй өндөр зардал болох аж. Тухайлбал, Канадын Ванкувер хотноо 2010 онд зохиогдсон өвлийн олимпийн тоглолтын зардал ердөө 3.6 тэрбум ам.доллар байв. ■

www.reuters.com

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ



АНУ-ын Эдийн засгийн шинжилгээний товчооноос гаргасан тоо, баримтаар ДНБ нь энэ оны хоёрдугаар улиралд 2.5, гуравдугаар улиралд 3.6 хувиар тус тус өсчээ. Олон улсын валютын сан (ОУВС)-гийн тооцоогоор эдийн засгийн өсөлт нь дунджаар 1.7 хувь байв. Харин шинэ онд 2.7 хувиар өснө гэсэн таамаг дэвшүүлжээ. Төсвийн зардал таналт ирэх онд мөн л үргэлжлэх хандлагатай байна.


Евробүсийн эдийн засаг жил хагасын турш хямралд байв. Харин энэ оны хоёрдугаар улиралд 0.3 хувиар өсч, хямралаас гарсан. Улмаар гуравдугаар улиралд 0.1-хэн хувиар өсчээ. ОУВС-гаас евробүсийн эдийн засаг ирэх онд нэг хувиар өсөх болов уу хэмээн таамаглаж буй. Өсөлт төдийлэн сайнгүй байсан нь Европын томоохон орнуудад бодлогын хэрэгжилт хойшлогдож, хэрэгжүүлэх ёстой байсан арга хэмжээ нь сунжирсантай холбоотой гэжээ.



Японы эдийн засгийн өсөлт энэ оны гуравдугаар улиралд 0.3 хувийн өсөлттэй байгаа талаар Засгийн газраас нь мэдэгдсэн байна. Харин нэг болон хоёрдугаар улиралд өсөлт харьцангуй сайн байжээ. Энэ нь Ерөнхий сайд Шинзо Абэгийн тэргүүлсэн Засгийн газраас авсан шийдмэг арга хэмжээтэй холбоотой аж. Уламжлалт бус мөнгөний бодлого хэрэгжүүлж, эдийн засагтаа шинээр мөнгөн тэмдэгт нийлүүлсэн байна. Улмаар иенийн ханш суларч, экспортлогч компаниудын борлуулалт сайжирснаар ашиг, орлого нь нэмэгдэх болсон. Айсуй онд эдийн засаг 1.25 хувиар өсөх төлөвтэй байна.



Энэтхэгийн эдийн засгийн өсөлт 2013 оны хоёрдугаар улиралд 4.4 хувь, гуравдугаар улиралд 4.8 хувь байв. Эдийн засаг нь таван хувиас дээш гарч өгөхгүй жилийн нүүр үзэж байгаа аж. Энэ нь санхүү, эдийн засгийн бодлого шинэчлэлт тааруухан хийсэнтэй холбоотой хэмээн ОВУС үзэж байна. Дэлхийн банкнаас тус улсын эдийн засгийг ирэх онд таваас илүү хувиар өснө гэсэн таамгийг дэвшүүлжээ.



Эх сурвалж: www.imf.org, www.dupress.com, www.bbc.co.uk, www.forbes.com, www.economist.com, www.reuters.com www.worldbank.com www.oecd.com

ТӨСӨВ

ТӨСӨВТ ИЙМ ЭРСДЭЛ БАЙНА

Б.ТОГТОХ

Манай улс ирэх онд 31.4 сая тонн нүүрс экспортолно. Хэрэв чадахгүй бол төсвийн орлого сох дутна гэсэн үг. Цаашилбал, орлогын хомсдолоос үүдэн эдийн засгийн дархлаа суларч болзошгүй. Энэ тохиолдолд Засгийн газар дахин төсвөө тодотгоно. Мөн тухайн оны хөрөнгө оруулалтын зардлаа танах хүртэлх арга хэмжээг авна. Ингэснээр шинэ сургууль, цэцэрлэг, эмнэлэг дахиад нэг жил цаасан дээр үлдэнэ гэсэн үг. Нийгмийн байгууламж удаашрах аваас хүний хөгжил зогсонги байдалд шилжинэ. Бидний өдөр тутмын амьдралд урган гарч буй асуудал улам цар хүрээгээ тэлж, зардал өснө. Аль ч тохиолдолд төсвийн хөрөнгө оруулалт жил өнжих тусам зардал нь хоёр дахин өсдөг аж. Тиймээс төсөвт суусан хөрөнгө оруулалтыг нэн даруй хугацаанд нь хийснээр гарч болох үр дагавар багасна. Ингэснээр улс хожих юм.

Ирэх оны төсвийн хөрөнгө оруулалтын зардал 1.1 их наяд төгрөг. Үүний 930.3 тэрбум төгрөгөөр барилга байгууламж барих юм. Энэ нь нийт хөрөнгө оруулалтын 81.4 хувийг эзэлж байна. Их засварын ажилд 44.7 тэрбум төгрөг зарцуулах бол 117.8 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж техник хэрэгсэл худалдан авахаар төлөвлөжээ. Мөн 42.9 тэрбум төгрөгийг дараа онуудад хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг хангахад зориулахаар баталсан байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар 69 цэцэрлэг, 49 сургууль, 28 дотуур байр, 30 эмнэлэг, 27 соёлын төв, 683.1 км хатуу хучилттай зам барих юм. Мөн таван цэвэрлэх байгууламж, 1032 урт метр төмөр бетон гүүр байгуулах аж. Гэхдээ төсвийн орлого бүрдсэн тохиолдолд дээрх бүтээн байгуулалт ажил хэрэг болно гэсэн үг.

Нэг талаасаа ирэх оны төсөв Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг мөрдсөн гэж хэлж болно. Гэхдээ төсвөөс гадуурх санхүүжилт /Чингис бонд/ тэлсээр байгаа нь дунд хугацаандаа хямралд хөтөлж мэдэхийг гадна, дотнын мэргэжлийн хүмүүс анхааруулж буй. Тиймээс төсвийн орлогыг бодитой төлөвлөх. Төсөвт учирч болох эрсдэлийг тооцоолж үзэх нь нэн тэргүүнд хийх “гэрийн даалгавар” болоод байна. Ирэх оны төсвийг “бодитой төсөв” гэж Сангийн сайд Ч.Улаан дүгнэсэн. Сайдын хэлснээр өмнөх жилүүдэд орлогыг маш өндөр төлөвлөж, түүнийг дагаж зарлага их өссөн тал бий. Өөрөөр хэлбэл, хүсэл мөрөөдөл шингэсэн төсөв болдог байсныг Сангийн сайд хэлсэн юм.

Шинэ он удахгүй гарлаа. Он гарахтай зэрэгцэн төсөвт тодотгол оруулах асуудлыг УИХ авч хэлэлцэнэ. Нийт 240 гаруй обьектыг судалж, өртөг зардал, үндэслэлийг хянах. Мөн зардал өссөн шалтгааныг тогтоохыг Үндэсний аудитын газарт УИХ даалгасан. Уг шалгалтын дүгнэлтэд үндэслэн төсөвт тодотгол хийнэ. Ирэх оны төсвийн алдагдал 410 тэрбум төгрөг. Энэ нь ДНБ-ий хоёр хувь буюу төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа. Гэвч төсвийн орлого бүрдэх эсэх нь эргэлзээ төрүүлсээр.



Ирэх онд манай улсын эдийн засаг тэдийлэн сайжрахгүй гэсэн дүн мэдээ гарах болсон нь сэтгэл түгшээсээр.

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор, профессор Ч.Энхбаяр “2013 оны эдийн засгийн хүндрэлтэй байдал нь ирэх оны төсвийг өөдрөг төсөөлөх нөхцөл боломжийг бууруулсан. Төсвийг үндэслэлгүй тэлдэг байдал өөрчлөгдөж, макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй уялдаатай байдал нэмэгдсэн” гэв. Ирэх оны төсвийн орлогын таамаглал энэ оныхоос таван хувиар буюу 363 тэрбум төгрөгөөр буурсан. Энэ нь эдийн засгийн идэвх саарсантай холбоотой. Нөгөөтэйгүүр төсвийн нийт орлогын тавны нэг нь уул уурхайн татвараас хамааралтай байгаа. Энэ нь төсвийн орлогын төвлөрөл өндөр, эмзэг байдал буурахгүй байгаагийн баталгаа аж.

Ирэх оны өнгийг Дэлхийн банк тун өөдрөг бусаар төсөөлж байгаа. Тэр тусмаа манай улсын хувьд эдийн засаг одоогийнхоос агшиж мэдэх онцгүй таамаг чих дэлсэх болов. Хэрэв “Оюутолгой”-н далд уурхайг тойрсон асуудал удаашрах аваас эдийн засаг царцанги байдалд шилжих. Ингэснээр хөгжил саатах эрсдэл байгааг УИХ-ын гишүүн Р.Амаржаргал анхааруулсан юм. Түүний хэлж буйгаар “Оюутолгойн хоёрдугаар ээлж үндсэндээ зогссон. Хамгийн өөдрөгөөр одоо гэрээ хэлцэл байгуулж чадна гэж үзвэл бодит ажил эхэлтэл дахиад хоёр жил хэрэгтэй болно” гэв. Эдийн засгийн нөхцөл тун ярвигтай байгааг тэрбээр учирласан. Мөн төсвийн алдагдал бараг 7-8 хувьд хүрч, өрийн дарамт урьд өмнө үзэгдээгүй түвшинд хүрсэн, банкны салбар сул дорой, эмзэг байгааг өгүүлсэн.

Монголбанкны зүгээс ирэх онд бодит эдийн засаг нэлээд хэмжээгээр царцах. Цаашлаад хумигдах эрсдэл байгааг сануулж буй. Сүүлийн таван жил гадаадын шууд хөрөнгө оруулалт болон томоохон төслүүдийн ачаар манай эдийн засаг жил бүр хоёр оронтой тоогоор өссөн. Тэгвэл ирэх онд огцом уруудаж тав болж буурах өндөр эрсдэл бий аж.

“Нээлттэй нийгэм форум”-аас “Төсвийн төлөвлөлтийг ул суурьтай хийх нь төсвийн орлогыг бүрдүүлэх хамгийн оновчтой арга хэлбэр” гэж үзэв. Ирэх оны төсөвт уул уурхайн салбар 1.4 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлнэ. Үүний 43 хувийг нүүрс, 27 хувийг зэсийн баяжмал, 13 хувийг алт тус тус бүрдүүлэхээр байгаа. Өөрөөр хэлбэл, нэгдсэн төсвийн 12 хувийг уул уурхайн салбар олно гэсэн үг.

Оюутолгойн хувьд төсвийн таван хувийг дангаар бүрдүүлэх юм. Дээрх судалгаанд “Коксжих нүүрсний орлого 30 хувиар өсөж, БНХАУ руу 31.4 сая тонн нүүрс экспортлох боломжтой гэж үзсэн нь хэт өөдрөг байх магадлалтай” гэжээ. Энэ оны төсөвт сууснаар 28 сая тонн нүүрс экспортлох ёстой байсан. Гэвч энэ үзүүлэлт 16 сая тоннд дөнгөн данган хүрч байна. “Монгол нүүрс” ассоциацийн гүйцэтгэх захирал Т.Наран “Энэ оныхоос давсан нүүрсний экспортыг ирэх онд хийх гэж байгаа нь боломжгүй” гэсэн.

Өнөөдөр хил дээр коксжсон нүүрс тонн нь 50 орчим ам.доллар. Үгаасан нь 70-80 орчим ам.доллартай тэнцэж байгаа. Тэнцвэржүүлсэн үнээр коксжсон нүүрсний үнийг тонныг нь 81.6 ам.доллар, боловсруулсан нүүрсийг 115.9 ам.доллар гэж төсөвт тооцсон. Энэ нь одоо байгаа үнээс бараг 30 орчим хувиар өсгөнө гэсэн үг юм. Гэвч ирэх жилүүдэд Хятадын хэрэгцээ өсөх бус буурах хандлага ажиглагдсаар. “Fitch” агентлагийнхан “Хятад улс нүүрсний импортоо багасгаж буй. Мөн дотоодын компаниудын өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд үнээ бууруулж байгаа нь дэлхийн зах зээл дээрх үнэ буурахад нөлөөлж байна. Ирэх жил ч энэ байдал үргэлжилнэ” гэжээ.

2014 онд уул уурхайн салбар өсөлтөө хадгалж 14 хувиар өсөх аж. Харин уул уурхайн бус салбарын хувьд долоон хувиар буурах тооцооллыг Эдийн засгийн хөгжлийн яамнаас гаргасан. Ч.Энхбаяр багшийн хэлж буйгаар импортын бууралтаас шалтгаалж дотоод эдийн засгийн хэрэглээ буурах. Цаашлаад уул уурхайн бус салбарын өсөлт саарах эрсдэл байгаа юм.

“Оюутолгой” компани ирэх онд 24.9 тонн алт нэмж экспортлох аж. Ингэснээр алтны татварын орлого 58 тэрбум буюу 48 хувиар өсөх таамаг бий. Ирэх онд “Оюутолгой”-н баяжмалыг оруулаад нийтдээ 1.2 сая тонн зэсийн баяжмал экспортлохоор төлөвлөсөн /экспортын түүхэнд хамгийн өндөр хэмжээ/. Гэсэн ч зэсийн татварын орлого буурахаар байгаа нь өнгөрсөн жил хэт өөдрөг төсөөлсөнтэй холбоотой аж. Төсөвт зэсийн баяжмалын экспортын үнийг байж болох хувилбарт ойртуулсан. Гэхдээ хэмжээ хэт өөдрөг байгаа нь нүүрстэй адил эрсдэл авчирч болзошгүйг зарим эдийн засагч хэлж байгаа юм.

Энэ жил Засгийн газар 0.39 их наяд төгрөгийн татварын орлогыг зэсийн баяжмалаас төвлөрүүлнэ. Энэ нь нэгдсэн төсвийн орлогын зургаан хувийг эзэлж буй. Хэрэв “Оюутолгой” 700 мянган тонноос дээш зэсийн баяжмал экспортолсон тохиолдолд орлогын таван хувь бүрдэх аж. Мөн төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” компани 10 сая тонн нүүрсний экспорт хийснээр төсвийн орлого бүрэн бүрдэх бололцоотой.

Төсвийн гадуурхи санхүүжилтээр гал унтраах арга хэмжээг авч буй нь дунд, урт хугацаанд эдийн засгийг сулруулах магадлалтай аж. Төсвийн эрсдэл уул уурхайн салбартай шууд холбогдож байгаа. Тухайлбал, гадаад эдийн засгийн таагүй нөхцөл байдал төсөвт орлогоор дамжин нөлөөлөх томоохон эрсдэл үүсгээд байна. Тэр тусмаа Олон улсын валютын сангаас дэлхийн голлох зах зээлүүд тэдийлэн сэргэхгүй байх таамаглал дэвшүүлсэн нь “бүсээ чангалах”-д хүргэж мэдэх нь. Мөн гаднын хөрөнгө оруулалт ирэх онд эрс нэмэгдэхгүй байх зураглал гарчээ.

Бас урд хөрш цаашид хүнд үйлдвэрлэлээ хэт нэмэхгүй байх бодлого барьж буй. Энэ нь эрсдэлийн удаах шалтгаан болсоор. Дэлхийн банк манай улсын төсөвт тун сэтгэл дундуур байгаа. Тэдний зүгээс төсвийн орлогыг ухаалаг зарцуулах. Мөн төсөв, мөнгөний бодлогоо чангатгах шаардлагатай гэж сануулсаар буй. Үүнээс гадна Хөгжлийн банк болон Чингис бондын зарцуулалтыг төсөвт хамтад нь авч үзэх ёстойг сануулсаар.

УИХ-ын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга “Өнөөдөр 260 мянган төсвийн ажилтан, 200 мянган тэтгэврийнхэн, мөн тооны оюутан, 300 мянган ажилгүй иргэдийг нэг сая хүүхдүүдтэй нь 320 мянган ажил эрхлэгчийн төрдөө тушаасан татвараар авч явж байна” хэмээсэн. Төсвийн орлого бүрдэх эсэхэд иргэн таны оролцоо чухал гэдгийг энд бас сануулъя. ■



Фотог Б.Бямба-Очир

Зэс бидэнд хөгжих баталгаа болж буй. Энэхүү боломжийг “Оюутолгой” орд олгож байгаа юм.

ОЮУТОЛГОЙ

ЗЭС ШИНЭ РЕКОРД ТОГТООХ УУ

Б.БАЯРТОГТОХ

Улбар шар металл бидний амьдралд оролцох нь эрс нэмэгдэж байгаа. Тэр бол зэс. Дэлхийн эдийн засагт гүйцэтгэх зэсийн үүрэг өнгөрсөн хугацаанд буурсангүй. Тэр тусмаа Монголын эдийн засагт үзүүлэх зэсийн нөлөө улам ч анхаарал татсаар. Дунд болон урт хугацаанд зэсийн үнэ хэрхэн хувьсах нь хэн бүхний сонирхлын төвд ороод байна. Нөгөөтэйгүүр зэс бидэнд хөгжих баталгаа болж буй. Энэхүү боломжийг “Оюутолгой” орд олгож байгаа юм.

Зэс дэлхийн эдийн засгийн хэтийн явдлыг харуулдаг бүтээгдэхүүний нэг. Өнөөдөр эдийн засгийн голлох салбарууд зэсийг түлхүү хэрэглэж байна. Тухайлбал, барилгын салбарт зэсийн ашиглалт өндөр хэвээр. Тэр тусмаа сантехникийн эд анги, цахилгаан дамжуулалт сайтай тул кабель утсыг зэсээр хийдэг. Бүх төрлийн машины үйлдвэр. Түүнээс гадна цахилгаанаар ажилладаг техникүүдийн гол түүхий эд нь мөн зэс юм. Тиймээс зэсийн үнийн өсөлт нь дэлхийн эдийн засгийн хөгжлийн гол хүчин зүйл болдог гэхэд хилсдэхгүй.

Хэрэв дэлхийн эдийн засаг, аж үйлдвэрлэл сэргэвэл зэсийн үнэ дагаад өснө. Ирэх онд тонн зэсийн үнэ 6800 ам.доллар орчим байх төлөвтэй. Үүнээс ч өндөр байна гэж зарим шинжээч таамаг дэвшүүлсээр. Тиймээс зэсийн ханшид гол анхаарлаа хандуулцгаая. Чилийн Төвбанк ирэх онд тонн зэсийн дундаж үнэ 6784 ам.доллар байна гэж төсөөлжээ. Энэ нь 2013 оныхоос 7.5 хувиар бууруулж тооцсон үзүүлэлт юм. Дэлхийн нийт зэсийн хэрэгцээний 32 хувийг дангаараа нийлүүлдэг тус улсын эдийн засаг зэсээс ихээхэн хамааралтай явж ирсэн. Цаашдаа ч ийм байх болов уу. Дэлхийн банк ирэх онд тонн зэсийн дундаж үнэ 7050 ам.доллар байна хэмээн таамагласан. Тэгвэл “Goldman Sachs”-ын шинжээчид тонн нь 6650 ам.доллар байна гэжээ.

Өсөлтийн буухиа

Дэлхийд үйлдвэрлэсэн нийт ▸▸

зэсийн 21 хувийг манай урд хөрш дангаараа хэрэглэж буй. Одоохондоо Хятадын хэрэгцээг “булаах” үлэмж хэрэглээтэй орон хараахан алга. Дэлхий дээр буй цэвэршүүлсэн зэсийн 41 хувийг АНУ, Япон, Өмнөд Солонгос, Герман, Итали, Орос хуваан хэрэглэж байна гэсэн судалгаа бий. Тухайлбал, Япон дээрх зэсийн хэрэглээний долоо, Өмнөд Солонгос таван хувийг тус тус эзлэх аж. Тэгвэл АНУ 13 хувьтай тэнцэх хэмжээний зэсийг хэрэглэдэг байна.

Олон улсын валютын сангийн түүхий эдийн үнийн статистик мэдээллээр 2013-2016 онд зэсийн дундаж үнийн төсөөлөл 7336.2 ам.доллар байх аж. Манай улсын ирэх оны нэгдсэн төсөвт зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 6241.9 ам.доллар байхаар тооцсон. Ингэснээр 1.2 сая тонн зэсийн баяжмал, 3.2 мянган тонн молибдений баяжмал олборлож нийт 273.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх юм.

2015-2020 онд Хятадын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хот байгуулалтын эрчимтэй хөгжлийн үе явагдах аж. Энэ үед зэсийн хэрэглээ дээд цэгтээ тулж, жилд 7.2 сая тоннд хүрэхээр байна. Энэхүү өсөлт нь зэсийн үнэ цэнийг улам нэмэгдүүлэх бололтой. 2020 он гэхэд Хятад, Энэтхэг хоёр улс нийлээд дэлхийн нийт зэсийн хэрэглээний 50 хувийг бүрдүүлнэ гэсэн тооцоог “Рио Тинто” групп хийжээ. Энэтхэг улсын хувьд Хятадын араас нэхэн ирж байгаа томоохон тоглогч. Одоогоор зэсийн нийт эрэлтийн 62 хувийг Ази тив бүрдүүлж байна.

Эрсдэлтэй “тоглоом”

Англиин “CHR Economics” судалгааны байгууллагын мэдээллээр дэлхийн аж үйлдвэрлэл 2014 онд гурван хувиар өсөх аж. Хэдийгээр тийм боловч Хятадын аж үйлдвэрлэл 0.3 хувиар саарахаар байна. Энэ нь зэсийн үнэд эрсдэлийг бий болгож магадгүй нь. Өнгөрсөн оны байдлаар дэлхийн зэсийн үйлдвэрлэлийн нийт хэмжээ 20.3 орчим сая тоннд хүрчээ. Үүний 80 орчим хувийг Хятад, Чили, Япон, ОХУ, АНУ, Герман, Замби, Энэтхэг, Өмнөд Солонгос, Польш зэрэг орон бүрдүүлж байна.

Тэгвэл дэлхийн томоохон Codelco, Phelps Dodge, Rio Tinto, BHP Billiton зэрэг 10 компани нь нийт зэсийн 50 орчим хувийг үйлдвэрлэж буй. Гэхдээ нийт хэрэглээний бараг тэн хагас нь зөвхөн ганц улс /Хятад/-аас хараат байгаа нь ихээхэн эрсдэлийг дагуулж байна. Дэлхийн зэсийн нийт хэрэглээ 20 сая тонн байдаг. Тэгвэл өнгөрсөн оны байдлаар Хятад улс нь дангаараа 40 хувийг хэрэглэжээ.

Нийлүүлэлт огцом өсөх үү

2012-2015 онд дэлхий дахинд нийт 60 гаруй орд шинээр ашиглалтад орохоор байгаа. Эдгээр ордын 11 нь Перуд, 10 нь Канадад, зургаа нь Чили, нэг нь Монголд /Оюутолгой/ байгаа юм. Дэлхийн хөрсөнд нийт гурван тэрбум тонн зэсийн нөөц бий гэж таамагладаг. Мөн далайн гүнд 700 сая тонн нөөц бий гэж судалгааны байгууллагууд үзэж байна. АНУ-ын судалгааны байгууллагуудын үзэж байгаагаар дэлхийн зэсийн тогтоогдсон нөөц 550 сая тонн. Үүнээс нарийн судлагдсан нөөц нь 260 сая тонн.

Канад улсын хараат бус судалгааны “Metals Economics Group” байгууллагын тайлан бий. Түүнд 2010-2011 онд ашигт малтмалын хайгуулын ажилд зарцуулах зардал 45-50 хувиар өссөн. Нийт зардлын 20 гаруй хувийг зөвхөн зэсийн хайгуул, судалгааны ажилд зарцуулсан гэжээ. Судалгааны байгууллагуудын үзэж байгаагаар олборлолт болон ашиглалтын хөнгөн нөхцөлтэй зэсийн орд илрэх магадлал бага. Харин илэрсэн нөөц нь олборлолтын нэлээд их хөрөнгө шаардсан. Мөн хүнд нөхцөлтэй төслүүд байх аж.

Одоогоор илрээд байгаа ордыг ашиглаж, бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах төслийн богино хугацаа нь 2013-2015 он. Түүнээс ч удааширч болзошгүй. Иймд өнөөгийн зах зээлд үүсээд байгаа хэрэглээний өсөлтийг хангах хэмжээний нийлүүлэлт ойрын 4-5 жилд бий болохгүй гэж үзэж байгаа. Тийм бол зэсийн үнэ ч тогтвортой байна гэсэн үг.

Монголын Оюутолгой

Оюутолгой нь дэлхийд нөөцөөрөө үнэмлэхүй хэмжээний орд. Тиймээс Афганистаны Аянак, Перу улсын Лас бамбас ордтой бараг адил аж. 1999-2010 оны хооронд дэлхийн нээгдсэн 62 ордын нийт зэсийн нөөц 229 сая тонн байна. Үүнээс нөөцөөрөө тэргүүлэх ихэнх ордыг нь америкчууд илрүүлсэн байдаг.

“Macguarie Research” компанийн уул уурхайн шинжээч Пирре Вейланкурт дэлхийд нөөцөөрөө тэргүүлэх ордыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд, Оюутолгой / Монгол 36.7 сая тонн /, Pebble /Аляск 36.5 сая тонн /, Удокан /ОХУ 25.7 сая тонн/ багтаж байгаа юм. Pebble нь АНУ-ын Аляскт буй. Энэхүү ордыг 2014 оноос ашиглаж эхлэх төлөвлөгөөтэй байгаа ч олборлолтын нөхцөл хүнд. Үүнээс гадна байгалийн унаган төрхийг эвдэхгүй байх шаардлагын дагуу хугацаа хойшлогдох магадлалтай байгаа.

Удокан нь ОХУ-ын зэсийн нийт нөөцийн 60 хувьтай тэнцэх хамгийн том орд. Тиймээс хэмжээгээрээ дэлхийд гуравт ордог. Удоканы зэсийн орд нь 2010 оны байдлаар нийт 25.7 сая тонн зэс агуулсан 1.8 их наяд тонн хүдрийн нөөцтэй гэж тогтоосон. Тус ордыг ашиглахад Хятадын талаас хөрөнгө оруулж, хамтран ажиллахаар санал тавиад буй.

Судалгаагаар дэлхийн зэсийн үйлдвэрлэлийн томоохон орд газрууд хуучирч эхэлсэн. Мөн уурхайнуудын хүдрийн чанар буурч байгаа. Зэс олборлолтоороо дэлхийд тэргүүлдэг зарим уурхайн олборлолт жилээс жилд багасаж буй нь мэдээж. Энэ нь ойрын хугацаанд зах зээлд зэсийн үнэ өсөх боломжийг олгож байгаа хэрэг. Мөн сүүлийн жилүүдэд зэсийн үнэ өндөр байсантай уялдан энэ салбарын хөрөнгө оруулалт нэмэгдсэн. Тэр хэрээр шинэ төслүүд ихээр хэрэгжиж, 2012 оноос зэсийн зах зээл хомсдолоос илүүдэлд шилжсэн байна. ■



ДЭЛХИЙН ХҮН

ДОРНО ЗҮГИЙН ОХИН

Б.ЭРДЭНЭ

БНСУ-ын анхны эмэгтэй Ерөнхийлөгчийн амьдрал, түүний туулсан зам дардан байгаагүй. Магадгүй өнгөрүүлсэн амьдрал, үзсэн зовлон, шаналсан сэтгэл, шархалсан зүрх нь түүнийг өнөөдрийн өндөрлөгт хүргэсэн байж мэдэх. Гэнэтийн хагацал, харуусал ээлж дараалан тохиосон ч тэр сөхрөн унасангүй. Хөл дээрээ тогтож үлдэв, өнгөрсөн он жилүүдэд. Түүний эцэг Өмнөд Солонгосыг 18 жил удирдсан Пак Чун Хи. Улсаа улс шиг улс болгох гэж зүтгэсэн аавынх нь түүх өнөөдрийн Солонгосын хөгжлийн түүх юм. Цэргийн дэглэм дор хатуу чанга гараар улсаа удирдсан гэж түүнийг үзэх нь бий. Гэвч цаг хугацаа цахилж одох тусам түүний зүтгэлийг улсаараа ойлгож, үр шимийг нь хүртсээр.

Аавынхаа 36 насанд, ээжийнхээ 28 насанд төрсөн айлын ууган охины амьдрал “Хөх ордон”-нд очихоос өмнө эгэл жирийн байлаа. Хожмоо түүний амьдрал жирийн бус зүйлээр дүүрэн өрнөв. Александр Дюмагийн “Шадар гурван цэрэг” зохиолыг унших болгондоо хөөрөл догдлолд автах тэр жаахан охин өнөөдөр улсаа удирдаж байгаа. Гэхдээ тэр жаахан охин байхаа аль хэдийнэ больсон. Тэрбээр ээжийгээ цаг бусаар гэнэт алдсан. Дараа нь бас аавыгаа бусдын гарт. Энэ айлыг гунигийн хар үүл бүрхэн байсан хүнд жилүүд холдож одсон ч сэтгэлийн шарх аниагүй юм. “Захиа гэрээслэлийн нэг ч үг үлдээлгүй нас барсан ээжийг бодохоор цээж урагдах мэт янгинана” хэмээн Пак Гынхе харууссан байдаг. Түүний элэг бүтэн амьдрах цагийг тасалдуулсан буруутан нь Хойд Солонгосчууд гэх. Гэвч үндэс нэгт ахан дүүстээ тэр бурууг өгдөггүй.

Төрөлх тосгондоо амар жимэр аж төрөн суух аавынх нь мөрөөдөл байсан. Ээж нь мөн адил ач зээ нараа харан баясах тэр цагийг хүлээдэг байв. Тэд ийм цагаас эрт буцсан нь одоо ч сэтгэл үймрүүлдэг болохыг Пак Гынхе өөрийн “Цөхрөл намайг хатуужуулж, Найдвар намайг урагшлуулдаг” намтар номондоо дурджээ. Тэрбээр “Надад шинэ үүрэг оногдов. Хорин хоёрхон настай би гэдэг хүн ээжийн оронд тэргүүн хатагтай боллоо” гэж номынхоо “Ширүүн давалгааны өөдөөс” гарчиг дор өгүүлсэн байдаг. Тэр ээжийнхээ өмнөөс улсаа төлөөлөх эрх бүхий тэргүүн хатагтай болж байсан юм. “Хөдөлмөрч шувуу шинэ хоол иддэг”. Түүний ээж ийм сургадаг байсныг Пак Гынхе дээрх номондоо дурджээ. Эдийн засаг нь мөлхөж байсан улсаа өөд татах гэж түүний аав бие сэтгэлээ харамгүй зориулсныг энд дахин тэмдэглэе.

Хөх ордон

Пак Гынхе. Тэр бага насаа Хөх ордонд өнгөрүүлсэн. 15 жил энд амьдран суухдаа нэг л удаа аав ээжийгээ ихэд баярлуусан аж. Энэ нь сургуулийнхаа шилдэг төгсөгч болсон явдал байв. Төдийлэн сэтгэл хөдлөлөө гаднын хүнд үзүүлээд байхгүй аав нь хүртэл охиныхоо амжилтыг Тамгын газрын даргадаа хөөрөн өгүүлсэн байна. Англи, Франц, Испани, Хятад хэлтэй Өмнөд Солонгосын шинэ удирдагч “Гадаад хэл миний амьдралын чанарыг дээшүүлэх хэрэгсэл байсан юм” гэжээ. Солонгосын Соганы их сургуулийн Электрон инженерийн ангийг төгссөн. Үүний дараа Францад маш богино хугацаанд суралцсан гэж хэлж болно. Алхам тутам Ерөнхийлөгчийн охин гэсэн нэр хүнд басхүү дарамт энэ бүхнээс Францад түр ч болтугай чөлөөлөгдсөн. Энд гадаад оюутнууд олон байснаас тэр үү “Дорно зүгийн охин” гэж анхааран сониучирхах хүн цөөн байж. Пак Гынхе энд зургаахан сар болоод Хөх ордонд дуудагдсан.

Аавыгаа дурсахад…

“Цаг хугацаа хурдан өнгөрчээ. Аав, эх орон БНСУ-ынхаа төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэсэн. Миний хувьд аав минь тийм л хүн байв. Аавын минь тархи толгойд “эх орноо орчин үежүүлэх” гэдэг бодол салахгүй эргэлдэж байсан тухай Пак Гынхе дурссан байдаг. Тэр аавынхаа тухай “Үндэсний удирдагч” гэдэг ном хэвлүүлсэн. Мөн “Эх орны гэрэл гэгээ” хэмээх киног хийжээ. Зорилго нь аавынхаа үйл хэргийг дахин үнэлж цэгнэх. Бусдад таниулах байв. Нөгөөтэйгүүр аавынх нь эсрэг түгсэн улс төрийн ташаа мэдээллийг үгүйсгэх. Үнэн зөв ойлголтыг өгөхөөр зорьжээ.

Нам гүм дундаас

“Хүмүүст аажим аажмаар мартагдах тусмаа би амар амгаланг олсон юм” гэж Өмнөд Солонгосын одоогийн Ерөнхийлөгч бичсэн байдаг. Ерөнхийлөгчийн охин гэсэн алдар нэр хүнд бас хүндлэл заримдаа зовлон шаналал болж байсан. Үүний зэрэгцээ аавынх нь эсрэг ажиллагаа Пак Гынхегийн амьдралд багагүй саад болсныг өөрөө ч хэлсэн байдаг. Гэсэн ч тэр дахин тэмцэх, улс төрд эргэлт буцалтгүй орох тэнхээг энэ хугацаанд олж авч чаджээ. “Дүн өвлөөр ч ногоон дээлээ тайлдаггүй нарсан ойн дундуур алхаж явахдаа аз жаргал гэж ийм юм байдаг болов уу” хэмээсэн Пак Гынхе бичгийн хүн. Өөрийнхөө амьдрал, үзэл бодлоо шингээсэн “Эгэл жирийн айлд төрсөн бол...” номоо бичиж гаргасан. Дараа нь “Эрхэм чухаг амьдрал” номоо хэвлүүлж, нэг л мэдэхэд би Зохиолчдын эвлэлийн гишүүн болсон байлаа хэмээн дурссан нь бий.

Залуу насны бүтээгүй мөрөөдөл

Тэр ганц бие бас хүүхэдгүй. Энэ тухайд “”Ижий минь тэгээд өнгөрчихөөгүй бол би бусдаас өөрцгүйгээр, хүнтэй суун үр хүүхэдтэй болж, гэрийн сайн эзэгтэй болох байсан ч байж мэдэх юм. Гэвч тийм амьдрал миний хувьд залуу насны минь бүтээгүй мөрөөдөл төдий болсон. Ээжийнхээ хоосон зайг орлон тэргүүн хатагтайн үүрэг гүйцэтгэх гээд завгүй байсан. Ийм болохоор хүнтэй хайр сэтгэлийн холбоотой болох ч юм уу, гэрлэх тухай бодох ч сөхөө байсангүй. Их сургуулийн оюутан байхдаа Ерөнхийлөгчийн охин гэдгээсээ болоод алхам бүрээ хянадаг байв. Тэгээд л миний амьдралд хайрын дурсамж гэхээр юм нэг ч үлдсэнгүй” хэмээн дөч гарсан хойноо өгүүлсэн байдаг.

Улс төрч Пак Гынхе

Тэр ийм замаар замнахаар зориг шулуудсан юм. Өөрөөр хэлбэл, БНСУ-ын хөгжлийн төлөө үлдсэн амьдралаа зориулахаар шийдсэн нь энэ. “Миний давах ёстой уул хэчнээн бартаатай, хэчнээн хэцүү байсан ч хойш суухгүй, бэргэж халгахгүй гэж шийдээд улс төрд хөл тавьсан юм” гэж Пак Гынхе хэлсэн байдаг. Түүний хувьд ингэж шинэ амьдрал эхлэв. Түүх давтагдлаа. Солонгост 1997 онд болсон валютын хямрал Пак Гынхегийн улс төрд орох нэг талаасаа үүдийг нээсэн гэж хэлж болохоор. “Яаж босгосон улс билээ. Яахаараа ийм амархан нурдаг билээ” гэж бодохоос энэ хорвоо үнэхээр цэвдэг санагдана гэж тэрбээр цухалдсан удаатай.

Пак Гынхе улстөрийн амьдралаа Ханнара намаас эхлэв. “Ард түмнийхээ төлөө гэсэн үзэл баримтлалаасаа алхам ч ухрахгүй” гэж тэр хэлдэг. Үүнийхээ төлөө ч бат зогсдог. Улс төрд баттай хөл тавимагцаа тэр шинэчлэл хийсэн хэлж болохоор. Өөрөөр хэлбэл, итгэл алдаад байсан Ханара намд “амь тариа” болсон аж. “Живэх гэж буй хөлөг онгоцны дарга болов” гэж өөрийн дурсамждаа бичсэн нь бий. Түүнчлэн улс төр дэх эмэгтэйчүүдийн хаалгыг тэрбээр зоримог нээсэн. Ингэснээр жендер тэгш бус Өмнөд Солонгост эмэгтэйчүүдийн манлайлал эхэлсэн гэж үзэж болно.

Эдүгээ шүүгч, прокурорын албан тушаалд ажиллагсдын тавь хүртэлх хувь нь эмэгтэйчүүд болжээ. Мөн сансрын эмэгтэй нисгэгч хүртэл бэлтгэгдсэн гээд нийгэмд тэгш оролцоо бий болсон байна. Үүнд түүний гүйцэтгэсэн үүрэг багагүй байсныг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Пак Гынхе сайн улс төрч төдийгүй сайн менежер гэж үзэж болохоор. Удаа дараа ялагдал хүлээгээд байсан намдаа шинэ суудал авчирсан. Мөн намынхаа шинэ түүхийг эхлүүлсэн гээд амжилт их. Одоо түүний бүтээх түүх бол Өмнөд Солонгосын шинэ түүх юм. Домог болох удирдагч гэж түүнийг үздэг. Аль ч талаас нь авч үзсэн Өмнөд Солонгосын анхны эмэгтэй Ерөнхийлөгч түүхэнд үлдэх тодорхой. Гэхдээ ямар Ерөнхийлөгч байх нь түүнээс ихээхэн хамаарах нь дамжиггүй.

Ерөнхийлөгчийн бодлого

Өмнөд Солонгос хөгжлийн үзүүлэлтээрээ Азид төдийгүй дэлхийд нэрээ гаргасан. Гэвч энэ байр сууриа хадгалж үлдэх эсэх нь эргэлзээ төрүүлсээр буй. Тус улсын эдийн засгийн өсөлт саарч, ажилгүйдэл нэмэгдэж байгаа нь санаа зовоох асуудлын нэг юм. Мөн дотоодын томоохон үйлдвэрлэгч компанийн ашгийн хэмжээ жилээс жилд буурч байгаа нь Солонгос цаашдаа хэрхэн хөгжих вэ гэсэн эрэлд мордуулж мэдэх. Ийм нөхцөлд Ерөнхийлөгчийн бодлого хэрэгжинэ. Пак Гынхе том компанид бус жижиг, дунд үйлдвэрлэгчдэд боломж олгохуйц бодлого барьж буй.

Мөн боловсрол, эрүүл мэндийн салбарт хандах үзэл баримтлал нэн эртнээс түүнд суусан. Үүнээс гадна гадаад харилцааны өргөн туршлагатай гэж хэлж болох Пак Гынхе Япон болон Хятадтай илүү тааламжтай, эдийн засгийн шинэ харилцааг тогтоох. Цаашилбал, хоёр Солонгосын харилцаанд “хаврын урь” мэт эрс өөрчлөлтийг авчирна гэж найдаж буй. Түүний эцэг Хан мөрний эрэгт эдийн засгийн хүчирхэг орныг босгосон. Тэгвэл охиных нь бодлого улсаа хэрхэн хөгжүүлэхийг харах үлдлээ. ■

UN-REDD PROGRAMME

UNDP Mongolia

ОЙГ ДЭД БҮТЦИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НЭГ ХЭСЭГ БОЛГОН ҮЗЭХ НЬ

Дэлхийн олон улс орон, эрдэмтэн мэргэд, байгаль орчны төлөө дуу хоолой, ажил хөдөлмөрөө зориулдаг идэвхтнүүд агаар мандалд ялгарах хүлэмжийн хийн хуриммтлалыг бууруулах нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах хамгийн чухал үйл ажиллагаа гэдгийг хүлээн зөвшөөрч буй. Тиймээс 1992 онд уур амьсгалын тогтолцоонд аюул занал учруулахаас урьдчилан сэргийлэх, агаар мандал дахь хүлэмжийн хийн хуриммтлалыг тогтворжуулах, бууруулах зорилготой Нэгдсэн үндэстний байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь Конвенцийг баталсан билээ. Конвенцийн дэргэдэх Засгийн газар хоорондын Зөвлөлийн 2004 онд хийсэн судалгааны тайлангаас харахад дэлхийн ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй агаар мандалд ялгарах хүлэмжийн хийн хэмжээ хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй ялгарч буй нийт хүлэмжийн хийн 17.4 хувийг (IPCC, 2007) эзэлж байна. Конвенцийн хүрээнд, ялангуяа, хөгжиж буй улс орнуудын ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийг бууруулах, ойн нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх, хадгалах үйл ажиллагааг урамшуулах зорилго бүхий REDD+ механзмыг хэрэгжүүлэх санаачлагыг дэмжсэн байдаг.

2008 оноос НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ), Байгаль Орчны Хөтөлбөр (НҮББОХ)-ийн хамтарсан UN-REDD хөтөлбөр хөгжиж буй орнуудыг REDD+-д бэлтгэхэд нь туслахаар хэрэгжиж эхлээд байна. Энэхүү хөтөлбөрт Монгол Улс 2011 оны зургаадугаар сараас элсэн нэгдэж, UN-REDD хөтөлбөрийн түнш орон болсноор REDD+-д бэлтгэхтэй холбоотой олон үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Үүний нэг нь 2012 онд Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ) Үндэсний REDD+-д бэлтгэх төлөвлөгөө (National REDD+ Readiness Road-map in Mongolia)-г НҮБХХ, ХХААБ-ын техникийн тусламжтайгаар амжилттай боловсруулсан явдал юм. Цаашлаад 2013 оны эхний хагаст НҮБХХ-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас Манай орны ойн салбарын санхүүгийн урсгал, эдийн засгийн үнэ цэнэ, үнэлэмж судалгааг хийсэн. Монгол орны ойн салбар нь байгаль орчны болон бусад салбаруудтай харьцуулахад Ногоон хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд төдийгүй, улс орны ДНБ-д оруулах хувь нэмэр төдийлөн өндөр биш мэтээр олон нийтэд ойлгогддог. Иймээс ойн салбарын экологийн үнэ цэнэ болон нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмэр, салбарын төсвийн хуваарилалтын талаар олон нийт, шийдвэр гаргагчид, гадаад, дотоодын хандивлагчдад үнэн зөвөөр ойлгуулахаар дээрх судалгаа хийгдсэн. Түүний гол үр дүнг энэхүү өгүүллээр дамжуулан та бүхэнд хүргэж байна.

Дэд бүтэц гэдгийг бид нийгмийн эсвэл аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай барилга байгууламж, үйлчилгээ, тоног төхөөрөмж гэж тодорхойлон ойлгодог. Түүнчлэн дэд бүтцийн хангамж ба хүртээмжтэй байдал нь эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах үйл ажиллагааны гол цөм гэж үзэх нь улам бүр нэмэгдсээр байгаа. Энэ нь ч зүйн хэрэг юм. Монгол Улсад дэлхийн бусад улсын адилаар үндэсний хэмжээний дэд бүтцийн суурийг сайжруулах, өргөжүүлэхэд хувийн хэвшлийн болон төрийн хөрөнгө оруулалтыг дайчлах нь нэн тэргүүний асуудал болж байна.

Цөөн хүмүүс орон сууц, зам, гүүр, харилцаа, эрчим хүч, усан хангамж зэрэг зүйлс нь хүний сайн сайхан амьдрах, эсвэл эдийн засгийн хөгжлийг харьцуулахад чухал гэдгийг хүлээн зөвшөөрөх байх. Энд нэмэхэд хүрээлэн буй байгаль орчин нь баригдсан дэд бүтэцтэй яг адилаар эдийн засгийн өсөлт, хөгжилд шаардлагатай үйлчилгээнүүдийг хүргэж байдаг юм шүү. Дэд бүтцийн талаарх уламжлалт тодорхойлолт нь (мөн түүнд оруулсан асар их хөрөнгө оруулалтууд нь) ийм “байгалийн” дэд бүтцийн үнэ цэнийг үл хайхарч ирсэн ба энэ нь эдийн засагт маш их сөрөг нөлөөтэй гэдэг нь батлагдсан.

Монгол Улсын ой мод нь үүний нэг жишээ юм. БОНХЯ-ны Ойн судалгаа, хөгжлийн төвийн гаргасан сүүлийн тоо баримтаар ой мод нь улс орны нийт газар нутгийн 12 хувь буюу 185,000 ам метр талбайг эзэлж байна. Хойд хэсэгт орших сэрүүн бүсийн шилмүүст болон навчит ойд шинэс, хус, нарс, улиас, хуш зэрэг зүйлс давамгайлдаг бол өмнө зүгийн Говийн бүс нутаг нь заг зэрэг бутлаг ургамлаас бүрддэг.

Энэ салбарын ДНБ-д эзлэх хувийг ажиглахад (одоогоор 0.5 хувиас доош – ойролцоогоор 70 тэрбум төгрөг буюу 40 сая ам. доллар байна) ой мод нь үнэ цэнэ багатай эсвэл бараг үнэ цэнэгүй мэт харагддаг. Харин бодит байдал үүнээс шал өөр байна. НҮБХХ-өөс саяхан хийсэн судалгаанд сонгож авсан сэрүүн бүсийн шилмүүст болон навчит ой нь үндэсний эдийн засагт жилд 430 тэрбум төгрөгийг оруулах боломжтойг тооцож гаргасан. Энэ тоо нь ДНБ-ий “албан ёсны” тооцооллоос зургаа



Фотог П.Жаргалсайхан

дахин илүү байгаа юм (НҮБХХ-ийн судалгаанд одоогийн байдлаар зөвхөн үнэлгээнд оруулах боломжтой ой модыг оруулсныг тэмдэглэх нь зүйтэй. Үүнд: хэрэглээний болон түлээний мод, зэрлэг амьтан, ургамал, бэлчээр, аялал жуулчлал, усны эх үүсвэрийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах зэргийг хамруулсан. Иймээс энэ тоог хамгийн багаар тооцоолсон гэж үзэх хэрэгтэй).

Гол асуудал нь Монгол Улсын ой мод эдийн засгийн үнэ цэнэ багатайд байгаа юм биш, харин энэхүү үнэ цэнийн талаарх ойлголт муу байгаад оршиж байгаа юм. Ингэснээрээ энэ нь эдийн засгийн гүйцэтгэлийг хэмжихэд ашиглагддаг статистикт тусгагдахгүй үлдсээр ирсэн. Эдийн засагчид байгаль орчны мөнгөн үнэлгээг тооцоолохдоо түүний гаргаж буй түүхий эд материал болон биет үр дүнг л тооцдог. Иймээс ДНБ-ийг тайлагнаж буй тооцоолол нь зөвхөн модны үйлдвэрлэлийн нэмүү өртгөөс хэтэрдэггүй.

Байгаль орчны үнэ цэнийг ийнхүү хязгаарлагдмал байдлаар үнэлэх нь түүний эдийн засагт үзүүлэх “жинхэнэ” үнэ цэнийг дутуу үнэлэхэд хүргэдэг. Түүнчлэн энэ нь шийдвэр гаргахдаа дутуу эсвэл буруу мэдээлэл дээр үндэслэн гаргах эрсдлийг дагуулдаг. Ойн үнэ цэнийг тооцоолон гаргахад арилжааны болон олборлох зорилготой хэрэглээ нь зөвхөн мөсөн уулын орой л гэсэн үг юм. Хэрэглээний болон түлээний мод бэлтгэлийн албан ёсны орлого нь уг судалгаанд тооцоолсон хэмжээний талаас доогуур хувийг эзэлж байна. Хамгийн их хувь нь буюу жилд 235 тэрбум төгрөгөөс илүү нь ойн салбараас бусад салбаруудад, бусад үйлдвэрлэлийн явцад оруулдаг хувь нэмрээс бүрдэнэ.

Эдгээр эдийн засгийн үр ашиг нь зөвхөн мод бэлтгэх, мод боловсруулах үйлдвэрлэлийн харьцангуй цөөн тооны үйлдвэрлэгчид биш, маш олон төрлийн хэрэглээ болж өөр өөр түвшинд хуваарилагддаг. Өрхийн түвшинд авч үзвэл хөдөөгийн малчин өрхөд ой модны эх үүсвэрээс бий болох түлш, бэлчээр, ойн баялгаас гаралтай хоол хүнс зэргээс бүрдэх нийт нэмүү өртгийн хэмжээ нэг хүнд ногдох ДНБ-ны 12.5 хувиас илүү хувийг эзэлж байна гэж тооцоолжээ. Туул голын эхийг хамгаалж буй ой модны үнэ цэнэ Улаанбаатар хотын ундны ус хэрэглэгчдэд 30 тэрбум төгрөгийн үнэ цэнэтэй бол ой модны ойролцоох амралт зугаалга нь аялал жуулчлалын салбарт болон тэнд амрагчдын зардал, ажиллагсдын цалинд 40 тэрбум төгрөгийг оруулж байна. Нүүрстөрөгчийг шингээснээрээ, Монгол Улсын ойн дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад оруулж буй хувь нэмэр нь жилд 80 тэрбум орчим төгрөг болж байна.

Ой модыг хамгаалахад хөрөнгө оруулах нь зөвхөн биологийн эсвэл экологийн асуудал биш, мөн эдийн засгийн асуудал гэдэг нь тодорхой юм. НҮБХХ-ийн судалгаанд ой модны салбарт хөрөнгө оруулах нь илүү хөгжил, эдийн засгийн илүү их үр өгөөжийг авчирдаг гэдгийг харуулсан. Одоогийн санхүүжилтийн түвшинд, ойн салбарт оруулсан нэг төгрөг бүр Монголын эдийн засаг, хүн амд жил бүр 30 төгрөгийн хувь нэмэр оруулахаар байна.

Гэсэн хэдий ч ойн салбарын эдийн засгийн энэхүү өндөр үнэлэмжийг үл харгалзан, тус салбарын төсөв харьцангуй бага хэвээр байсаар байна. БОНХЯ-нд хуваарилж буй төсвийн хувьд ч гэсэн бага, мөн аймаг, сумын засаг захиргаанаас хэрэгжүүлж буй анхан шатны үйл ажиллагаанд зарцуулж буй төсөв ч гэсэн бага хэвээр байна. НҮБХХ-ийн судалгаагаар ойн менежмент, хөгжил, хамгаалал, судалгаанд жилд хуваарилж буй санхүүжилт нэг га тутамд 1,250 төгрөг байгаа нь Азийн болон дэлхийн дунджаас харьцангуй доогуур үзүүлэлт юм (НҮБ-ын ХХААБ-ын мэдээгээр энэ дундаж Азид 34,000 төгрөг, дэлхийд 12,750 төгрөг байдаг).

Эцсийн үр дүндээ ойн салбарт төсвийн хомсдол үргэлжилсээр байгаа ба энэ салбарын зайлшгүй чухал үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээнд шаардлагатай төсөв хангалтгүй байна. Монгол Улсыг цаашид хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай дэд бүтцийг барьж байгуулахад асар их хэмжээний хөрөнгө мөнгө урсан орж байхад байгалийн ийм чухал дэд бүтэц хөрөнгө оруулалтын гадуур үлдэж байна. Үүний оронд “сөрөг хөрөнгө оруулалтын” үйл явц буюу биет дэд бүтцийг барьж байгуулах, өргөжүүлэх явцад ой мод, бусад экосистем устаж үгүй болох, доройтох, биет дэд бүтэц болгож хувиргах үйл явц ажиглагдаж байна.

Тэгэхээр бидний өмнө тулгараад байгаа үндсэн сорилт бол Монгол Улсын байгалийн арвин нөөц баялаг, тэдгээрийн ач холбогдол одоогоор хэт доогуур үнэлэгдэж байгааг хэрхэн шийдэх вэ, экосистемд дэд бүтэцтэй хэрхэн ижил түвшинд хөрөнгө оруулалт хийх вэ? Хэрэв ойн салбарын эдийн засгийн үр ашгийг бүрэн ашиглахыг зорьж байгаа бол – байгаль орчны өртөг, үр ашгийг эдийн засаг ба төсвийн талаар шийдвэр гаргах суурь болгож өгөх. Энэ тооцоололд тусгаж чаддаггүй байдлаас гарч байгаль орчны экосистемийг үнэ цэнэ өндөртэй, үйлдвэрлэл, хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөг болох, ийм өөрчлөлтийг хийх шаардлагатай юм. Эдийн засгийн талаас нь авч үзвэл, эдийн засгийг ирээдүйд хөгжүүлэх, өсөлтийг хангахын тулд экосистемийг – нийгмийн үйл ажиллагаанд шаардлагатай барилга байгууламж, үйлчилгээ, тоног төхөөрөмж зэрэг дэд бүтцийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдтэй ижил түвшинд авч үзэх ёстой юм. ■

Since 1997

ITZone®

Accelerate Your Success

Happy New Year 2014



Шинэ жилийн шилдэг бэлэг таны сонголтоор...



Худалдан авалтын үнийн дүнгээс хамаарсан бэлгүүд

store.itzone.mn /ITZoneStore 7731-2424

eznis airways

EZ BIZ service

Eznis Airways offers its **EZ BIZ service** to cater to the needs of organizations and companies whose staff frequently travel within Mongolia for business purposes.



- ✓ Flexible Reservation Conditions
- ✓ 20kgs of Free Baggage Allowance
- ✓ Easy payment conditions

Ticket office:
8 Zovkhis Building, 1st floor, Seoul street 21, Sukhbaatar district,
Ulaanbaatar 14251, Mongolia
Res: 7575-3232
Tel: 7575-7791, 9910-1391, E-mail: sales@eznis.com

www.eznisairways.com

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Л.ДУЛМААЗУЛ:

SMBC МОНГОЛЫН ТОМ ТӨСЛҮҮДИЙГ СОНИРХОНО



Фотог Э.Зоригт

Д.БЭХЭЭ

Япон улсын SMBC (Sumitomo Mitsui Banking Corporation) банк манай улсад саяхан төлөөлөгчийн газраа нээлээ. Энэ нь манай улс дэлхийн санхүүгийн томчуудын сонирхлыг татаж эхэлснийг илтгэж буй.

Дэлхийд нэртэй SMBC-ийн төлөөлөгчийн газрыг эх орондоо нээж, том төслүүдийг санхүүжүүлэх ажилд Л.Дулмаазул хучин зүтгэжээ. Багаасаа хилийн чанадад өссөн тэрбээр Чехийн Карлын их сургууль, Токиогийн Олон улсын харилцааны сургуулийг дүүргээд, Оксфордын их сургуульд санхүүгийн чиглэлээр магистр хамгаалсан юм билээ. Тэрбээр одоо Лондон дахь SMBC банкны салбарт зээлийн мэргэжилтнээр ажиллаж байна.

100 сая ам.доллараас дээш дүнтэй томоохон төслүүдэд хөрөнгө оруулахыг сонирхож Монголд үүдээ нээсэн Японы банкны “монгол төлөөлөгч” эх орныхоо томоохон төслүүдийг санхүүжүүлэхэд хувь нэмрээ оруулах чин хүсэлтэйгээ ярьж байна. Монголын хэл шинжлэлийн ухааны доктор Лувсандорж гуайн охин тэрбээр Лондон дахь Англи-Монголын худалдааны зөвлөлийн тэргүүн, “Европ дахь монгол эмэгтэйчүүдийг хөгжүүлэх” холбооны удирдах зөвлөлийн гишүүний алба хашдаг юм билээ. Л.Дулмаазултай SMBC банк Монголд салбараа яагаад нээх болсон, манайхантай хэрхэн хамтарч ажиллах талаар ярилцлаа.

-Монгол Улсад төлөөлөгчийн газраа нээсэн гадаадын том банкуудаас танайх юугаараа онцлогтой вэ?

-SMBC нь Монголд Төлөөлөгчийн газраа нээж буй гадаадын дөрөв дэх, Японы анхны банк юм. Манай банк хөрөнгийн хэмжээгээрээ Японд хоёрдугаарт, дэлхийд есдүгээрт эрэмбэлэгддэг. SMBC нь дэлхийн өнцөг булан бүрт, тэр дундаа Ази, Африкийн буурай орнуудын уул уурхай, цахилгаан станц, дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлдэг. Тэр бүр нь тухайн улсын эдийн засагт томоохон нөлөө үзүүлж байснаараа онцлогтой. Сүүлийн жилд Европын банкуудын хөрөнгийн эх үүсвэр багассанаас шалтгаалж Японы банкуудын нэр хүнд эрс өссөн. Том төслүүд санхүүжүүлдэг банкны хувьд хамгийн нэр хүндтэй "Global Bank of the Year" шагналыг 2010 онд гардсанаар Европ, АНУ-ын банкуудыг гүйцэж чадсан. Япон бол асар их хөрөнгийн нөөцтэй орон. Хүмүүс нь банкинд их хэмжээний мөнгөн хадгаламжтай болох тусам банкуудын хөрөнгийн эх үүсвэр нэмэгддэг. Том төслийг санхүүжүүлэх нь бүтээн байгуулалтад тусална гэсэн үг. Тусална гэдэг бол сайн санаа. Тэгэхээр SMBC нь сайн санааны банк юм. Тухайлбал, Тавантолгойн цахилгаан станц зэрэг том төслийн санхүүжилтийг шийдсэнээр бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, улс орны хөгжлийг хурдасгах давуу талтай. SMBC "Буух эзэнтэй, буцах мөртэй" төсөлд хөрөнгө оруулах зарчим баримталдаг.

-SMBC банкны төлөөлөгчийн газрыг Монголд нээхэд таныг багагүй үүрэг гүйцэтгэсэн гэж сонссон.

-Би SMBC банкны Лондон дахь салбарт Европ, дундад Ази болон ОХУ-ын дэд бүтэц, эрчим хүч, газрын тосны томоохон төслүүдийг хариуцан ажилладаг. Эдгээр орны эдийн засгийн нөхцөлтэй нь газар дээр нь очин танилцаж, зах зээлийн судалгаа хийсний үндсэн дээр санхүүжилт өгөх эсэхийг шийддэг. Манай банкнаас зээл олгосон гаднын олон том төсөл амжилттай хэрэгжсэнээр тухайн орны хөгжил урагшилж байгааг нүдээр харсан. Тиймээс эх орондоо том зээлийн санхүүжилт олгох ажлыг хиймээр санагддаг болсон. Ялангуяа Казахстан, Туркменистан улсад олгосон зээлийг Монголдоо оруулж, эх орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах хүсэл төрсөн. 2011 онд банкныхаа төсөл хариуцан ажилладаг англи бүсгүйтэй хамт Монголд ирж, ЭЗХЯ, Хөгжлийн болон бусад банк, томоохон компаниудын төлөөлөлтэй уулзаж, том төсөл санхүүжүүлэх боломж, нөхцөлийг судалсан. Дараа нь Монголын эдийн засаг, бизнесийн орчин, хөрөнгө оруулалт, том компаниудын тухай сурвалжлага бичиж, банкныхаа салбар бүрт тараасан юм. Үүнээс хойш SMBC банкны мэргэжилтнүүд манай улс руу явахыг ихээхэн сонирхох болж, Сингапур, Токио, бүр Нью-Йоркийн салбарынхан ч байнга ярьдаг болсон. Би хоёр жилийн дотор 10-аад удаа банкны төлөөллүүдээ дагуулан ирсэн. Мөн монгол компаниудын хэд хэдэн томоохон төслүүд дээр ажиллаж эхэлсэн. Анх Хөгжлийн банктай гэрээ хийхээс эхлэн ХААН банк, Худалдаа хөгжлийн банктай хамтран ажиллаж эхэлсэн. SMBC банкныханд Монголыг "сонирхуулахын" тулд банк дотроо улсынхаа нэр хүндийг дээшлүүлэх хэрэгтэй байсан. Ази, Африкийн бусад оронтой харьцуулахад "Moody's", "Standard & Poor's" агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг дээшлүүлэхгүй, доошлуулж байхад SMBC банк "Монгол бол удаан хугацаанд ирээдүйтэй" гэж үзэн манай улсад оруулах хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлсэн. Эдийн засгийн хүнд үед хэдийгээр би дотор нь ажилладаг ч гэсэн гадаадын том банкинд улсынхаа нэрийг дээшлүүлнэ гэдэг тийм ч амар байгаагүй.

Манай улсад хэрэгжиж буй, цаашид хэрэгжих том төсөл олон бий. Тэдгээр төсөл нь улс төрөөс их шалтгаалдаг, хэрэгжилтийн явц удаан юм шиг байна. Тухайлбал, манай банкны оролцох, бүтээн байгуулалцахыг хүссэн Оюутолгой болон Тавантолгойн цахилгаан станцын төслийн явц удаан байгаад жаахан сэтгэл дундуур байна.

-Том хэмжээний төслүүд санхүүжүүлэх гол зорилго агуулж байгаа гэлээ. Яагаад заавал томоохон төслүүдийг онцлов. Ер нь төслүүдийг санхүүжүүлж хамтран ажиллахад танай банк ямар шалгуур тавьдаг вэ?

-Томоохон хэмжээний төсөл гэдэг нь нэгдүгээрт, тухайн улсын эдийн засагт өндөр өгөөжтэй байх. Хоёрдугаарт, их хэмжээний хөрөнгө оруулалт хийхэд банк эрсдэлд орохооргүй нөхцөл бүрдсэн байх. Гуравдугаарт, олон улсын хууль зүйн хүрээнд хариуцлага хүлээх найдвартай эзэнтэй байх гэсэн шаардлага тавьдаг. Бусад төслийг санхүүжүүлэхэд дотоодын банкуудын тусламж хангалттай гэж үздэг. Өмнө нь хэлсэнчлэн манай банк том төслүүд хэрэгжүүлсэн олон жилийн туршлагатай. Тиймээс Монголд туршлагаа нэвтрүүлж, Монголын хөгжилд хувь нэмрээ оруулах сонирхолтой банк гэж ойлгож болно. Мөн энэ жил Япон-Монгол хоёр орны хооронд Засгийн газрын хэмжээнд айлчлалууд өрнөсөн тэдийгүй Японы Засгийн газраас манай улсыг дэмжих сонирхолтой байгаа нь томоохон түлхэц болсон.

-Танай банктай хамтарч буй Монголын ямар төслүүд байна вэ?

-Одоогоор Оюутолгойн далд уурхайн санхүүжилтэд гадаадын бусад банкуудын адил зээл олгох санал тавьж, дотоод зөвшөөрлөө авсан. Уул уурхайгаас гадна цаашид дэд бүтэц, эрчим хүч, зам тээвэр, үйлдвэржилт зэрэг өргөн хүрээтэй чиглэлээр хамтарч ажиллах сонирхолтой байгаа. Монголд хэрэгжиж буй төслүүдээс Тавантолгойн цахилгаан станцын төсөлд Монголын Засгийн газрын талын зөвлөгчөөр ажиллаж, нэг тэрбум ам.долларын хөрөнгө босгоход нь тусалж байна. Түүнчлэн ДЦС-V гээд яригдаж байгаа төслүүд бий. Том төслүүдэд зөвхөн санхүүжилт хэрэгтэй болсон үед нь биш, эхнээс нь оролцон бүтэцчилсэн схем гаргаж, шаардлагатай төслүүдийг дэмжин хөгжүүлж ажиллах нь зүйтэй байдаг. Тиймээс ч зөвлөх, санхүүжүүлэхийг хослуулах нь ач холбогдолтой.

Гэхдээ бид зөвхөн том төслүүдийг хүлээгээд суух биш, худалдааны

санхүүжилт, банк хоорондын, уул уурхайн салбарын зээл болон ногоон хөгжлийн төслүүдэд анхаарлаа хандуулж байгаа. SMBC нь 2012 онд Дэлхийн тогтвортой хөгжлийн банк гэсэн шагнал хүртсэн “ногоон” банк юм.

-Лондоны SMBC банкинд зээлийн баталгаа гаргах талд түлхүү ажилладаг юм байна. Том хэмжээний төслүүдэд баталгаа гаргах асуудал хамгийн хэцүү бөгөөд чухал нь байх, тийм үү?

-Зээлийн баталгаа бол итгэл үнэмшил юм. Итгэл үнэмшил бий болгоход хөрөнгө хүсэгч, хөрөнгө оруулагч хоёр талын хоорондын ойлголцол чухал. Хөрөнгө хүсэгчтэй болж өгвөл эх хэлээр нь харилцвал сайн байдаг. Тухайн хүнийг таньж, мэдэхэд эх хэлээр нь харилцах нь ач холбогдолтой.

Хөгжиж буй орнуудын том төслүүдэд банкууд баталгаагүй зээл бараг өгөхгүй. Миний хувьд тэдгээр орны төслийг хэрхэн хийвэл санхүүжүүлж болох санааг гаргадаг. Түүнчлэн баталгаагүй, зээл олгоход бэрхшээлтэй орнуудад Дэлхийн банк, агентлагуудын болон хувийн даатгалын компаниудын баталгааг гаргуулах нөхцөл бүрдүүлэх, улмаар эрсдэлийг багасгасан зээлийн хэрэгжилтийг хангаж, том төслүүдийг бүтээн байгуулах ажил хийдэг. Нэг үгээр хэлбэл, том төслүүдэд санхүүжүүлэх арга барилыг нь шийдэж өгөх явдал юм.

Лондоны салбарт ОХУ, Казахстан, Туркменистан, Азербайжан орныг хариуцаж ажилладаг тухай дээр хэлсэн. Манай банкнаас санхүүжүүлсэн төслүүдийг дурдвал, 670 гаруй сая ам.долларын өртөгтэй Москвагийн Шереметьевогийн онгоцны буудлын шинэ D терминал төсөл, ADNOC (Abu Dhabi National Oil Company)-д гурван тэрбум ам.долларын зээлээр шинэ технологи, нефть боловсруулах үйлдвэр зэрэг болно.

-Том төслүүдээ хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт авахын тулд монголчууд ямар арга хэмжээ авах ёстой вэ. Гаднын орнуудын туршлагаас хуваалцана уу?

-Манай орны томоохон төслүүдийг санхүүжүүлэх сонирхолтой гадаадын хөрөнгө оруулалтын банк олон байна. Гэхдээ шийдвэрлэх ёстой асуудлууд байгаа нь анзаарагдсан. Манай төр, засгийн түшээд гадаадын хөрөнгө оруулагч банк “Цаанаа ямар санаа агуулж байна” гэж болгоомжилж, төслүүдийн явцыг удаашруулдаг тал харагдаж байна. Дэлхийд нэртэй банкууд хариуцлагаа сайтар ухамсарладаг тул тухайн төслийг маш богино хугацаанд шийдэж, хамтын ажиллагааг урагшлуулахыг хичээдэг. Манай төрийн түшээд ямар нэг хоосон зүйлд эргэлзэлгүйгээр асуудлыг шуурхай шийдэж ажиллах хэрэгтэй юм шиг санагдсан. Миний бодлоор Азербайжан, Туркменистан зэрэг улс том төслүүдийнхээ санхүүжилт болоод хэрэгжилтийг маш шуурхай шийдчихдэг юм билээ. Нэг бодлын шийдвэр гаргагч цөөн байх нь төслийн хэрэгжилтийг хурдасгадаг. ОХУ-д ч мөн адил, Ерөнхийлөгч В.Путиний удирдлага дор олон том төслийг мэргэжлийн хэмжээнд маш хурдан шийдвэрлэн хөгжиж байна.

> Дэлхийд нэртэй банкууд хариуцлагаа сайтар ухамсарладаг тул тухайн төслийг маш богино хугацаанд шийдэж, хамтын ажиллагааг урагшлуулахыг хичээдэг. Манай төрийн түшээд ямар нэг хоосон зүйлд эргэлзэлгүйгээр асуудлыг шуурхай шийдэж ажиллах хэрэгтэй юм шиг санагдсан.

-Өмнө нь SMBC банкны мэргэжилтнүүдийг дагуулан Монголд хэд хэдэн удаа ирж байсан гэсэн. Энэ удаад нэг сар болохдоо ямар өөрчлөлтийг анзаарав?

-Монгол Улс маань хөгжих замдаа орсныг харж байна, хотод ч, хөдөөд ч адил. Гэхдээ асуудлууд байгаа нь мэдээж. Нийслэлд орчин үеийн өндөр барилгууд нь хуучныхтайгаа нэг дор шаваараалдан байгаа нь Улаанбаатар хотыг сайхан харагдуулахгүй байна. Чөлөөтэй амьсгалах орон зай дутагдаж байна гэх үү дээ. Агаарын бохирдол бол байнгын асуудал байх. Жаахан эмх цэгцтэй, соёлоо гээхгүйгээр хөгжөөсэй гэж боддог.

Замбараагүй байдал зөвхөн дэд бүтэц, зам тээвэр, компаниудын засаглал, хууль зүй, банкны системд биш, хаа сайгүй л байгаа юм уу даа. Гэхдээ хууль, эрх зүйн орчныг сайжруулах, зам тээвэр, санхүүгийн системийг шинэчлэх талд Англи, Японы туршлагыг нэвтрүүлж байгаа гэж сонссон. Энэ бол сайн хэрэг.

-SMBC-гийн Лондон дахь салбарт хэзээнээс ажиллаж эхэлсэн бэ. Шалгуур өндөр байсан уу?

-2008 оноос хойш Лондоны салбарт ажиллаж байна. Энэ банкинд ажиллах гол шалгуурт нь санхүүгийн мэргэжлээс гадна хэлний мэдлэг чухал. ОХУ, Зүүн Европыг хариуцан ажиллахад орос, чех хэл маань тусалсан. Дэлхийн санхүүгийн томоохон төв Лондонд Европын орнуудын залуус ажиллахаар зорьдог нь өрсөлдөөн бий болгодог.

-Лондонд эх орноо сурталчилсан олон арга хэмжээ зохион байгуулдаг гэж сонссон. Тэдгээрээсээ дурдахгүй юу?

-Гадаад ертөнцөд Монголыг сонирхогч хүмүүс олон байдаг нь надад таалагддаг. Лондон хотноо Монголын уул уурхайн нэг өдрийн семинар зохион байгуулахаар зарлахад Англиин 200 орчим уул уурхай болон санхүүгийн мэргэжилтнүүд богино хугацаанд цугларахад их гайхсан л даа. Тэр үед Монгол Улсаа сурталчлах арга хэмжээг системтэй зохион байгуулахад төр, засгаас анхаарах нь зүйтэй юм байна гэж бодсон. Монголд олон төсөл буй ч хэрэгжүүлэх арга барил дутагдаж байна. ■

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

ХУВЬЦААГ ХЯМДХАН ГАРГАХ АРГА ЗАМ



IPO буюу анхдагч зах зээлд хувьцаа гаргах үйл явц нь тухайн компанийн хувьд хөрөнгө, зардал ихээр шаардсан үйл ажиллагаа юм. АНУ-ын брокер, дилерийн компаниуд хувьцаа гаргахад зориулсан тогтсон ханштай байдаг. Энэ нь тухайн хувьцааны борлуулалтаас олох ашгийн 5-7 хувьтай тэнцүү. Хэрэв хувьцааны үнэлгээг дутуу хийвэл 10-15 хувийг нь мөн л зарцуулахаас аргагүй болдог байна. Иймээс олон компанийн эзэд энэхүү эрсдлээс сэргийлэхийн тулд өөр арга зам эрэлхийлдэг аж. Тухайлбал, компаниуд өөр хоорондоо нэгдэж, эсхүл өөр компани худалдан авдаг (Merger and Acquisition – M&A).

Сүүлийн үед Америкт зарим компани хувьцаа гаргах зардлаа бууруулах үүднээс хөрөнгө оруулагч болон брокерийн пүүстэй “Татварын гэрээ” (Tax Receivables Agreement – TRA) байгуулж эхэлжээ. Гэрээний нөхцөл ёсоор тухайн хувьцааг борлуулагч брокерийн пүүс нь хувьцааг гаргаснаас хойш 15 хүртэлх жилийн хугацаанд татвараас чөлөөлөгдөх, татварын хөнгөлөлт эдлэх зэрэг урамшуулалтай юм байна. Мөн хувьцааг гаргахад зарцуулсан зардлыг дунджаар гурав дахин нугалсантай тэнцүү ашиг олох боломжтой аж. Өдгөө энэ гэрээ нь хөрөнгө оруулалтын тэргүүлэгч банкуудын гол хэрэгсэл болжээ. Түүнчлэн хувьцаат компаниудын хувьд үнэт цаасаа гаргахдаа ашигладаг стандарт арга барил нь болсон байна. Энэ онд “Татварын гэрээ” байгуулж, хувьцаа амжилттай гаргасан жишээ олон байгаа аж. Гэхдээ энэ гэрээний талаар хүмүүс сайн мэдэхгүй байна. Уг гэрээг ашиглан хөрөнгийн зах зээлд ихээхэн хэмжээний ашиг, орлого олох боломжтой юм.

“Татварын гэрээ”-ний хүрээнд ямар үйл явц өрнөдгийг тайлбарлая. Хувьцаа гаргахаас өмнө брокерийн компани тухайн хувьцаат компанид зориулан татварын таатай орчныг бүрдүүлж өгнө. Энэ нь тухайн компани хувьцаа гаргасны дараах орлогын албан татварын хэмжээг бууруулах зорилготой. Үүнд төлсөн татвараа буцааж авах ч багтана. Өөрөөр хэлбэл уг гэрээ нь татварын хэмжээг урт хугацаанд тогтвортой хадгалдаг байна. Брокерийн пүүс 15 жилийн туршид төлөгдөх татварыг хэмнэснээр ашиг, орлогоо улам нэмэгдүүлэх боломжтой. Суурь татварын өсөлт (Tax Basis Step-up) хувьцаа эзэмшигч нас барсны дараа ч гэсэн үнэ цэнээ алдахгүй. Тухайлбал, Дорж гэдэг хүн өмнө нь хувьцаа худалдаж авсан гэж бодъё. Түүнийг нас барсны дараа хүү Бат нь түүний хувьцааг өвлөн авчээ. Энэ тохиолдолд уг хувьцаа Доржийн нас барсан өдрийн зах зээлийн үнэлгээг тусгасан суурь татвартай байх юм. Энэ нь хувьцааг анх худалдан авахад төлж байсан үнийн дүнгээс өөр байна. Иймээс тохиолдолд хувьцааны татварын үндэслэл дээшээ чиглэсэн байна. Бат хувьцаагаа яаралтай зарж борлуулах шаардлагатай болсон ч тэрбээр орлогын албан татвар төлөхгүй аж. Яагаад гэвэл суурь татвар өндөртэй байсан учраас. Нөгөө талаас Бат тухайн хувьцаанаас орлого хүртээгүйтэй нь холбоотой юм.

Татвар төлөх гэрээг хангалттай ашигладаггүй байна. Учир нь энэ талаар хүмүүс мэддэггүй. Үүний шалтгаан нь нэгдүгээрт, бүрэн шалгагдаж, баталгаажаагүй гэсэн болгоомжлол. Хоёрдугаарт, хөрөнгө оруулагчид өөрсдийн брокеруудыг хувьцаанаас нь шударга бусаар ашиг олж байна гэж үздэгтэй холбоотой. Энэ хоёр асуудал үнэн эсэх нь өдийг хүртэл батлагдаагүй зүйл юм.

Татварын гэрээ нь хувьцааны зах зээлд сайн шалгагдаж, шалгарсан арга барил юм. Үүнд олны танил болсон томоохон үнэт цаас ч багтдаг. Хэрэв хувьцааг худалдан авагчид татварын хөнгөлөлт хүртвэл энэ нь эргээд брокеруудын хувьд хувьцаагаа өндөр үнээр борлуулах боломжийг олгодог аж. Тиймээс ч сүүлийн үед “Татварын гэрээ”-г хөрөнгийн зах зээлийн тоглогчид ихээр ашиглах болсон байна.

Дэлхийн санхүүгийн хямрал АНУ-ын хөрөнгийн зах зээлийг бараг үгүй хийсэн гэж хэлж болно. Гэсэн ч уг зах зээл дахин сэргэж байна. Үүний шалтгаан нь нэг талаас брокерийн компаниуд “Татварын гэрээ”-г хувьцаа гаргахад тохиромжтой хувилбар болгон ашиглаж буйтай холбоотой аж.

Harvard Business Review сэтгүүлээс орчуулав





Р.Эрдэнэцэцэг. Ноос самнаж байгаа нь

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ

ЭСГИЙ ЕРТӨНЦӨӨР АЯЛАХАД

Э.ЗОРИГТ

Улсын их дэлгүүрийн өмнөх талбайд зассан ганган гацуур дээр ганц нэгээр хаялах цасан ширхэг өнгө нэмэн гялтганана. Айсуй оныг зөгнөх шинэ жилийн дуу хуур их хотын хэмнэлд хөг нэмж, элдэв гоёл чимэглэл үдшийн бүрийд өнгө хоршин сүлэлдэх нь үлгэрийн мэт. Орчин тойрон үлгэрийн мэт байгаа болоод ч тэр үү, эсгий эдлэлийн “Цагаан алт” худалдааны төв рүү дөхөх тутам яагаад ч юм бэ сэтгэл догдолно.

Сэтгэл хөдлөл талаар болсонгүй. Дэлгүүрийн босгоор даваад л нэг л содон ертөнцөд яваад орчихлоо. Шинэ жилийн утга учир болсон гацуур модны мөчрийг гоёсон эсгий чимэглэлүүд нэг л өвөрмөц. Монгол хэв шинжийг хадгалсан ботго, тэмээ, өвлийн өвгөн гээд төрөл бүрийн эсгий чимэглэлүүд нь гацуур модыг амь оруулчихав уу гэлтэй. Тэр бүү хэл эсгийгээр урласан гутал, бэлэг дурсгалын зүйлс, пальто, банзал, хүрэм, малгай гээд төрөл бүрийн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн “Цагаан алт” дэлгүүрийн лангуун дээр өрөөстэй харагдана. Эсгий цамц, хүрэм гэхээр санаанд нэг л бууж өгөхгүй байсан. Гэтэл биед эвтэйхэн, дулаан гээд олон давуу талтай байдаг аж. Эсгийгээр идэх юмнаас бусдыг хийж болдог юм байна даа гэх сэтгэгдэл өөрийн эрхгүй төрж байлаа. Тус дэлгүүрээр үйлчлүүлж байсан Т.Оюун-Эрдэнэ “Шинэ жилээр Хятадын чанаргүй бүтээгдэхүүн авч байхаар дотоодын үйлдвэрлэлээ дэмжих хэрэгтэй. Миний хувьд шинэ жилийн бэлэг цуглуулаад явж байна. Эсгий бүтээгдэхүүн чанартай. Мөн эрүүл мэндэд сайн төдийгүй үнийн хувьд ч боломжийн” гэсэн юм. “Цагаан алт” дэлгүүр үйл ажиллагаагаа эхлүүлээд таван жилийг ардаа орхижээ. Норвегийн тусламжийн байгууллагын Монголд хэрэгжүүлсэн томоохон төслийн нэг хэсэг болох “Ноосны өрхийн үйлдвэрлэлийн маркетинг” сургалтад хамрагдсан хүмүүс энэ үйлдвэрлэлийг авч яваа аж.

Жилдээ 200-250 сая төгрөгийн ашигтай ажилладаг тэд »



Ноос нягтаршуулж байгаа нь



Фотог Э.Зоригт

Эсгий эдлэлийн загвар гаргаж байгаа байдал

бүтээгдэхүүнээ зөвхөн Монголдоо борлуулаад зогсохгүй Герман, Япон, Австри, Норвеги, АНУ, Англи зэрэг оронд худалдаалдаг гэнэ. Түүнчлэн олон улсын үзэсгэлэн, уралдаанд амжилттай оролцдог ажээ. Тухайлбал, ХБНГУ-д болсон “Ambient Fair” үзэсгэлэнд оролцож шагналт байранд шалгарч байсан аж. ”Ноосон зангилаа” дундын хоршооны дэлгүүрт бүтээгдэхүүнээ нийлүүлдэг анхан шатны хоршооны ажилчид маань үнэхээр чадварлаг ажээ. Олон улсад улсынхаа нэрийг гаргаж байгаа хүн ч олон бий” гэсэн. Тив дэлхийд эдгээр эсгий бүтээгдэхүүнийг хэн, хаана, хэрхэн урладаг бол гэх бодол өөрийн эрхгүй төрөх ажээ.

Чингээд “Ноосон ертөнц” анхан шатны хоршооны ажилтан Р.Эрдэнэцэцэгтэй уулзахаар Зүүн дөрвөн замыг зорилоо.

“Ноосон ертөнц” хоршооны ажлын байр нийслэлийн 14-р хорооллын 116 байрны хонгилд байдаг ажээ. Өдгөө 34 ажилчинтай уг хоршоо 2004 оноос хойш үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж ирсэн байна. Тус хоршооны нягтлан бодогч, үүсгэн байгуулагч, урлаач Р.Эрдэнэцэцэг “Норвегийн тусламжийн байгууллагын Монголд хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 2003 онд анх сургалтад суугаад нэхмэлчин болсон. Түүнээс хойш эндээ л ажиллаж байна” гэсэн юм. Р.Эрдэнэцэцэг өмнөх нийгмийн үед Хөдөө аж ахуйн материал техникийн хангамжийн газарт агуулахын нярав хийдэг байжээ. Ардчилсан нийгэмд шилжээд удалгүй албан байгууллага нь хувьчлагдаж, ажилгүй болсон аж. 2000 он хүртэл наймаачин, тогооч, барилгачин гээд олон зүйл хийж үзжээ. Польш улс руу явж хар бор ажил ч хийсэн байна. Тэгээд 2002 онд Монголдоо иртэл түүнийг голоод ажилд аваагүй. Тэрбээр “Ажилгүй нэг жил амьдарна гэдэг миний хувьд 10 жил шиг л урт байсан даа. Ажил хайж яваад энэ хоршоо байгуулагдах гэж байгааг сонсоод нэхмэлчний 21 хоногийн сургалтад хамрагдсан нь миний хамгийн том аз болсон” гэв. Ер нь “Ноосон ертөнц” хоршоонд ажилладаг ажилчдын олонх нь өрх толгойлсон эмэгтэй, дунджаас доогуур орлоготой иргэд байдаг аж. Өдгөө тус хоршооныхон эсгийнээс гадна ангоран ноолууранр нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг нь бусдаасаа онцлог. 10 гаруй нэрийн бүтээгдэхүүнтэй. Ноосон ороолт бээлий, эсгий чимэглэл, гэрийн шаахай гээд ихэнх бүтээгдэхүүнээ Герман, Япон зэрэг орон руу бага багаар экспортолдог ажээ.

Ноосноос эсгий хүртэл

Хийц эдэлгээ нь хаана ч гологдохгүй. Экспортод гаргах бүтээгдэхvvн болдог эсгий эдлэлийг хэрхэн хийдэг талаар цухас дурдъя. “Говь”, “Гоёо” зэрэг үйлдвэрээс авсан боловсруулсан ноосыг эргэн тойрондоо битүү шүдтэй хоёр дугуй хүрдийн завсраар хийн эргүүлэхэд тэр нь аяндаа хавтан хэлбэртэй хуйлмал үүсгэх нь сонихон. Онгорхой цоорхой, нимгэн газарт нь ноосоо нэмж, давхарлаж мөн л түүнийгээ эргүүлсээр ноосон хавтанг үүсгэнэ. Үүнийг ноос самнах гэнэ. Энэ нь нэг ёсны ноосоо савж буй хэрэг аж. Хоёроос гурван удаа ингэж самнаснаар ноосны хог арилж, хөнгөн сэвсгэр, нэгэн жигд болдог ажээ. Үүнийхээ дараа ноосоо өргөн ширээн дээр зулна. Хийх гэж буй зүйлээсээ хамааранд хоёроос найм хүртэл давхарлаж зулаад савантай усаар булхдаг аж. Үүнийхээ дараа хийх гэж байгаа эдлэлээсээ хамааранд ноосоо илнэ. Бэлэг дурсгалын, гацуур модны чимэг зэрэг жижиг зүйл хийх бол дан эсгий байхад л хангалттай. Харин эсгий шаахай, цүнх хийх бол нэлээд давхарлаж байж, чанартай эд болдог ажээ. “Цагаан алт”-ыг гэмтээхгүйн тулд нимгэн самбай тавиад байн байн савандан илж эсгийрүүлдэг аж. Ингэж саванддагийн учир нь үйлдвэрийн аргаар боловсруулсан ноосны зунгаг нь арилчихаад байдагтай холбоотой. Ингэхээр тослог нь үгүй болж, барьцалдах чадвараа алддаг гэнэ. Тиймээс савангаар ноосны зунгагыг орлуулдаг гэж хэлж болох юм. Энэ үйлдлийг олон дахин хийх тусам эсгийний чанар сайжирдаг аж. Р.Эрдэнэцэцэг “Ингэж илэхэд гарын арьс зулгарах юу ч биш. Ямар ч машин ашигладаггүй. Тиймээс тухайн эсгийгээр хийсэн хувцас, эдлэл хэрэглэл нь хүний биеийг загатнуулахгүй, харшил өгдөггүй. Тийм болоод ч тэр үү, гаднынхан эсгий эдлэлийг авахдаа дуртай. Ер нь гаднын хэрэглэгчид автомат машинаар хийсэн бүтээгдэхүүнээс илүү хүний гараар хийсэн бараа бүтээгдэхүүнийг их сонирхдог юм билээ. Ойрд шинэ жилийн чимэглэлийн захиалга ихтэй байна” гэсэн юм. Улмаар илж эсгийрүүлсэн эсгийгээ бүлээн усаар шавшиж, норгоод “өлгийдөнө”. Үүнийхээ дараа эсгийгээ ялимгүй хатаагаад нухаж гарна. Энэ нь Монгол уламжлалын дагуу савсан ноосыг морь, тэмээгээр чирж хийдэгтэй адил зүйл аж. Эсгийг хэдий чинээ эргүүлнэ төдий чинээ хатуурч, чанар нь сайжирна. Ингээд бэлэн болсон эсгийгээ хатаагаад л цамц, малгай, шинэ жилийн чимэглэл гээд төрөл бүрийн бүтээгдэхүүн хийх эд бэлэн болдог ажээ.

Загварын дагуу ширж, зурж, будаж, оёж эцсийн бүтээгдэхүүн бий болдог ажээ. Энэ олон шат дамжлагыг давж эцсийн бүтээгдэхүүн бий болоход

бүтэн хоёр өдөр хэрэгтэй. Бэлэн болсон бүтээгдэхүүнээ “Цагаан алт” дэлгүүрт өгч борлуулна.

Шинэ жилээр ээждээ хайртай гэж хэлээд үнсэнэ

Ноосны ертөнцөөр аялж байх



хооронд 40 эргэм насны дуу чангатай бүсгүй үйлдвэрт ороод ирлээ. Энэ бүсгүйг С.Найданхүү гэдэг аж. Түүнтэй цөөн хором ярилцлаа.

-Та “Ноосон ертөнц” хоршоонд ажилладаг юм уу?

-Үгүй ээ. Харин миний ээж Сэржмядаг ажилладаг юм. Би хийсэн бүтээгдэхүүнийг нь л энд авчирч өгдөг юм. Манай ээж юм нэхэж мөнгө олдог юм. Намайг гурван хүүхэдтэй минь тэжээж байгаа хүн бол миний ээж. Үнэнийг хэлэхэд бид ээжийгээ шимэгч хэлбэрээр амьдарч байгаа хүн. Дээрээс нь нэг дүлий дүү маань ээж дээр хоёр хүүхдээ дагуулаад хүрээд ирсэн. Сүүлийн нэг жил ээж маань өөрөөсөө гадна долоон хүн тэжээж байна даа. Миний хувьд ээждээ тусалдаг.

-Та ямар мэргэжилтэй вэ?

-Эгч нь уг нь барилгачин. Уг нь ч эгч нь хоёр гурван жилийн өмнө угаагч ч болов хийгээд мөнгө олоод байдаг байлаа. Архичин нөхөртөө зодуулаад хоёр жил ээжийнхээ дэргэд өвчтэй хэвтлээ. Одоо нөхрөөсөө салсан. Бие дээрдэж байгаа болохоор ямар ч хамаагүй ажил хийнэ дээ.

-Танай гэр хаана байдаг юм бэ?

-Шар хадны эцэст. Тэндээс сая алхаж ирлээ. Ээжийн хийсэн зүйл ойрд зарагдаагүй болоолтой. Мөнгө байдаггүй. Бид чинь энэ хоршооны буянд л хоолтой байдаг улс. Сард 3-4 алчуур дэлгүүрт өгдөг. Нэг алчуур 30-40 мянган төгрөгтэй. Алчуур зарагдахгүй л бол бид хоосон хононо.

-Та тэтгэмжийн мөнгө авдаг уу?

-Хүүхдийн мөнгө авдаг. Харин группын мөнгө өгөхгүй ээ. Тархины хаван, судасны нарийсалт чинь группын мөнгөнд ордоггүй юм билээ. Охиныгоо Хөдөө аж ахуйн их сургуульд оруулна.

-Таны ирээдүйн зорилго юу вэ?

-Том охиноо ирэх жил Хөдөө аж ахуйн дээд сургуульд оруулна. Одоогоор төлбөр мөнгийг бэлдээгүй л байна. Ёстой нөгөө тэнэгийн дотор уужуу л гэдэг шиг явж байна. Гэхдээ одооноос бие сайжирч байгаа болохоор энэ хоршоондоо ажиллах санаатай байна. Аль юм болгонд муу ээжийгээ шаналгаж амьдрах вэ дээ. Дээрээс нь миний мөрөөдөл бол хөдөө гарч амьдрах. Ногоо тариад л амьдарна даа. Дараа жилээс хөдөө гарна. Ютай ч хэдэн хүүхдийнхээ сургууль соёлын асуудлыг шийдэх хэрэгтэй байна. Улсаас өгч байгаа 0.7 га газраа Төв аймгаас авсан. Надад зөндөө гоё бодол байгаа. Байгальд ээлтэй учраас мод үржүүлнэ. Манай хүүхдэд миний олгосон нэг хүмүүжил байдаг. Цэцэг ногоо тарьдаг. Шар хадны тэр хавьд намагтай болохоор мод ургадаггүй юм билээ. Харин манай хүүхдүүд манай дүүгийнд тарьсан мод өндөөр ургасан байсан.



Эсгийгээр хийсэн бүтээгдэхүүн

Ирээдүйд эгч нь гоё амьдарна.

-Удахгүй болох шинэ жилийн баярыг хэрхэн тэмдэглэх гэж байна вэ?

-Хэдэн хүүхдүүддээ махтай хоол хийж өгнө дөө. Толгой цувдай байнга идээд уйддаг байлгүй хөөрхийс. Муу ээжийгээ сайхан амраах юмсан даа. Сохолзоод л юм оёод байгаа. Энэ завшааныг тохиолдуулаад ээждээ хайртай шүү гээд хэлэх гэсэн юм аа. Ер нь хүн гэдэг чинь хүний хүнд л хайртай гээд байхаас ээждээ хайртай гэж хэлдэггүй юм билээ. Тиймээс энэ шинэ жилээр ээждээ хайртай гэж хэлээд хацар дээр нь үнсэнэ дээ. Одоогоор шинэ жилийн баяраар миний хийж чадах зүйл ердөө л энэ байна. Гэхдээ ажил хийгээд дараа жилийн шинэ жилийн баярыг нижгэр тэмдэглэнэ дээ.

Түүний утас дуугарч ээж нь дуудаж байгаа болоолтой. Гэр рүүгээ алхаж харих тул эртхэн гарах хэрэгтэй гээд тэрбээр яаран гарч одлоо.

Сайн явахад садаа мундахгүй

Хэдийгээр эсгийгээр гоё зүйл олныг хийж болох ч тэр бүр нийтэд танигдахдаа тааруу байгаа аж. Учир нь тэдэнд тулгараад буй хамгийн том бэрхшээл нь бүтээгдэхүүний үнэ. Тухайлбал, үйлдвэрлэгчийн гар дээрээс 12-15 мянган төгрөгөөр гарсан гэрийн шаахай дэлгүүрт очихдоо 20-25 мянган төгрөгийн үнэтэй болчихдог гэнэ. Учир нь дэлгүүр болон хоршооны ашгийг нэмээд тээвэрлэлтийн болон зарагдах хүртэлх зардлыг тооцохоор ийм үнэтэй болчихдог аж. Гэтэл

өнөөдөр 20-25 мянган төгрөгөөр гэрийн шаахай авах хүн хэр олон билээ. Анхан шатны хоршоонд ажилладаг үйлдвэрлэгчид нь ихэвчлэн дундаас доогуур орлоготой иргэд байдаг. Тиймээс урласан бүтээгдэхүүн нь хэзээ зарагдана. Тэр үед л мөнгөтэй, хоолтой залгана. Р.Эрдэнэцэцэг “Надтай адилхан өрх толгойлсон эмэгтэйчүүд гэр бүлээ тэжээх гээд хөлс хүчээ шавхаад л байдаг. Гэтэл бүтээгдэхүүний үнэ бидэнд ямар ч ашиггүй байна. Түүхий эдийн үнэ нийт өртгийн 40 хувийг эзэлдэг. Ажлын цагийн хөлс, ашиг нэмээд үнээ тогтоодог. Гэхдээ бидэнд ашгаа нэмж зарах боломж байхгүй” гэв. Зарим талаар гар урлалын бүтээгдэхүүний үнийг тогтооход бэрх. Манай хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ цагийн 1060 төгрөг байдаг. Гэтэл хөлс хүчээ шавхаж, ямар ч хүний биед хоргүй эсгий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 5-10 цаг зарцуулдаг. Тиймээс бүтээгдэхүүн дунджаар 10-15 мянган төгрөгийн үнэтэй болдог. Гэхдээ энэ нь тийм ч хангалттай үнэлэмж биш аж. Дээрээс нь шинэ жилийн чимэглэл, түлхүүрийн оосор хүүхдийн тоглоом хийхэд цаг хугацаа нарийн ажиллагаа их шаарддаг хэдий боловч үнийн хувьд харьцангуй хямд байдаг ажээ. Нөгөө цагийн хөлсөөрөө ч тооцож чаддаггүй байна. Гэсэн хэдий ч Хятадаас орж ирж байгаа ижил төрлийн чанар муутай бүтээгдэхүүнээс нэг, хоёр дахин үнэтэй болчихоор борлуулалт нь муудчихдаг. Дээрээс нь түүхий эдийнх нь үнэ сүүлийн хэдэн жил хоёр дахин нэмэгджээ. Анх таван мянган төгрөгөөр авдаг байсан нэг килограмм утас 18 мянган төгрөг болтлоо нэмэгджээ. Мөн нэг килограмм нь 25 мянган төгрөгөөр авдаг байсан тэмээний ноос өнөөдөр 50 гаруй мянган төгрөгийн үнэтэй болчихсон байна. Гэтэл үйлдвэрлэгчид маань үнээ нэмж болдоггүй. Дээрээс нь төрөөс авдаг татаас улам л нэмэгдээд байгаа аж. Тухайлбал, тэднээс албан байгууллагын тарифаар дулаан, цахилгаан, хогны мөнгө авна. “Ноосон ертөнц” хоршоонд ажилладаг 72 настай Ц.Адъяатовуу “Бид чинь ар гэрээ тэжээх гээд л явж байгаа хүмүүс шүү дээ. Ямар тийм том компани



Хоршооны ажилтан Ц.Адъяатовуу

биш. Бидний хувьд эсгий хаягдалгүй технологи гэж явдаг. Хоршоологчдын хувьд грамм ноос ч үнэ цэнэтэй. Эндээс үйлдвэрлэлийн зориулалттай ямар ч хог гарахгүй. Ахуйн чанартай л хог гардаг. Гэтэл хогны мөнгө гэж 15 мянган төгрөг тушаадаг байсан бол гэнэтхэн л 30 мянган төгрөг болгоод өсгөчихсөн. Энэ байрны хонгилын сарын түрээс 100 мянган төгрөг. Цахилгаан дулааны төлбөрийг нь бас албан байгууллагын журмаар авна. Бид сүүлийн хоёр сарын мөнгөө төлж чадаагүй байна. Яах вэ төр биднээс Орлогын албан татвар авдаггүй. Энэ л бидний хувьд төрөөс харж үзсэн хамгийн том хөнгөлөлт. Гэхдээ бусад талаараа бидний нуруун дээр ачаа их байна” гэсэн юм.

Жинхэнэ үйлдвэрлэгч


Хоршоологчдын хувьд жинхэнэ экспортлогчид гэж хэлж болохоор. Түүхий эдээ дотоодоосоо хангачихна. Бүтээгдэхүүнээ 100 хувь өөрсдөө үйлдвэрлэнэ. Түүнийгээ олон улсад гаргачихна. Ер нь өрхийн үйлдвэрлэл, хоршоо нэрийн дор үйлдвэрлэл эрхэлж, бүтээгдэхүүнээ экспортод гаргадаг нь олон. Тиймээс тэднийг нэгтгэж дэмжих нь нэг талаар монголчуудын экспортлогч болох мөрөөдлийг биелүүлж болох. Эсгийгээр урлагчид шиг дотоодоосоо түүхий эдээ хангаад өөрсдөө өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь жинхэнэ үйлдвэрлэгч юм. Адаглаад шинэ жилийн баяр дөхөж байгаа энэ үед гацуур модоо дотооддоо үйлдвэрлэсэн эсгий чимэглэлээр гоёж яагаад болохгүй гэж. Нэг эсгий чимэглэл өнгө үзэмжээсээ хамаараад 1500-10 000 төгрөг хүртэлх үнэтэй байдаг юм билээ. Уг нь үнийг нь буулгах боломжтой. Гэтэл түүхий эдийнх нь үнэ тэнгэрт хадчихсан, болсон болоогүй татаас ихтэй учраас тэд үнээ буулгах боломжгүй ээ. Дотоодын түүхий эд нь үнэтэй болохоор бусад үйлдвэрлэгчид Хятадаас үйлдвэрийн аргаар хийсэн бэлэн, хямдхан эсгий худалдан авч бүтээгдэхүүн хийх нь элбэг болжээ. Гэтэл тэр нь хялгас ихтэй байдаг тул хүний биед харшил үүсгэдэг байна. Мөн монгол хүний ур, ухаанаар хийсэн эсгийнээс чанарын хувьд хэдэн хувь муу байдаг аж. Дээрээс нь “Ноосон зангилаа” дундын хоршооны харъяа 10 хоршоо нь бүгдээрээ орон сууцны хонгилд үйлдвэрлэлээ эрхэлдэг. Тиймээс тэднийг ажлын байр болон хямд өртөгтэй дотоодын түүхий эдээр нь хангах тал дээр төрөөс дэмжээд өгвөл хоршоологчид Монголын зэх зээлийг хангаад байх боломжтой юм билээ. ■

ТЕХНОЛОГИ

ХЭВШЛИЙГ ХЭТ ЭВДЭХ ХӨГЖЛИЙН 10 ТААМАГ

Б.БЯМБАДОРЖ

2018 оноос 3D хэвлэх технологи нь жил бүр 100 тэрбум ам.долларын оюуны өмчийн хохирол учруулна.



Ямар нэг хийсэн бүтээлийн загварыг дахин хувилахын тулд хүмүүс буцааж задлах, эсвэл их хэмжээний судалгаа явуулна. Харин 3D технологиор тус загварыг дахин гаргах боломжтой. Тийм үед хүмүүс өөрсдийн бүтээлийн загварыг хэрхэн хамгаалах вэ?

Өнөөдөр 3D хэвлэх нь олон нийтэд хүртэж хараахан энгийн хэрэглээний түвшинд очоогүй байна. Харин ирээдүйд ийм технологиор "зэвсэглэсэн" мэргэжлийн, мэргэжлийн бус хүмүүс бусад материал, бүтээл, загварыг дууриах зорилгоор ашиглана гэж таамаглаж байна.

2016 он гэхэд хүний эрхтнийг хувилах нь дэлхийг доргиосон томоохон шуугиан тарина. Энэ үед хүний эрхтэн хувилах технологи дээр хязгаарлалт тавих, хувилахыг олон улсын хуулиар хязгаарлах эсвэл бүрмөсөн хориглох үгүйг олон нийтээр хэлэлцэж шийднэ.

Хүний эрхтэн хувилах ойлголт олон арван жил яригдсан. Энэ нь өнөөдрийн байдлаар зүгээр нэг ойлголт биш, бодит болоод байна. Хэд хэдэн компани хүний эрхтэн хувилах туршилтууд эхэлсэн байгаа. Тухайлбал, АНУ –ын Сан Диего мужийн "Органова" компани өнгөрсөн оны гуравдугаар сард хүний элгийг амжилттай хувилж чаджээ. Тус компани нь эрхтний эс сэргээх туршилт хийдэг юм. Эднийх Бостон хотын "Туршилтын био-технологийн чуулга уулзалт" дээр өөрийн хувилсан элгийг "Үйл ажиллагааны хувьд энгийн элэгний үүргийг биелүүлж чадсан" хэмээн танилцуулжээ.

Энэ нь дэлхий дахинд юу сануулж байна вэ? Хэдхэн жилийн дараа хаа нэг газар хэн нэг нь хүний эрхтэн хувилах "үйлчилгээг" үзүүлээд эхлэхэд гайхах юмгүй боллоо. Бид үүнд хэрхэн хандах бол? Хэв журмын, ёс зүйн, зан заншлын болон шашин шүтлэгийн маш олон маргаан үүсгэнэ.

Жишээ нь хувилсан эрхтний алдаа дутагдал, эрсдэлийг яг хэн, ямар маягаар хүлээх вэ? Зарим нэг шашин нь хүнийг, эсвэл хүний эрхтэнг тэр чигээр нь хувилах гэдэг нь бурхны "бүтээлтэй" адил гэж үздэг. Иймд тус компани юу хийх ёстой вэ? Био-технологийн "*Fiercebiotech*" цахим хуудас товчхондоо "Бэлтгэл ажлыг нь маш сайн хийх хэрэгтэй" гэв. Хүний эрхтэн хувилах тал дээр олон улсад хүлээн зөвшөөрөгдөх хууль санаачилж, технологи, үйлчлүүлэгч зэрэг хамаатай зүйлсийг ойлгомжтой тодорхойлох, мөн хувилах хил хязгаарыг сайн тогтоож өгөх хэрэгтэй гэж цахим хуудаст санал болгожээ.

2017 он гэхэд үйлдвэрлэгчдийн 75 хувь нь шинэлэг санаагаа олон нийтийн оролцоон дээр суурилж гаргана.



Эрэлт дээр үндэслэж нийлүүлэлт үүсдэг. Харин шинэлэг санааг нийлүүлэхийн тулд өнөөдөр зарим компани интернэт, хурал гэх мэт олон нийтийн цуглаж ярилцдаг газруудыг түшиглэдэг.

2017 онд компаниуд олон нийтийн ярилцлагыг автоматаар дүгнэж, шинэлэг санаанууд шүүж авах технологийг бүтээнэ гэж *"enterpriseefficiency"* сайт харж байна. Үүгээр ч барахгүй үйлдвэрлэгчдийн 75 хувь нь шинэ санаагаа олон нийтийн оролцоон дээр бүрэн түшиглэнэ гэж таамаглажээ.

2017 он гэхэд үйлчлүүлэгчийд 80 хувь нь хувийн мэдээллээ цуглуулж, ашгийнхаа төлөө "арилжаалж" эхэлнэ.

Хүмүүсийн хувийн мэдээлэл нь төрийн байгууллага, компаниудын хувьд их сонирхолтой зүйл. Саяхан Эдварт Сноуден гэхэд л АНУ маш олон хүмүүсийг нууцаар тагнадаг байсныг олон нийтэд ил гаргасан. Өөрөөр хэлбэл бид хувийн компаниудаас гадна төрөөс хувийн мэдээллээ нууж, хянах шаардлагатай гэсэн ойлголт гарч ирлээ.

Хувийн компаниуд хоорондоо хүмүүсийн хувийн мэдээллийг солилцдог. Удахгүй үйлчлүүлэгчид үүнийг нягт хянаж, мэдээллээ хэрхэн хэнд өгч хариуд нь юу шаардахаа өөрсдөө мэддэг цаг ирэх нь.

Бид өнөөдөр ийм алхмыг ямар нэг байдлаар хийж байгаа. Өөрийн цахим шуудан, овог нэрийг өгч ямар нэг газарт бүртгүүлэх, зарим үйлчилгээг авах зэрэг жишээнүүд байна. Харин ирээдүйд энэ нь "арилжааны" шинэ түвшинд гарах юм.

2020 он гэхэд олон улсын байгууллагууд засгийн газрууд нууц баримт бичгийнхээ 75 хувийг дэлгэнэ.

Нууц баримт бичгүүд сүүлийн үед их цацагдах болов. АНУ –ын байлдагч Брадли Маннинг наймдугаар сард тийм хэргээр эх орноосоо урвалаа гэж 35 жилийн ял сонслоо. АНУ –ын нууцыг задалж гутаасан Эдварт Сноуден одоо ОХУ –д дүрвэгчийн байдалтай байна. Манай улсын Сангийн сайд асан Сангажавын Баярцогт хүртэл нэг "золгүй" явдалд өртөөд Монгол Улсын Их Хурлын дэд даргын тушаалаасаа огцорсон.

Харин энэ бүхний үр дүнд байгууллага, банк, улс орнууд бүгд нууцлалтай баримт бичгүүдээ чамбайлан нуухад хүргэж байна.

Мэдээлэл технологийн судалгаа хийдэг АНУ –ын *Gartner* компани нь 2020 он гэхэд байгууллагууд ба баримт бичгүүдийн нууцлалыг дахин зэрэглэнэ гэж таамаглав. Энэ нь эдийн засаг, ил тод байдлын төлөө хийх ажил гэнэ. Мөн ард түмний итгэлийг авах алхам гэж үзэж байгаа юм.

2020 он гэхэд шинэ технологи сэхээтнүүдийн ажлын зорилгод их хэмжээгээр нөлөөлнө.



Аж үйлдвэрийн түүхэнд биеийн хүчний ажлыг машин тоног төхөөрөмж их хэмжээгээр орлох боллоо. Харин өнөөдөр технологийн хувьсал цагаан гартнуудын ажлыг ч тогтворгүй болгож байна.

Тодруулбал компьютерийн хиймэл ухаан өдрөөс өдөрт шинэчлэгдэж байгаа. Бидний сайн мэдэх iPhone утасны 4S загвараас дээших утаснууд нь Siri хэмээх автоматаар хүнд хариулдаг, утасны үйлдэл хийдэг программтай. *"The Atlantic"* сэтгүүл тус программыг хиймэл оюун ухааны эхлэл гэж нэрлэсэн байдаг.

Хиймэл оюун ухааны ойлгох чадвар, технологи нь өдрөөс өдөрт сайжирч цагаан гартнуудыг түгшээх нэгэн шалтгаан болж байгаа юм. Учир нь тэд өнөөдөр бидэнд зөвлөгөө өгч, маргааш бидэндтэй хамтарч, ирээдүйд биднийг орлох "аюултай" технологи гэж *Gartner* таамаглажээ. Энэ нь нийгмийн тогтворгүй байдал үүсгэх үү, үгүй юү гэдэг нь чухал асуулт юм.

Хүний оролцоог технологи хэт их орлосноос болж 2020 он гэхэд нийгмийн тогтворгүй байдал үүснэ. Энэ үед өнөөдрийн өндөр хөгжилтэй орнууд ажиллах хүчиндээ чиглэсэн өөр загвар санаачлах болно.

Энэ таамаг нь хоёр ойлголт дээр үндэслэж байна. Эхнийх өнөөдөр хүмүүсийн хийж байгаа ажлуудыг 2020 он гэхэд автоматаар хийж эхлэх нь олон. Нөгөөх нь энэ шалтгаанаас болж ажилгүй болсон хүмүүст тэр хэмжээний хурдаар шинэ ажил олгох боломжгүй юм.

Эхний ойлголтыг тодотгох амархан: бидний технологийн хөгжлийн сүүлийн 60 – 70 жилийг харахад ойлгомжтой. Энэ таамгийг дэвшүүлэх хоёр дахь шалтгаан нь 2010 онд эхэлсэн “Арабын хавар” хөдөлгөөн, олон улсад “халдварласан” *Occupy Wall Street* хөдөлгөөн зэргийг ажилгүйдлийн түвшнээс үүдэлтэй гэж тайлбарладаг.

Дэлхийн хүн ам өсч байгаа, мөн технологи өдрөөс өдөрт шинэчлэгдэж байна. Өөрөөр хэлбэл, ирээдүйд автоматжуулах технологиос үүдэлтэй ажилгүй болсон тэр их олон хүнд шинэ ажил олж өгөх бүрэн боломжтой юу?

Бичил төхөөрөмжүүдээс авсан мэдээлэл 2020 он гэхэд дэлхийн 1000 том компанийн орлогыг таван хувиар бууруулна

Мэдээлэл дамжуулдаг бичил төхөөрөмж гэдэг нь интернетэд холбогддог биедээ авч явах хэмжээний жижиг төхөөрөмжүүд юм (энгийн жишээ: гар утас). Таамаг №4 дээр хүмүүс мэдээллээ байгууллага, Засгийн газруудтай “арилжаалж” эхэлнэ гэсэн. Харин одоо үүний улмаас дэлхийн топ 1000 компани буюу Глобал 1000 –ын орлого таваас багагүй хувиар буурна гэж үзэж байна.

Энэхүү таамгийн үндэс нь өнөөдрийн олон тоогоор үйлдвэрлэгдэж байгаа мэдээлэл дамжуулах төхөөрөмжүүд юм. Уг төхөөрөмжүүдийн тусламжтайгаар тэдний үйлдвэрлэгчид маш их хэмжээний мэдээлэл авах боломжтой. Жишээлбэл хэрэглэгч Дорж нь даваа гаригийн бага үдэд хаана, юу хийж байсан зэрэг мэдээллийг авах юм.

Харин өнөөдөр Монголд бараг хүн бүр гар утастай. Өөрөөр хэлбэл хүн бүр ямар нэг газарт тодорхой хэмжээний мэдээлэл байнга өгч байна гэсэн үг юм.


Энэ бүх мэдээллийг тухайн газар яах вэ? Нэг таамаг нь тус мэдээлэл дээр үндэслэж хүмүүсийн сонирхлыг тодорхойлж хүн бүрт таарсан реклам, зар сурталчилгааг гар утсаар нь дамжуулж болох юм. Иймд хүмүүс Глобал 1000 –аас өөр компаниудтай харьцах харилцаа ихсэж, томоохон компаниудын орлого буурна гэх таамаг байна.

2024 онд хүний амь эрсдүүлж үйл ажиллагаануудын 10 хувь нь хүний амь аврах “ухаантай систем” шаардлагатай болно.

Ихэнх машин ослоос сэргийлсэн ABS тормостой үйлдвэрлэгддэг болсон. Гэхдээ энэ тормосыг зарим газар – ялангуяа Хойд Америк, Европын холбооны орнуудад заавал шаарддаггүй. Тэгж хуульчилж журамлаагүй. ABS тормос зэрэг нь хүний амь эрсдэхээс сэргийлж, хүнийг “өөрөөс нь хамгаалдаг” онцлогтой. Иймд удалгүй иймэрхүү хамгаалалтын технологийг дэлхий даяараа албан журмаар шаардах цаг ирэх юм байна.

Харин энэ нь уг технологийн нөлөөнд амьдарч байгаа хүмүүст ямар өөрчлөлт үзүүлэх вэ? ABS тормос нь цаг дээрээ тулахаар биднээс ухаантай үйлдэл хийдэг. Зарим зүйл дээр бид өөрсдийгөө санаснаараа хамгаалах чадваргүй байдаг нь үнэн. Харин иймэрхүү төхөөрөмжүүд бидний тийм чадварт хэзээ ч сургахгүй байх гэж бодогдуулах юм.

2017 он гэхэд компьютерүүдийн 10 хувь нь байгаа мэдээллийг боловсруулах бус, харин шинэ зүйл сурах үйлдэл хийнэ.



“Сурах” гэдэг нь оюун ухаантай нягт холбоотой зүйл юм. Өнөөгхүртэл компьютер, хиймэл оюун ухаанаар буюу хүмүүсийн өгөгдлийн дагуу ажиллаж ирсэн. Харин 2017 он гэхэд шинээр сурах чадвартай болж, ер нь бүх автомат төхөөрөмжүүдийн ядаж 10 хувь нь ийм хандлагатай болно гэж *Gartner* таамаглаж байна.

Одоо бид энэ өөрчлөлтүүд эерэгээр, эсвэл сөргөөр нөлөөлөх үү гэдгийг л таамаглах үлдлээ. ■


Мэдээллийн нэгдсэн сан гэж юу вэ? « Шинэ үйлчилгээг танилцуулж байна. «

IKH KHARANGA

* Logo3s.mn
* Reclam6s.mn
* Mobile web
* Application Reclam6s
  /App store, Playstore/
* Реклам мэдээллийн сан
* Media сурталчилгаа



LOGO3S.MN



Эрж хайсан зүйлээ

RECLAM6S

application - ээс

1. ВИДЕО РЕКЛАМ
2. ФОТО ТАНИЛЦУУЛГА
3. ТЕХТ ЗАР /УРСДАГ/

»

TOUCHSCREEN TV
Медиа сурталчилгаа

RECLAM6S.MN
MOBILE WEB





Медиа сурталчилгаа



